



ДАЛАЙД ГАРЦГҮЙ ХӨГЖИЖ БҮЙ
ОРНУУДЫН АСУУДЛААРХ НЭГДСЭН
ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН
ГУРАВДУГААР БАГА ХУРАЛ
АВАЗА, 2025

ДАЛАЙД ГАРЦГҮЙ ХӨГЖИЖ
БҮЙ ОРНУУДЫН

2024-2034 ОНЫ АВАЗАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР



Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын 2024-2034 оны Авазагийн Үйл ажиллагааны
хөтөлбөрийн олон талт хэлэлцээ амжилттай өндөрлөв.
НҮБ-ийн төв байр, Нью-Йорк хот, 2024 оны 6 дугаар сарын 3-ны өдөр.

Зүүн гар талаас ДГХБО-ын бүлгийн дарга Ботсван Улсаас НҮБ-д суугаа Байнгын
төлөөлөгч, Элчин сайд Г. Мохава, хэлэлцээг хамтран даргалагч Монгол Улсаас НҮБ-д
суугаа Байнгын төлөөлөгч, Элчин сайд В. Энхболд, Австри Улсаас суугаа НҮБ-д суугаа
Байнгын төлөөлөгч, Элчин сайд А. Маршик, НҮБ-ын Орлогч Ерөнхий нарийн бичгийн
дарга бөгөөд НҮБ-ын Нэн буурай хөгжилтэй, Далайд гарцгүй хөгжиж буй болон Арлын
жижиг орнуудын асуудал эрхэлсэн Дээд төлөөлөгч Рабаб Фатима.

<https://www.un.org/en/landlocked/awaza-programme-action-1ldcs>

Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын 2024-2034 оны Арван жилийн Авазагийн Үйл ажиллагааны хөтөлбөр (АҮАХ)-ийг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2024 оны 12-р сарын 24-ний өдөр А/RES/79/233 тоот тогтоолоор баталсан бөгөөд АҮАХ нь далайд гарцгүй хөгжиж буй 32 орны хөгжих эрмэлзлийг дэмжихэд чиглэсэн дэлхий нийтийн шинэчлэн сайжруулсан хамтын амлалт юм.

АҮАХ нь 2014–2024 оны Венийн Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад олж мэдсэн сургамжид тулгуурлан, ялангуяа худалдааг хөнгөвчлөх, бүтцийн өөрчлөлт, тээврийн холболт, технологи, уур амьсгалын нөлөөллийг тэсвэртэй даван туулах чадвар, олон улсын дэмжлэгийг татан оролцуулах зэрэг салбарт ахиц дэвшлийг түргэтгэхийг зорьж байна.

Энэхүү зорилго нь үндэсний түвшний арга хэмжээг бүс нутгийн интеграцийн хүчин чармайлт болон дэлхийн бодлогын чиглэлтэй харилцан уялдуулж, далайд гарцгүй орнуудыг илүү эрч хүчтэй, хүртээмжтэй тогтвортой хөгжлийн замд оруулахын зэрэгцээ ирээдүйд учирч болох гэнэтийн аюул, гамшгаас хамгаалах явдал юм.

Оршил: Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг хурдасгахын тулд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын тогтвортой, уян хатан хөгжлийг эрэлхийлэх нь

1. Бид түүхэн шийдвэрлэх мөчид ирээд байна. Одоо бидний гаргах шийдвэрүүд нь Африк, Ази, Европ, Өмнөд Америкт орших, 570 гаруй сая хүн амтай, далайд гарцгүй хөгжиж буй 32 орны ирээдүйг тодорхойлно. Эдгээр орнууд тогтвортой хөгжилд хүрэх замдаа газарзүйн болон бүтцийн суурь бэрхшээлүүдтэй тулгарч байна. Үүнд далайд шууд гарах гарцгүй байдал, тээвэр, харилцаа холбооны саад тотгор, томоохон зах зээлээс алслагдсан байдал, дамжин өнгөрөх нарийн төвөгтэй журам, хангалтгүй дэд бүтэц зэрэг хамаарах бөгөөд эдгээр бэрхшээл нь урьд өмнө тохиож байгаагүй дэлхийн хэмжээний сорилт, хямралаар дамжин улам хүндэрч байна. Үүний жишээнд коронавирусийн (COVID-19) цар тахлын үр дагавар, геополитикийн хурцадмал байдал ба зөрчил мөргөлдөөн, хүнсний болон эрчим хүчний хямрал, тээвэр ба худалдааны өндөр зардал, хүүгийн өндөр түвшин, инфляц, өрийн дарамт, уур амьсгалын өөрчлөлт, биологийн төрөл зүйлийн хомсдол, цөлжилт, бохирдол зэргийг дурдаж болно.
2. Эрүүл мэндийн болон нийгэм-эдийн засгийн хямрал хувь хүн болон нийгмийг тэр чигээр нь донсолгон, үргэлжилсэн сорилтын жилүүд 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр¹ болон бүх Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх боломжид аюул учруулж байна. Дэлхий нийт ядуурал, өлсгөлөн ба тэжээлийн дутагдал, тэгш бус байдал, хүний эрхийн зөрчил, улс орнуудын доторх болон хөгжингүй ба хөгжиж буй орнуудын хоорондох дижитал хэрэглээний ялгаа, вакцины хүртээмжийн тэгш бус байдал, цогц хүмүүнлэгийн хямрал ба зэвсэгт мөргөлдөөн, аюултай байдал, цар тахал, хүрээлэн буй орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн асуудалд нэрвэгдэж байна. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хувьд

¹ Ерөнхий Ассамблейн 70/1 дугаар тогтоол.

нөхцөл байдал онцгой хүнд байна. Ийм нөхцөлд бид хамтын нөөц бололцоогоо яаралтай дайчлах, бүх түвшинд шийдэмгий арга хэмжээ авах, урьд өмнө тулгарч байгаагүй сорилтыг даван туулах шинэ, шинэлэг шийдлийг олж хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ хүрээнд бид 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр болон түүний Тогтвортой хөгжлийн зорилтуудыг гурван хэмжээсний хүрээнд тэнцвэртэй, нэгдсэн байдлаар бүрэн хэрэгжүүлэхийн төлөө тасралтгүй чармайн ажиллах тууштай үүрэг амлалтаа дахин нотолж байна. Үүнд бодит алхмууд хийх, бүх улс орнуудаас илүү их үйл ажиллагаа, онцгой арга хэмжээг шаардах, мөн далайд гарцгүй хөгжиж буй орнуудад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн олон улсын болон олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар аль нэг орныг орхигдуулахгүйгээр, хамгийн хойно үлдсэн хэсэгт эхэлж хүрэхийг чухалчилна.

3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн зорилго, зарчмууд, түүний дотор олон улсын эрх зүйг бүрэн хүндэтгэхийг бид удирдамж болгон ажиллаж байна. Энэ нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал², Олон улсын хүний эрхийн гэрээ, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мянганы тунхаглал³ болон 2005 оны Дэлхийн дээд хэмжээний үулзалтаас гарсан баримт бичиг⁴-т тулгуурласан болно. Мөн Хөгжих эрхийн тухай тунхаглал⁵ зэрэг бусад баримт бичигт суурилсан болно. Хүний эрхийг хүндэтгэх, эрх зүйт ёсыг бүх түвшинд хэрэгжүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэх, ил тод, үр нөлөөтэй, хариуцлагатай институцид тулгуурласан, шударга, хүртээмжтэй, тайван амгалан нийгмийг байгуулж, хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх боломжийг хангах шаардлагатайг бид хүлээн зөвшөөрч байна.

2 Ерөнхий Ассамблейн 217 А (III) дугаар тогтоол.

3 Ерөнхий Ассамблейн 55/2 дугаар тогтоол.

4 Ерөнхий Ассамблейн 60/1 дугаар тогтоол.

5 Ерөнхий Ассамблейн 41/128 дугаар тогтоол, хавсралт.

4. Цаашид 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр болон түүний Тогтвортой хөгжлийн зорилтуудыг бүрэн, цаг тухайд нь хэрэгжүүлэхийн төлөөх хүчин чармайлтаа нэмэгдүүлэх үүрэг амлалтаа бид дахин нотолж байна. Үүнд Хөгжлийг санхүүжүүлэх асуудлаарх олон улсын Гуравдугаар бага хурлын үеэр баталсан Аддис Абабагийн үйл ажиллагааны хөтөлбөр⁶, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Үүр амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенц⁷ болон Парисын хэлэлцээр⁸, мөн Гамшгийн эрсдэлийг бууруулах 2015–2030 оны Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг⁹ орно. Эдгээр нь ялангуяа далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хөгжлийн тусгай хэрэгцээ шаардлага болон сорилттой холбогдож байгаа болно.
5. Байгаль орчин ба хөгжлийн тухай Риогийн тунхаглалын¹⁰ бүх зарчмыг, түүний дотор ялангуяа 7 дугаар зарчимд туссан нийтлэг боловч ялгаатай хариуцлагын зарчмыг бид дахин нотолж байна.
6. 2014–2024 оны арван жилд хэрэгжсэн Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Венийн үйл ажиллагааны хөтөлбөрийн¹¹ зургаан тэргүүлэх чиглэлийн хэрэгжилтэд харилцан адилгүй ахиц дэвшил гарсныг бид тэмдэглэж байна. COVID-19 цар тахал, геополитикийн хурцадмал байдал ба зөрчил, мөн уур амьсгалын өөрчлөлтийн нийлмэл нөлөө нь энэ ахиц дэвшилд сөргөөр нөлөөлсөн юм. Мөн дэд бүтцийн санхүүжилтийн үлэмж хэмжээний дутагдал, хязгаарлагдмал мэдээлэл ба техникийн чадавх зэрэг саад нь ахиц дэвшлийг доройтуулсныг бид санаа зовнин цохон тэмдэглэж байна.

6 Ерөнхий Ассамблейн 69/313 дугаар тогтоол, хавсралт.

7 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гэрээний Цуврал, боть 1771, № 30822.

8 НҮБ-ын Үүр амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенцын дор батлагдсан (FCCC/CP/2015/10/Add.1, шийдвэр 1/CP.21).

9 Ерөнхий Ассамблейн 69/283 дугаар тогтоол, II хавсралт.

10 Байгаль орчин ба хөгжлийн тухай НҮБ-ын бага хурлын тайлан, Рио-де-Жанейро, 1992 оны 6 дугаар сарын 3–14, боть I, Хурлаас баталсан тогтоолууд (НҮБ хэвлэл, Борлуулалтын дугаар E.93.I.8 ба засвар), тогтоол 1, I хавсралт.

11 2014 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 69/137 тоот тогтоолын II хавсралт

Нэмж дурдахад, дэлхийн эдийн засгийн таагүй нөхцөл байдал нь сулхан өсөлт, инфляцын огцом өсөлт, эрчим хүч, хүнс болон санхүүгийн дарамт нэмэгдэх, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, худалдааны өндөр зардлаар тодорхойлогдож байгаа бөгөөд эдгээр нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын сэргээн босголтын хүчин чармайлтад тасралтгүй саад учруулж байна. Үүнээс гадна, далайд гарцгүй хөгжиж буй орнууд гамшигт ихээхэн нэрвэгдсэн бөгөөд эдгээрийн олонх нь уур амьсгалын өөрчлөлт, биологийн төрөл зүйлийн хомсдол болон цөлжилт, давтагдмал ган, мөнх цэвдгийн хайлалт, үер, мөсөн гол, нуурын түрлэгт үер зэрэг гамшгийн улмаас ихээхэн даамжирсан байна.

7. Венийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд гарсан ахиц дэвшил хязгаарлагдмал байсныг бид хүлээн зөвшөөрч байна. Худалдааг хөнгөвчлөх, бүс нутгийн интеграцийг дэмжих, далайд гарцгүй хөгжиж буй болон дамжин өнгөрөх орнуудын дамжин өнгөрөх, худалдааг дэмжих олон улсын конвенцод нэгдэх, нэгдмэл байдлыг сайжруулахын тулд дэд бүтцийн чанарыг сайжруулах зэрэгт хийсэн нөр их хүчин чармайлт нь бодитой үр дүнд хүргэсэн байна.
8. Гэсэн хэдий ч Венийн үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилт, зорилтуудад хүрэх ахиц дэвшил хангалтгүй байсныг бид санаа зовнин тэмдэглэж байна. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт сүл байсан бөгөөд ядуурлыг арилгах, тэгш бус байдлыг бууруулахад хангалтгүй байв. Энэ нь ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд, эмзэг бүлгийн иргэд болон албан бус салбарт ажиллагсдад илүү ихээр нөлөөлсөн байна.
9. Далайд гарцгүй хөгжиж буй орнууд бүтцийн өөрчлөлтөд хүрэх чиглэлд маш бага ахиц дэвшил гарсанд санаа зовниж байна. Мөн эдгээр орны эдийн засгийн бүтэц одоог хүртэл төрөлжилт бага хэвээр байгааг, экспорт нь нэмүү өртөг бага шингэсэн цөөн нэр төрлийн бүтээгдэхүүнд төвлөрсөн, одоо болон ирээдүйд тохиож болзошгүй гадаад орчноос үүдсэн шок, аюулд маш их өртөмтгий хэвээр байгааг бид тэмдэглэж байна. Авто зам, төмөр зам, усан болон агаарын тээврийн дэд бүтэц, мөн далайн боомт, тэнгисийн боомтуудыг холбох дэд бүтэц

бүрэн хөгжөөгүй, хоорондоо бүрэн холбогдоогүй, санхүүжилт дутмаг, засвар үйлчилгээ хангалтгүй хэвээр байна.

10. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын дэлхийн барааны экспортод эзлэх хувь 2022 оны түвшинд ердөө 1.1 хувь, дэлхий нийтэд авч үзвэл өчүүхэн хэмжээтэй хэвээр байгаад бид санаа зовниж байна. Гэсэн хэдий ч эдгээр орнуудын дунд бүс нутгийн интеграци ба хамтын ажиллагааны сонирхол нэмэгдсэн байна. Далайд гарцгүй хөгжиж буй орон тус бүрийн бүс нутгийн худалдааны хэлэлцээрийн тоо 2014 онд дундаж 3.3 байсан бол 2023 онд 4.3 болж өсжээ.
11. Албан ёсны хөгжлийн тусламж болон худалдааны тусламжийг далайд гарцгүй хөгжиж буй орнуудад хуваарилах чиглэлээр тодорхой ахиц дэвшил гарсан ч, гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал буурч, ихэвчлэн байгалийн нөөцөд төвлөрснийг бид санаа зовнин тэмдэглэж байна. Үүнээс гадна, далайд гарцгүй хөгжиж буй олон орон өрийн дарамтад орсон эсхүл өндөр эрсдэлтэй байдалд байна.
12. Дэлхийн эдийн засгийн орчныг технологи хурдтай өөрчилж байгааг бид тэмдэглэж байна. Энэ нь ажлын үйл явц, үйлдвэрлэл, түгээлтийн арга барил, хэрэглээний хэв маягийг шинэчилж байна. Шинэ инновацыг урамшуулж, өсөлтийн шинэ боломжийг бий болгож байна. Мөн эдгээр нь улс доторх болон улс хоорондын дижитал хэрэглээний ялгаа, ялангуяа хүйсийн дижитал хэрэглээний тэгш бус байдлыг бууруулах, хүртээмжтэй тогтвортой хөгжилд ахиц дэвшлийг түргэсгэх боломжийг олгож байна. Хэдийгээр онцгой боломжууд байсан ч, далайд гарцгүй хөгжиж буй орнууд үүнийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна. Үүнд дэд бүтцийн хоцрогдол, мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний өндөр өртөг, дижитал технологи ашиглах түвшин доогуур байх, зохицуулалтын хүрээ хангалтгүй, далайн гүний кабельд нэвтрэх өртөг өндөр зэрэг хүчин зүйлс саад болж байна.
13. Хэрэгжилтийн хугацаанд дамжин өнгөрөх асуудлыг дэмжих тухай бүс нутгийн, дэд бүсийн болон олон талт санаачилгууд эрчимтэй хөгжсөнийг бид хүлээн зөвшөөрч байна. Холбогдох

эрх зүйн гэрээ, хэлэлцээрийг баталгаажуулах чиглэлд ахиц гарсан юм. Дамжин өнгөрөх асуудлыг сайжруулах аргачлал болох Дэлхийн Гаалийн Байгууллагын дамжин өнгөрөх асуудлаар удирдамж, тээврийн цахим бичиг, цахим TIR зэрэг баримт бичгийг боловсруулсан байна. Зорчих хугацааг бууруулах Венийн үйл ажиллагааны хөтөлбөрийн тодорхой зорилтын хүрээнд зарим тээврийн коридорт ахиц дэвшил гарсан байна.

14. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын дэд бүтцийн хоорондын холболтыг сайжруулах зорилгоор дэд бүтцийн чанарыг ерөнхийд нь сайжруулах чиглэлд тодорхой ахиц гарсан ч сорилтууд хэвээр байгааг бид мөн тэмдэглэж байна. Хэрэгжилтийн хугацаанд хэд хэдэн хурдны замын сүлжээ болон төмөр замын шугам ашиглалтад орсон ч, цаашид илүү олон төсөл шаардлагатай хэвээр байна.
15. Венийн үйл ажиллагааны хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэхэд саад болсон сорилтуудыг бид хүлээн зөвшөөрч байна. Үүнд: хэрэгжүүлэх арга хэрэгслийн байнгын дутагдал, санхүүгийн боломжит дэд бүтцийн төслийг боловсруулах чадавхын хомсдол, албан ёсны хөгжлийн тусламжийн урсгал бага, хөрөнгө оруулалтын урсгал байгалийн нөөцөд төвлөрөх, өрийн өндөр эмзэг байдал болон COVID-19 цар тахал зэрэг олон улсын хэмжээний давагдсан хямралууд нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудад харьцангуй хүнд нөлөөлсөн зэрэг болно.
16. Далайд хүрэх, далайгаас гарах бүх төрлийн тээврийн хэрэгслээр саадгүй, үр ашигтай, зардал багатай нэвтрэх боломжийг дамжин өнгөрөх эрх чөлөөний зарчим болон холбогдох олон улсын эрх зүйн дүрэм журмын дагуу хангахын чухлыг бид дахин нотолж байна. Худалдааны гүйлгээний болон тээврийн зардлыг бууруулах, хангалттай дамжин өнгөрөх тээврийн дэд бүтцийн сүлжээг хөгжүүлэхийн чухлыг мөн дахин тэмдэглэн дурдаж байна. Бүтцийн өөрчлөлт, нэмүү өртөг шингээх, аж үйлдвэржилт болон төрөлжилтийн ач холбогдлыг бид хүлээн зөвшөөрч байна.

17. Шударга, тэгш эрхийг хангасан олон талт худалдааны системд тулгуурласан олон улсын худалдаан дахь оролцоогоо нэмэгдүүлэх нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлтөд болон Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтойг бид цохон тэмдэглэж байна. Тээврийн коридорууд нь гол боомтууд болон төвүүдийг холбосон тээврийн сүлжээний тулгуур бүтэц бөгөөд эдгээр нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын зах зээлтэй холбогдох чадварыг нэмэгдүүлэх, үр ашигтай дамжин өнгөрөх нөхцөлийг хангах, тээврийн зардлыг бууруулахад чухал ач холбогдолтой.
18. Бүх нийтийн хүртээмжтэй, тэгш чанартай боловсрол, үр чадварын сургалтаар дамжуулан хүний нөөцийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтын чухлыг бид мөн хүлээн зөвшөөрч байна. Ялангуяа эмзэг нөхцөлд байгаа хүмүүсийг хамруулан боловсрол олгох нь нэн чухал. Ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийн үр нөлөөтэй арга хэмжээг хэрэгжүүлэхэд шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик (STEM)-ийн чанартай боловсрол болон институцийн чадавхын хөгжил далайд гарцгүй хөгжиж буй орнуудад чухал ач холбогдолтойг бид хүлээн зөвшөөрч байна.
19. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад олон чиглэлээр илүү өргөн хүрээтэй техникийн тусламж, чадавх бэхжүүлэхэд дэмжлэг шаардлагатайг бид хүлээн зөвшөөрч байна. Үүнд: холбогдох бүс нутгийн хэлэлцээрт үр ашигтайгаар нэгдэх, соёрхон батлах, хэрэгжүүлэх; хөрөнгө оруулалт татахуйц төслийг боловсруулах; зорилтот аж үйлдвэрийн бодлого хэрэгжүүлэх; хөдөө аж ахуйг аж үйлдвэржүүлэх; үйлдвэрлэл, экспортын баазыг төрөлжүүлэх; инновацыг дэмжих болон технологийг илүү өргөн ашиглах, нутагшуулах; дотоодын нөөцийн татан төвлөрүүлэлтийг бэхжүүлэх; хууль бус мөнгөн урсгалыг мэдэгдэхүйц бууруулах; хөрөнгө оруулалтын таатай орчныг сайжруулах зэрэг орно.
20. Жендерийн ялгаа бүх салбарт, тэр дундаа хөрөнгө, үйлчилгээний хүртээмжийн хувьд ч хэвээр байгаад бид санаа зовниж байна. Жендерийн тэгш байдлыг хангах, бүх

эмэгтэйчүүд, охидын эрх мэдлийг нэмэгдүүлэх нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудад бүх Тогтвортой хөгжлийн зорилт, зорилтуудын хэрэгжилтэд шийдвэрлэх хувь нэмэр оруулахыг бид дахин нотолж байна. Бүх эмэгтэйчүүд, охидын чадавхыг дэмжих хүчин чармайлтад хөрөнгө оруулж, хууль эрх зүйн, нийгмийн болон эдийн засгийн бүх саадыг арилгах нь нэн тулгамдаж буйг бид онцолж байна.

21. Хоёр тал, олон талт болон олон оролцогч талуудын нягт түншлэлийн хамтын ажиллагааны чухлыг бид хүлээн зөвшөөрч, судлаачид, иргэний нийгэм, хувийн хэвшилтэй хамтран ажиллаж, инновацад түшиглэн тулгамдсан хөгжлийн сорилтод шийдэл олох, Тогтвортой хөгжлийн зорилтууд болон Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн төлөө, ил тод, үр нөлөөтэй, хариуцлагатай төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамтран ажиллахаа амлаж байна.
22. Далайд гарцгүй хөгжиж буй орнууд бүтцийн хязгаарлалтаас гадна газарзүйн байрлалтай холбоотойгоор хөгжлөө дэмжихийн тулд нэмэлт хүчин чармайлт, тэр дундаа нэмэлт зээл авах шаардлагатай байдаг бөгөөд энэ нь тэдний санхүүгийн орон зайд нөлөөлж, цаашлаад тогтвортой хөгжлийг дэмжихэд шаардлагатай бодлогын орон зайг хязгаарлаж байгааг бид хүлээн зөвшөөрч байна. Ийм нөхцөл байдал нь хөгжлийг санхүүжүүлэхэд хүндрэл үүсгэж, эдгээр орны онцлогт тохирсон хариу арга хэмжээ, шийдлийг шаардаж байна.
23. Иймд, энэхүү Үйл ажиллагааны хөтөлбөр нь далайд гарцгүй хөгжиж буй орнууд, дамжин өнгөрүүлэгч орнууд, хөгжлийн түншүүд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын системийн байгууллагууд, олон улс, бүс нутаг, дэд бүс нутгийн байгууллагууд, олон талт болон бүс нутгийн хөгжлийн банкууд зэрэг олон улсын хамтын нийгэмлэгийн бүгдийнх нь шинэчилж, сайжруулсан хамтын үүрэг амлалтыг тодорхойлж байгаа юм. Энэ нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын газарзүйн хязгаарлалтаас үүдэн бий болсон тусгай хөгжлийн хэрэгцээ, эмзэг байдал, сорилтыг илүү нэгдмэл байдлаар шийдвэрлэх, тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийн түвшнийг

нэмэгдүүлэх, олон улсын худалдаанд идэвхтэй оролцох, бүх хэлбэр, хэмжээнд нь ядуурлыг устгахад хувь нэмэр оруулах өргөн цар хүрээтэй зорилтуудад суурилж байна. Энэ нь хэрэгжилтийн арга хэрэгслийг өргөтгөж дэлхий нийтийн түншлэлийг бэхжүүлэх үндсэн дээр олон оролцогч талын түншлэлийн хамгийн өргөн хэмжээнд эвсэл байгуулж, далайд гарцгүй хөгжиж буй орнуудад төрөл бүрийн дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжинэ. Мөн гамшгийн эрсдэлийг харгалзан үзсэн тогтвортой хөгжлийн хандлагыг орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон дэлхийн түвшинд дэмжиж, бодлого, хөтөлбөр, хөрөнгө оруулалтад гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг бүх түвшинд нэгтгэх үйл явцыг түргэтгэнэ.

24. Энэхүү Үйл ажиллагааны хөтөлбөр нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хувьд иж бүрэн, үр дүнд чиглэсэн, тоон үзүүлэлтэд суурилсан, ирээдүйд чиглэсэн, уялдаа холбоотой, шинэчлэгдсэн дэлхийн түншлэл дээр тулгуурлаж байгааг бид онцолж байна. Энэ нь 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр болон Тогтвортой хөгжлийн зорилтууд, Аддис Абабагийн үйл ажиллагааны хөтөлбөр, Сендайн үйл ажиллагааны хүрээ, Парисын хэлэлцээртэй бүрэн уялдсан бөгөөд далайд гарцгүй хөгжиж буй орнууд, дамжин өнгөрөх орнууд, тэдгээрийн хөгжлийн түншүүд, холбогдох олон улсын болон бүс нутгийн байгууллагууд, хувийн хэвшил, иргэний нийгэм болон бусад холбогдох оролцогч талуудын хамтын ажиллагаанд түшиглэж байна.
25. Иймд Бага хүрлын “Түншлэлээр дамжуулан ахиц дэвшлийг урагшлуулах нь” сэдэв нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын энэхүү Үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилт, зорилтуудад хүрэхэд хамгийн бодитой, найдвартай арга замыг тодорхойлж байгааг бид онцолж байна.
26. Далайд гарцгүй хөгжиж буй орнууд, дамжин өнгөрөх орнууд, тэдний хөгжлийн түншүүд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын системийн байгууллагууд болон бусад холбогдох оролцогч талуудыг энэхүү Үйл ажиллагааны хөтөлбөрт тодорхойлсон таван тэргүүлэх чиглэлийн хүрээнд тохиролцсон холбогдох арга хэмжээнүүдийг үндэснийхээ тэргүүлэх чиглэлтэй

уялдуулан, зохицуулалттай, нэгдсэн, шуурхай байдлаар хэрэгжүүлэхийг бид уриалж байна. Мөн НҮБ-ын системийн холбогдох байгууллага, хороод, түүнчлэн олон улсын болон бүс нутаг, дэд бүс нутгийн байгууллагуудыг энэхүү Үйл ажиллагааны хөтөлбөрийг өөрсдийн хөтөлбөр, үйл ажиллагаандаа холбогдох чиг үүргийн дагуу нэгтгэхийг бид уриалж байна.

27. Далайд гарцгүй хөгжиж буй болон дамжин өнгөрөх орнуудын түншлэл нь дэд бүтцийн холболтыг сайжруулах, тээвэр, гааль, логистикийн системийн техникийн болон удирдлагын зохицуулалтыг байнга сайжруулахад харилцан ашигтайг бид онцолж байна. Үр ашигтай дамжин өнгөрөх тээврийн систем, олон төрлийн тээврийн дэд бүтцийн хөгжүүлэлт, уялдаа холбоог бэхжүүлэх хамтын хүчин чармайлт, таатай эрх зүйн орчин, институцийн зохицуулалтыг дэмжих, дамжин өнгөрөх болон далайд гарцгүй орнуудын хамтын ажиллагаанд үндэсний манлайллыг хүчтэй хэрэгжүүлэх нь бүтцийн өөрчлөлт, тогтвортой эдийн засгийн өсөлт, хөгжилд хүрэхэд шийдвэрлэх ач холбогдолтой.
28. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хөгжлийн өмчлөл, манлайлал, анхдагч хариуцлага нь өөрсдийнх нь үндэсний эдийн засаг, хөгжлийн бодлого, стратегиар илэрхийлэгдэж байгааг бид тэмдэглэж байна. Гэсэн хэдий ч бид далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хөгжил зөвхөн тэднээс өөрсдөөс нь хамаарахаас гадна олон улсын хамтын нийгэмлэгийн хамтын хүчин чармайлт, зайлшгүй дэмжлэг, хамтын ажиллагаа, хөгжлийн тусламжид тулгуурлаж байгааг мөн онцолж байна.
29. Энэхүү үйл ажиллагааны хөтөлбөрийг бүрэн дүүрэн, цаг тухайд нь хэрэгжүүлэхэд хөгжлийн түншүүдтэй өрнүүлэх шинэчлэгдсэн, бэхжүүлсэн түншлэл чухал болохыг бид дахин нотолж байна. Санхүүгийн болон хөгжлийн байгууллагууд, олон талт байгууллагууд, агентлагууд, хөгжлийн түнш орнуудыг хамарсан олон улсын хамтын нийгэмлэгийг энд дурдсан тодорхой зорилтуудыг урагшлуулахын тулд хангалттай санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлэхийг бид уриалж байна. Бүс нутгийн болон дэд бүсийн хамтын

ажиллагаа, интеграци нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын тодорхой асуудлыг амжилттай шийдвэрлэхэд мөн чухал үүрэгтэй оролцох шаардлагатай.

30. Олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны үүргийг, ялангуяа "Хойд-Өмнөд"-ийн хамтын ажиллагааны чухлыг онцолж тогтвортой хөгжлийн үндсэн хөдөлгөгч хүч хэвээр байгааг бид тэмдэглэж байна. Чингэхдээ "Өмнөд-Өмнөд" болон гурвалсан хамтын ажиллагааны хүрээнд харилцан тохиролцсон хамтын ажиллагааны салбарт хувь нэмэр оруулах нь чухал бөгөөд "Хойд-Өмнөд"-ийн хамтын ажиллагааг орлох бус, харин нөхөх шинжтэйг тэмдэглэн сайшааж байна.
31. Эдийн засаг, улс төр, соёлын харилцаа бүхий түвшинд бүс нутгийн урт хугацааны хөгжил цэцэглэл, тогтвортой байдал, энх тайванд хувь нэмэр оруулж байгааг бид тэмдэглэж байна.
32. Ард түмнийг, ялангуяа далайд гарцгүй хөгжиж буй орнуудад зонхилж буй залуу болон ажиллах хүчний насны хүн амыг хөгжлийн чухал нөөц хөрөнгө гэж бид үзэж байна. 2024–2034 оны хооронд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хүн ам 135 саяар нэмэгдэж, 726 саяд хүрнэ гэж тооцоолж байна. Залуучууд нь үнэлж баршгүй, олон дахин үр өгөөж өгөх үнэ цэнтэй хөрөнгө бөгөөд тэдэнд хөрөнгө оруулах нь чухал юм.
33. Хэнийг ч үл орхигдуулах тогтвортой ирээдүйг бүх хүнд хүртээмжтэйгээр хангах бодлого, хөтөлбөрийг тодорхойлж, хэрэгжүүлэхэд Засгийн газруудын үүрэг маш чухал гэдгийг бид онцлон тэмдэглэж байна. Үндэсний парламентууд хууль тогтоомж батлах, бүх хүнд үйлчлэх төсвийг батлах замаар "хэнийг ч үл орхигдуулах" зорилгод чухал хувь нэмэр оруулах ёстой.
34. Энэхүү үйл ажиллагааны хөтөлбөр нь дараах таван тэргүүлэх чиглэлтэй байна:
 - Тэргүүлэх чиглэл 1: Бүтцийн өөрчлөлт болон шинжлэх ухаан, технологи, инновац
 - Тэргүүлэх чиглэл 2: Худалдаа, худалдааг хөнгөвчлөх болон бүс нутгийн интеграци

- Тэргүүлэх чиглэл 3: Дамжин өнгөрөх асуудал, тээвэр ба холболт
 - Тэргүүлэх чиглэл 4: Дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх, уур амьсгалын нөлөөллийг тэсвэртэй даван туулах чадварыг бэхжүүлэх, уур амьсгалын өөрчлөлт ба гамшгийн эмзэг байдлыг бууруулах
 - Тэргүүлэх чиглэл 5: Хэрэгжилтийн арга хэрэгсэл
35. Эдгээр чиглэл дэх амлалтыг хэрэгжүүлэх үйл явцыг хэрэгжилт, хяналт-шинжилгээ, дагаж мөрдөхөд чиглэсэн нэмэлт тусгай арга хэмжээгээр дэмжинэ.

Тэргүүлэх чиглэл 1: Бүтцийн өөрчлөлт ба шинжлэх ухаан, технологи, инновац

36. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын тогтвортой хөгжлийн замд нь томоохон бүтцийн саад тотгорууд тулгарч байгааг бид хүлээн зөвшөөрч байна. Үүнд үйлдвэрлэлийн болон нийлүүлэлтийн чадавх сул, шинжлэх ухаан, технологи, инновацад ахиц дэвшил хангалтгүй байгаа зэрэг орно.
37. Далайд гарцгүй хөгжиж буй олон орон эдийн засгийн төрөлжилтөд хангалттай амжилт гаргаж чадаагүй, цөөн тооны бараа бүтээгдэхүүнээс хэт хамааралтай хэвээр, түүнчлэн бүс нутгийн болон дэлхийн нэмүү өртгийн сүлжээний доод түвшинд байгаад бид санаа зовниж байна.
38. COVID-19 цар тахал ба түүний урт хугацааны үр дагавар, уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн зарим хэсэгт гарч буй геополитикийн хурцадмал байдал, зөрчил мөргөлдөөн зэрэг олон төрлийн дэлхийн нийтийг хамарсан хямрал нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудад хамгийн хүндээр туссан бөгөөд энэ нь тэдний бүтцийн өөрчлөлт болон Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх явцыг нь сааруулсан болохыг бид санаа зовнин тэмдэглэж байна.
39. Бүтцийн өөрчлөлтөд эдийн засгийн төрөлжилтийг нэнт тэргүүнд тавьж, ялангуяа нэмүү өртөг шингээх, аж үйлдвэржилтийг дэмжих, шинжлэх ухаан, технологи, инновацийн хүчийг ашиглах нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын өвөрмөц сорилтыг

даван туулах, өнөөгийн болон ирээдүйд тохиож болзошгүй эрсдэл, аюулыг тэсвэрлэх чадавхыг бий болгох, хөгжлийн эрмэлзэлдээ хүрэхэд шийдвэрлэх ач холбогдолтойг бид хүлээн зөвшөөрч байна.

I. Үйлдвэрлэлийн чадавхыг хөгжүүлэх

40. Далайд гарцгүй хөгжиж буй олон орны үйлдвэрлэлийн чадавх сул хэвээр байгаа нь салбар хооронд технологийн шилжилт хийх, үр ашигтай үйлдвэрлэл эрхлэх, эдийн засгаа төрөлжүүлэх, тогтвортой ажлын байр бий болгох чадамжийг хязгаарлаж байгааг бид хүлээн зөвшөөрч байна.
41. Тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдал, шим тэжээл болон хүнсний стандартыг хангах нь ядуурлыг бүх түвшинд нь арилгах гол элемент болохыг бид онцолж байна.
42. Хөдөө аж ахуй нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын эдийн засгийн тулгуур хэвээр байгаа бөгөөд тэдгээрийн дотоодын нийт бүтээгдэхүүний дунджаар 17 хувь, ажиллах хүчний ойролцоогоор 55 хувийг бүрдүүлж байгааг бид хүлээн зөвшөөрч байна. Гэвч энэ салбар нь чанартай, найдвартай, тогтвортой, тэсвэртэй дэд бүтцийн хүртээмжийн дутмаг байдал, нийлүүлэлтийн сүлжээ сул хөгжсөн, нэмүү өртөг багатай, орчин үеийн технологид нэвтрэх боломж дутмаг байдлаас шалтгаалан бага бүтээмжтэй, эмзэг, албан бүс хэв шинж давамгайлсан хэвээр байна.
43. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын үйлчилгээний салбар нь бага нэмүү өртөгтэй үйл ажиллагаанд төвлөрсөн, мэдлэгт суурилсан үйлчилгээ хангалтгүй хэвээр байгаад бид мөн санаа зовниж байна.
44. Бүх төрлийн үйлдвэрлэлийн чадавхыг ашиглахад цаашид хүний нөөцийн хөгжлийг бэхжүүлэх нь шийдвэрлэх хүчин зүйл болохыг бид цохон тэмдэглэж байна. Далайд гарцгүй хөгжиж буй орнууд иргэдийнхээ, ялангуяа эмэгтэйчүүд, залуучуудын чанартай боловсрол, сургалт, үр чадварын хөгжилд илүү их дэмжлэг авах шаардлагатай байна. Энэ нь хөдөлмөрийн

бүтээмжийг сайжруулах, өсөн нэмэгдэж буй ур чадварын хэрэгцээг хангахад чухал ач холбогдолтой.

45. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад үйлдвэрлэлийн чадавхыг цаашид хөгжүүлэхэд хөгжлийн түншүүдийн дэмжлэгийг нэмэгдүүлэх шаардлагатайг бид хүлээн зөвшөөрч байна. Үүнд шинжлэх ухаан, технологи, инновац, хөдөлмөрийн бүтээмж, бизнесийн чадавх, салбар, аж ахуйн нэгж, фермийн мэргэшил, хөрөнгө ба нөөц хуримтлал зэрэг хамаарна.
46. Бүтээлч эдийн засгийн жинхэнэ үнэ цэнийг хүлээн зөвшөөрүүлэхийн тулд дотоодын болон олон улсын түвшинд авч хэрэгжүүлж буй дэмжлэгийн арга хэмжээг баталгаажуулах шаардлагатай бөгөөд энэ нь Тогтвортой Хөгжлийн 2030 он хүртэлх Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүх улс оронд, түүний дотор далайд гарцгүй хөгжиж буй орнуудад чухал ач холбогдолтойг бид мөн хүлээн зөвшөөрч байна.
47. Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн хэв маягийг бий болгох нэг зам нь тойрог эдийн засгийн хандлагыг хэрэгжүүлэх явдал болохыг бид хүлээн зөвшөөрч байна. Түүнчлэн тойрог эдийн засгийн арга, хог хаягдлыг бууруулах санаачилгуудыг урамшуулах нь уур амьсгалын өөрчлөлт, биологийн төрөл зүйлсийн хомсдол, газрын доройтол, усны хомсдол, бохирдол болон хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад хувь нэмэр оруулж, Тогтвортой Хөгжлийн 2030 он хүртэлх Хөтөлбөр болон бусад олон улсын хүрээнд тохиролцсон байгаль орчны зорилтуудад хүрэхэд дэмжлэг болно.

Зорилтууд:

- 2034 он гэхэд далайд гарцгүй хөгжиж буй орнуудад, ялангуяа эмэгтэйчүүд, залуучуудыг түлхүү хамруулсан үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуйн бүх салбарын хөдөлмөрийн бүтээмж, зохистой хөдөлмөр эрхлэх боломжийг 50 хувиар нэмэгдүүлэх.
- Үйлчилгээний салбарын гарцыг 2034 он гэхэд хоёр дахин өсгөх, ялангуяа аялал жуулчлал болон өндөр бүтээмж, мэдлэгт суурилсан салбаруудад, тэдгээрийн эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх.

- Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх хүчин чармайлтыг дэмжих бүс нутгийн хөдөө аж ахуйн судалгааны төвүүдийг зөвхөн сайн дурын санхүүжилтээр байгуулах.
- Хүн бүрийн хүртээмжтэй, тэгш, чанартай боловсрол, сургалт, ур чадварын хөгжилд илүү их хүртээмжийг хангах, ялангуяа шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик (STEM)-ийн боловсролыг өргөжүүлэх, дижитал хэрэглээний ялгаа, тэр дундаа хүйсийн дижитал хэрэглээний ялгааг арилгах.
- Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад тогтвортой хөгжлийн төлөө дижитал шилжилтийг жигд хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтот технологийн болон санхүүгийн дэмжлэг, чадавх бэхжүүлэхийг дэмжих.

Бид дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг амлаж байна:

48. Бүтцийн өөрчлөлт, зохистой хөдөлмөр эрхлэлт, төрөлжилт, нэмүү өртөг шингээлт, үйлдвэрлэлийн үр ашиг ба өрсөлдөх чадварыг дэмжих үндэсний стратеги боловсруулах ажлыг урамшуулах, дэмжихээ бид амлаж байна. Үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбаруудад чиглэсэн эдгээр стратегид бүх оролцогч талуудын санхүүгийн болон техникийн дэмжлэгийг нэмэгдүүлэхийг уриалж байна.
49. Хүн ам зүйн давуу талыг ашиглах, технологийн хоцрогдлыг арилгах, хүний чадавх ба ур чадварыг бэхжүүлэх, бүтцийн өөрчлөлтийг урагшлуулахын тулд боловсрол, сургалтад олон улсын хамтын ажиллагааг багтаасан төрийн болон хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийг бид уриалж байна.
50. Үндэсний болон бүс нутгийн түвшинд ур чадвар хөгжүүлэх, сургалтын хөтөлбөрүүдийг уялдуулах шаардлагатай арга хэмжээг авахаа бид амлаж байна. Засгийн газар, бизнесийн байгууллага, боловсролын байгууллага болон бусад оролцогч талуудын хамтын ажиллагааг өргөжүүлэхийн тулд бүс нутгийн болон дэлхийн сүлжээний платформуудыг ашиглана.
51. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад хөдөө орон нутгийн дэд бүтэц, судалгаа, хөгжүүлэлтэд илүү их хөрөнгө оруулалт хийх,

тогтвортой хөдөө аж ахуйн орчин үеийн арга технологийг түргэвчилсэн байдлаар нэвтрүүлэх, орцын илүү үр дүнтэй хэрэглээг хангах, зээлийн болон даатгалын механизмуудын хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна.

52. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн чадавх, бүтээмж, хүнсний аюулгүй байдлыг тогтвортой нэмэгдүүлэхэд илүү их хүчин чармайлт гаргахыг уриалж байна.
53. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад агро-экологи болон бусад шинэлэг арга, тогтвортой технологийг ашиглах замаар хөдөө аж ахуйн судалгаа, тогтвортой инновацын туршлагыг нэвтрүүлэх байдлыг сайжруулахаа бид амлаж байна.
54. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад бүтцийн саад тотгорыг шийдвэрлэх, хөдөө аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэх, нэмүү өртөг бий болгох, чадавх бэхжүүлэх, хөдөө аж ахуйн аргуудыг сайжруулахын тулд бүс нутгийн хөдөө аж ахуйн судалгааны төвүүдийг байгуулах боломжийг судлахаа бид амлаж байна. Бид Ерөнхий нарийн бичгийн даргад ийм төвүүдийг ажиллуулах боломж, үр нөлөө, захиргааны зохицуулалтын талаар судалж, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 80 дугаар чуулганд тайлагнахыг хүсэж байна.
55. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг институцийн болон хүний нөөцийн чадавх бий болгох, мэдлэгийн менежментийг дэмжих замаар аж үйлдвэрийн төрөлжилт, нэмүү өртөг бий болгоход таатай бодлогын орчин бүрдүүлэхийг дэмжихийг уриалж байна. Мөн үйлдвэрлэлийн түвшин, чиг хандлагыг илүү сайн ойлгох, бүтээмжийн өөрчлөлтийг дэмжих бодлогыг илүү сайн боловсруулахын тулд чанартай, цаг тухайд нь, найдвартай, ангилсан өгөгдөл мэдээлэл цуглуулахыг бид дэмжиж байна.
56. Шинэлэг шийдэл, бизнес эрхлэлтийг урамшуулах, үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарт (аялал жуулчлал, мэдээлэл, харилцаа холбоо, санхүүгийн үйлчилгээ зэрэг) орчин үеийн, тогтвортой, зардал багатай технологи, туршлагыг ашиглахыг бид дэмжиж байна.

57. Бүтээлч эдийн засгийг эдийн засгийн бодлого, үндэсний болон олон улсын хөгжлийн төлөвлөгөө, стратегид нэгтгэхийг бид дэмжиж байна. Бид тогтвортой хөгжлийн гурван хэмжээсний хүрээнд бүтээлч эдийн засгаар дамжуулан тогтвортой хөгжилд хүрэхэд шинэ тутам болон, шинээр түрэн гарч буй технологиуд, тухайлбал хиймэл оюун ухааны боломж, эрсдэл, сорилтыг үнэлэх, судлах, судлан нээх ажлыг дэмжинэ.
58. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг үндэсний нөхцөл байдал, чадавхыг харгалзан үндэсний болон бүс нутгийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тойрог эдийн засгийн хандлагыг нэгтгэж, тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлд хувь нэмэр оруулахыг бид уриалж байна.
59. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг уур амьсгалын өөрчлөлт, хатуу ширүүн цаг уурын нөхцөл, ган гачиг, үер, бусад гамшгийн нөлөөнд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх, тогтвортой бүтээмжийг дээшлүүлэх, экосистемийг хадгалах, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, бүх хэлбэрийн хоол тэжээлийн хомсдолыг бууруулахад чиглэсэн шинжлэх ухаанд суурилсан, нотолгоонд тулгуурласан, мэдээлэлд суурилсан хөдөө аж ахуйн практикийг хэрэгжүүлэхийг бид уриалж байна.
60. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад шударга зах зээлийн боломжийг бий болгох, үндэсний, бүс нутгийн болон дэлхийн нэмүү өртгийн сүлжээнд үрашигтай нэгтгэх замаар тогтвортой өсөлт, зохистой ажлын байр бий болгох, ялангуяа эмэгтэйчүүд, залуучуудын хувьд санхүүгийн үйлчилгээ, бүтээгдэхүүнд бүрэн, тэгш хүртээмжийг сайжруулахыг бид амлаж байна.
61. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад хариуцлагатай, тогтвортой хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх, нэмүү өртгийн сүлжээ болон чухал түүхий эдийн аж үйлдвэржилтэд илүү гүнзгий нэгдэн оролцохыг дэмжих замаар тэдний хэрэгцээ, өрсөлдөх чадварыг хангаж, үйлдвэрлэл, түгээлтийн сүлжээнд нэгдэхэд нь туслахаа бид амлаж байна.
62. Ашигт малтмалын нэмүү өртгийн сүлжээ, тэр дундаа чухал ашигт малтмалын хүрээнд хамтын ажиллагааг дэмжих, уул уурхайн салбарт шинэлэг хандлага, түүхий эдийн орон нутгийн

нэмүү өртөг бүтээхийг дэмжихээ бид амлаж байна. Энэ нь ядуурлыг устгах хүрээнд тогтвортой, хүртээмжтэй хөгжлийг түргэтгэхэд, тухайлбал Тогтвортой хөгжлийн 8 ба 9 дүгээр зорилтуудтай нийцэхэд тусална.

63. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад цэвэр технологийг нэвтрүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн нөлөөлөлтэй холбогдууландасан зохицох, бууруулах чадавхыг бий болгоход зориулсан хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна.

II. Хувийн хэвшлийн хөгжил

64. Идэвхтэй, байгаль орчин болон нийгмийн хариуцлагатай хувийн хэвшил нь бүтцийн өөрчлөлтөд хүрч, тогтвортой, хүртээмжтэй, шударга эдийн засгийн өсөлтөд үнэтэй хувь нэмэр оруулж чадна гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна. Энэ утгаараа шаардлагатай бодлого, зохицуулалтын хүрээг хөгжүүлэх, дэмжлэгтэй орчныг бэхжүүлэхийн чухлыг онцолж байна.
65. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын аж ахуйн нэгжийн ихэнх нь бичил, жижиг, дунд аж ахуйн нэгжүүд бөгөөд тэдгээр нь тусгай хэрэгцээ болон сорилтуудтай тулгарч байгааг бид цохон тэмдэглэж байна.
66. Бүтцийн хязгаарлалтууд, тухайлбал үйл ажиллагааны болон худалдааны өндөр зардал, санхүүгийн хүртээмжийн хомсдол, ур чадварын дутагдал, зохицуулалтын хүрээ хангалтгүй байх, институцийн чадавх сул байх, дэд бүтэц хангалтгүй хөгжсөн байдал нь эдгээр улсад идэвхтэй бизнес эрхлэлт болон хувийн хэвшлийн өсөлтөд саад болж байгааг бид онцолж байна.
67. Хувийн хэвшлийг хөгжүүлэхэд далайд гарцгүй хөгжиж буй орнууд илүү их дэмжлэг авах шаардлагатай бөгөөд шинжлэх ухаан, технологи, инновац нь гарааны бизнес, аж ахуйн нэгжүүдэд өөрсдийн бүтээмж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, үйлчилгээний салбар дахь нэмүү өртгийн сүлжээний шатанд ахих, худалдааны боломжоо нэмэгдүүлэхэд туслах боломжтойг бид хүлээн зөвшөөрч байна.

Зорилтууд:

- Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад хувийн хэвшлийг хөгжүүлэхэд таатай бизнесийн экосистемийг бэхжүүлэх.
- Эмэгтэйчүүд, залуучуудыг илүү сайн хамруулахын тулд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын бизнес эрхлэлтийн суурь баазыг өргөжүүлж, төрөлжүүлэн, хүртээмжтэй хөгжлийг түргэтгэх, үүнд чиглэсэн техникийн дэмжлэгийг багтаах.
- Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад тусгай эдийн засгийн бүс, аж үйлдвэрийн парк, инновацын төвүүд болон бусад шинэлэг санаачилгуудыг хөгжүүлэх, удирдахад санхүүгийн болон техникийн дэмжлэг туслалцаа үзүүлэх.
- Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад олборлох салбарын гэрээ хэлэлцээр байгуулахад шаардлагатай техникийн дэмжлэг үзүүлэх болон чадавхыг бэхжүүлэх.
- Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад бодлого боловсруулах, олон улсын татварын хамтын ажиллагаанд дэмжлэгийг өргөтгөх.

Бид дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг амлаж байна:

68. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад бизнес эрхлэлтийн бодлого, институцийн хүрээ, экспортын стратеги болон үндэсний бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна. Энэ нь гарааны болон бичил, жижиг, дундаж ахуйн нэгжүүд, түүний дотор эмэгтэйчүүд эзэмшдэг аж ахуйн нэгжүүдийн өсөлтийг дэмжих зорилготой. Мөн далайд гарцгүй хөгжиж буй орнуудад тогтвортой дижитал дэд бүтцийг хөгжүүлэх бодлогын арга хэмжээг боловсруулахад дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна. Үүнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хувийн хэвшил цахим худалдаа, дижитал эдийн засгаас шударга хүртээмжтэйгээр, түүний дотор бичил, жижиг, дундаж ахуйн нэгжүүд хүртэл бүрэн ашиг хүртэх боломжийг хангах зэрэг орно.
69. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад тусгай эдийн засгийн бүс, аж үйлдвэрийн парк, технологийн инкубатор, инновацын төвүүд болон бусад шинэлэг санаачилгуудыг байгуулахад

бодлого боловсруулахад чиглэсэн хөрөнгө оруулалт, дэд бүтэц хөгжүүлэх болон бизнесийн таатай экосистем бүрдүүлэхэд нь олон оролцогч талын дэмжлэгийг татан оролцуулахаа бид амлаж байна.

70. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад хууль эрх зүйн орчин, удирдамжийг боловсруулахад дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна. Үүнд олон улсын корпорацийн хариуцлага, хяналтыг сайжруулах зорилгоор харилцан тохиролцсон нөхцөлөөр дотоодын агуулга, хөдөлмөр болон технологи дамжуулалтын заалтыг тусгах.
71. Инновацыг урамшуулах оюуны өмчийн эрхийн хөгжилд дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна.
72. Өртгийн сүлжээний уялдаа холбоог сайжруулах, эдийн засгийг төрөлжүүлэх, хүн ам зүйн давуу талыг ашиглах замаар бүх ажлын байрыг бүрэн хангах, зохистой ажлын байр бий болгох зорилготойгоор хүртээмжтэй, өрсөлдөх чадвартай нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхээ бид амлаж байна.
73. Аялал жуулчлал, хөдөө аж ахуй, бүтээлч эсвэл соёлын салбар хоорондын уялдааг дэмжихээ бид амлаж байна. Мөн гарааны бизнес, бичил, жижиг, дунд аж ахуйн нэгжүүд болон томоохон аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжиж, үндэсний болон бүс нутгийн нэмүү өртгийн сүлжээг бэхжүүлэх, дотоодын нийлүүлэлтийн чадавхыг нэмэгдүүлэх, гарааны болон бичил, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд илүү олон боломж нээхийг бид дэмжинэ.
74. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад хувийн хэвшлийг хөгжүүлэх олон оролцогч талын хандлагыг дэмжихээ бид амлаж байна. Үүнд засгийн газар, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны төвүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх арга хэмжээг багтаана.
75. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад мөнгөн шилжүүлгийн үнийн хамгаалалтыг бэхжүүлж хялбаршуулах, татварын гэрээний сайн туршлагыг дэмжихээ бид амлаж байна.
76. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад татварын орлогын алдагдлыг хязгаарлах зорилгоор ашиг шилжүүлэхийг

бууруулахад чиглэсэн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна.

77. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад олборлох салбарын, ялангуяа чухал ашигт малтмалтай холбоотой төслийн бэлтгэл, гэрээ хэлэлцээ хийх, одоо хүчин төгөлдөр гэрээнүүдийг хянахад тэдний хүсэлтээр бид дэмжлэг үзүүлэх болно.
78. Мөн далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг илүү сайн ойлголт бий болгох, тогтвортой бизнес эрхлэлтийг дэмжих, ахиц дэвшлийг хянах, үнэлэх зорилгоор задлан шинжилсэн мэдээллийг багтаасан мэдээллийн өгөгдөл цуглуулалтаа бэхжүүлэхийг бид уриалж байна.

III. Шинжлэх ухаан, технологи ба инновац

79. Дижиталчлалын огцом өсөлт болон “дөрөвдүгээр аж үйлдвэрийн хувьсгал”-ын нөлөөгөөр хиймэл оюун ухаан, машин сургалт, робот техник, их өгөгдөл зэрэг орчин үеийн болон дижитал технологид нэвтрэх, хөгжүүлэх, ашиглах чадавхыг аж үйлдвэржилт, бүтцийн өөрчлөлт, тогтвортой хөгжлийн гол хөдөлгөгч хүчин болохыг бид тэмдэглэж байна.
80. Дижитал технологийн үр өгөөж нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын дотоодод болон улс хооронд жигд бүс бөгөөд тэдгээр нь дэд бүтэц, зохицуулалт, бодлого, хэрэгжилтийн чадавх, институц болон дижитал үр чадварын ихээхэн хэмжээний зөрүүнээс шалтгаалан шинжлэх ухаан, технологи, инновацийн хүчийг бүрэн ашиглаж чадахгүй хэвээр байгааг бид санаа зовнин тэмдэглэж байна.
81. 2021 онд далайд гарцгүй хөгжиж буй орнуудад интернет хэрэглэгчдийн эзлэх хувь ердөө 32.3 хувь байсан бол дэлхийн дундаж нь 66 хувь байгааг бид санаа зовнин тэмдэглэж байна. Энэ нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн бүх нийтийн хүртээмжийг хангахад илүү их ахиц хэрэгтэйг харуулж байна.
82. Мөн 2023 оны байдлаар далайд гарцгүй хөгжиж буй орнуудад эмэгтэйчүүдийн интернет хэрэглээ эрэгтэйчүүдийн түвшнээс даруй 9 хувиар доогуур байгааг бид санаа зовнин онцлон тэмдэглэж байна.

83. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүнд эрдэм шинжилгээ, хөгжүүлэлтийн зардлын эзлэх хувь 0.2 хувь хэвээр байгаа нь дэлхийн дундаж болох 1.8 хувиас үлэмж доогуур байгаа бөгөөд иргэдээс гаргасан жил тутмын патентын өргөдлийн тоо 2014 онд 2764 байсан бол 2021 онд 929 болж мэдэгдэхүйц буурсныг бид санаа зовнин тэмдэглэж байна.
84. COVID-19 цар тахал нь цахим засаглал, цахим худалдаа зэрэг зарим чиг хандлагыг түргэсгэж, шинжлэх ухаан, технологи, инновац болон дижитал шийдлүүдийн хэрэглээг бодлого болон үйл ажиллагааны түвшинд далайд гарцгүй хөгжиж буй орнууд зайлшгүй ахиулах шаардлагатайг бид тэмдэглэж байна.
85. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын дижитал экосистемд хийгдэж буй цаашдын хөрөнгө оруулалтыг бүс нутгийн болон дэлхийн зах зээлд тэднийг нэгтгэхэд чухал болохыг бид онцлон тэмдэглэж байна.
86. Батлан хамгаалахын бус салбарт аюулгүй, найдвартай, итгэл төрүүлэхүйц хиймэл оюун ухааны системийг хөгжүүлэхийг дэмжих шаардлагатайг бид хүлээн зөвшөөрч байна. Энэ нь Тогтвортой Хөгжлийн 2030 он хүртэлх Хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэхэд ахиц дэвшлийг түргэсгэж, хиймэл оюун ухаан болон бусад дижитал хэрэглээний ялгааг улс хооронд, улс дотор арилгах боломжийг олгоно. Ийм хиймэл оюун ухааны стандартууд нь дижитал шилжилтийг саатуулах бус, харин дэмжих, хүртээмжтэй байдлыг хангах ёстойг бид онцолж байна. Энэ нь Тогтвортой хөгжлийн 17 зорилт болон тогтвортой хөгжлийн эдийн засаг, нийгэм, байгаль орчны гурван хэмжээсийг хэрэгжүүлэхэд, мөн хөгжиж буй орнуудад онцгой ач холбогдолтой дэлхийн нийтлэг сорилтыг шийдвэрлэхэд чухал хувь нэмэр оруулна. Бид цаашлаад хиймэл оюун ухаан нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын урт хугацааны хөгжлийн эрмэлзэлд хувь нэмэр оруулж чадахыг хүлээн зөвшөөрч байна.

Зорилтууд:

- Эрдэм шинжилгээ, хөгжүүлэлт болон дижитал дэд бүтцийг хүртээмжтэй, найдвартай, боломжийн үнэтэйгээр (цахим сургалт, цахим засаглал, цахим худалдаа багтана) хөгжүүлэхэд бүх эх үүсвэрээс орох хөрөнгө оруулалтыг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх.
- Судалгаа, инновац, бүтээлч үйл ажиллагаанд үр дүнтэй, тэнцвэртэй, нээлттэй, хүртээмжтэй экосистемийг хөгжүүлэхийг дэмжих.
- Сурч боловсрох, сургалт, чадавх бэхжүүлэх бүс нутгийн цахим платформ байгуулах.
- Шинжлэх ухаан, технологи, инновацийн одоо байгаа механизм, байгууламжийг ашиглан технологид нэвтрэх, технологийн хэрэгцээний үнэлгээ хийхэд далайд гарцгүй хөгжиж буй орнуудад дэмжлэг үзүүлэх.
- Судалгаа, хөгжүүлэлтийг дэмжихийн тулд шинжлэх ухаан, технологи, инновацийн төвүүдийг байгуулах эсвэл бэхжүүлэх, шинэ технологийг ашиглах, дижитал бичиг үсгийн болон үр чадварын түвшнийг дээшлүүлэх, хиймэл оюун ухаан, дэвшилтэт анализ, автоматжуулалт зэрэг гарч буй технологийг нутагшуулах.
- Улс хооронд болон улс доторх хиймэл оюун ухаан болон бусад дижитал ялгааг арилгах чиглэлээр илүү их арга хэмжээ авах

Бид дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг амлаж байна:

87. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын шинжлэх ухаан, технологи, инновацийн үр өгөөжийг хүртэх чадавхыг дээшлүүлэх, шинэ болон шинээр гарч буй технологид нэвтрэхэд саад болж буй бүтцийн гол хязгаарлалтыг арилгах чиглэлээр бид арга хэмжээ авна. Үүнд нээлттэй шинжлэх ухаан, боломжийн үнэтэй нээлттэй эх сурвалж бүхий технологи, судалгаа, хөгжүүлэлтийг өргөтгөх, түншлэлийг бэхжүүлэх зэрэг багтана.
88. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын дижитал эдийн засгийн оролцоог өргөжүүлэхийг бид амлаж байна. Үүнд дижитал

дэд бүтцийн холболтыг бэхжүүлэх, тэдний чадавх болон технологийн инновацынх хүртээмжийг нэмэгдүүлэх, дижитал бичиг үсэг, үр чадварыг сайжруулах зорилгоор илүү хүчтэй түншлэл байгуулах зэрэг орно.

89. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг шинжлэх ухаан, технологи, инновацын хүчийг ашиглан үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарт нэмүү өртөг болон бүтээмжийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна. Энэ нь хүртээмжтэй, шударга, тогтвортой өсөлтийг хангахад чиглэнэ.
90. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад хувийн хэвшил болон төрийн байгууллагуудын хамтарсан судалгаа, хөгжүүлэлтийн төслүүдийг дэмжих үндэсний судалгаа, инновацын сан байгуулахад туслахаа бид амлаж байна. Мөн тэдний үндэсний судалгааны төвүүдийг байгуулах, одоо байгаа төвүүдийн чадавх болон мэдлэгийн төвүүдийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээ амлаж байна.
91. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад шинжлэх ухаан, технологи, инновацын стратегийг тогтвортой хөгжлийн үндэсний төлөвлөгөө, стратегийн салшгүй хэсэг болгон хэрэгжүүлэх шаардлагатайг бид хүлээн зөвшөөрч байна. Энэ нь мэдлэг солилцоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх, шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик (STEM)-ийн боловсролд хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтыг нэмэгдүүлэх, жендерийн мэдрэмжтэй байдлаар хэрэгжүүлэхэд чиглэнэ.
92. Нээлттэй дижитал платформуудын уялдаа холбоог ашиглан бүс нутгийн чиглэлтэй сургалт, чадавх бэхжүүлэх хэрэгслийг хөгжүүлэхээ бид амлаж байна.
93. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад цахим засаглал, цахим нийтийн дэд бүтэц, төрийн зохицуулалтын чадавх зэрэг дижитал засаглалын хүрээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна. Энэ нь нээлттэй эх сурвалжид суурилсан арга барилыг ашиглан бэхжүүлэх, тэсвэрлэх чадварыг бий болгох, дижитал ялгааг багасгах (цаг үеийн болон хүйсийн ялгааг багтаасан), хүртээмжтэй, оролцоотой, тогтвортой

эдийн засгийн өсөлтийг дэмжих, дижитал салбарт ажлын байр бий болгох зэрэг иж бүрэн дижитал стратегийг хэрэгжүүлэхийг зорьж байна.

94. Бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох агентлагуудын хамтаар далайд гарцгүй хөгжиж буй орнуудад шинжлэх ухаан, технологи, инновацын ашиг тусыг бүтцийн өөрчлөлтөд ашиглахад дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна. Үүнд Технологи дэмжих механизм, Тогтвортой хөгжлийн өргөн зурвасын комисс болон бүх төрлийн эх үүсвэрээс хөрөнгө оруулалт татаж дэмжих үйл ажиллагаа багтана.
95. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын сорилтыг хүлээн зөвшөөрч, тэдэнд технологид нэвтрэх, технологийн хэрэгцээний үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна. Түүнчлэн шинжлэх ухаан, технологийн чадавхыг бэхжүүлэх, мэдлэгийн солилцоо, сүлжээ байгуулалтыг дэмжих, бизнес эрхлэлт, технологийн солилцоо, инновацыг урамшуулах, бодлого боловсруулах, хэрэгжүүлэхийг хөнгөвчлөх, инновацын экосистемийг бэхжүүлэх шаардлагатайг онцолж байна. Эдгээрийг аль болох Нэн буурай хөгжилтэй орнуудын Технологийн банк зэрэг одоо байгаа механизм, байгууламжид түшиглэн дэмжлэг үзүүлэхийг тэмдэглэж байна.
96. Хөгжлийн түншүүдийг далайд гарцгүй хөгжиж буй орнуудад технологийн шинэчлэл, шинжлэх ухаан, технологи, инновацын экосистемийг сайжруулахад дэмжлэг үзүүлэхийг, мөн харилцан тохиролцсон нөхцөлөөр технологи дамжуулахыг дэмжихийг бид уриалж байна. Үүнд хиймэл оюун ухаан, робот техник, их өгөгдөл, машин сургалт, сүлжээ зэрэг шинэ болон тэргүүний технологийг нутагшуулахад шаардлагатай дотоодын технологийн чадавхыг бүрдүүлэх зэрэг багтана.
97. Хөгжлийн түншүүд болон бусад бүх холбогдох оролцогч талуудыг далайд гарцгүй хөгжиж буй орнуудад хиймэл оюун ухаан болон бусад дижитал хэрэглээний ялгааг арилгах чиглэлээр арга хэмжээ авахыг бид уриалж байна.

98. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад үндэсний дижитал стратеги, бодитой дижитал холболт, үр чадварын хөгжил, үндэсний зохицуулалтын орчин болон бүс нутгийн болон глобал таатай орчныг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна.

IV. Аж үйлдвэржилт

99. Аж үйлдвэржилт нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт, ажлын байр бий болгох, нэмүү өртөг шингээх гол хөдөлгөгч хүч бөгөөд хөдөө аж ахуй, орон нутгийн эдийн засагт эерэг дам нөлөө үзүүлэхийн зэрэгцээ нэмүү өртөг их шингэсэн бараа, үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлдэг гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна. Мөн шинжлэх ухаан, технологи, инновац нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын аж үйлдвэрийн хөгжилд оруулж буй хувь нэмэр, эдийн засгийн өсөлт, төрөлжилт, нэмүү өртөг шингээлтийн чухал эх үүсвэр болохыг бид хүлээн зөвшөөрнө. Гэвч далайд гарцгүй хөгжиж буй орнуудын ихэнх нь хангалттай хэмжээнд аж үйлдвэржилтэд хүрч, бүс нутгийн болон дэлхийн зах зээлд нэгдэн ороход бэрхшээлтэй хэвээр байгааг бид санаа зовнин тэмдэглэж байна. Мөн үйлдвэрлэлийн нэмүү өртгийн ДНБ-д эзлэх хувь 12–13 хувийн хооронд тогтмол байсан бөгөөд Венийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд дунд болон өндөр технологийн үйлдвэрүүд үйлдвэрлэлийн нэмүү өртгийн дунджаар зөвхөн 14.5 хувийг бүрдүүлснийг мөн тэмдэглэж байна.
100. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын эдийн засгийн гүйцэтгэл зогсонги байдалд байгаа нь эдгээр оронд аж үйлдвэрийн хөгжлийг эрчимжүүлэх стратегийн арга хэмжээ зайлшгүй шаардлагатайг бид онцолж байна. Эдгээр улсын онцлогт нийцсэн аж үйлдвэрийн бодлого хэрэгжүүлж, аж үйлдвэрийн хөгжил нь хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил, түүнчлэн үйлдвэрлэл ба үйлчилгээний салбарын өсөлттэй нь хослон уялдах боломжийг хангах хэрэгтэй.

Зорилтууд:

- 2034 он гэхэд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын ДНБ-д үйлдвэрлэлийн нэмүү өртгийн эзлэх хувийг хоёр дахин нэмэгдүүлэх.
- 2034 он гэхэд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын нийт үйлдвэрлэлийн нэмүү өртөгт ногдох дунд болон өндөр технологийн үйлдвэрлэлийн эзлэх хувийг хоёр дахин нэмэгдүүлэх.
- Үндэсний тэргүүлэх чиглэлд нь нийцүүлэн идэвхтэй, шударга, хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэрийн бодлого нэвтрүүлэхэд далайд гарцгүй хөгжиж буй орнуудад хангалттай дэмжлэг үзүүлэх.

Бид дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг амлаж байна:

101. Үйлдвэрлэлийн шинж чанарын өөрчлөлт, салбаруудын харилцан хамаарлыг харгалзан үзсэн идэвхтэй аж үйлдвэрийн бодлогын хүрээг нэвтрүүлэхийг далайд гарцгүй хөгжиж буй орнуудад уриалж байна. Үйлдвэрлэлийн чадавх болон холбогдох оролцогч талуудтай хамтын ажиллагааг бэхжүүлж, ялангуяа хөдөөгийн аж үйлдвэржилтэд анхаарлаа төвлөрүүлэхийн зэрэгцээ албан бус салбарыг шат дараатайгаар албан ёсны болгох, аж үйлдвэрийн хөгжлийн хамтын ажиллагаа болон бизнес эрхлэлтийн бодлогод жендерийн хандлагыг төлөвшүүлэхийг дэмжинэ.
102. Худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого болон аж үйлдвэрийн бодлогын зорилтуудын стратегийн үялдааг бэхжүүлэхэд далайд гарцгүй хөгжиж буй орнуудад дэмжлэг үзүүлэхийг хөгжлийн түншүүдэд уриалж байна
103. Нэмүү өртөг шингээлт, үйлдвэрлэл ба экспортын бүтээгдэхүүний төрөлжилт, инновац, технологийг өргөн ашиглах ба нутагшуулахыг дэмжих зорилгод чиглэсэн аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр, төслүүд, мөн үйлдвэрлэлийн салбар дахь хөрөнгө оруулалтад далайд гарцгүй хөгжиж буй орнуудад санхүүгийн ба техникийн тусламж, чадавх бэхжүүлэх дэмжлэгээ нэмэгдүүлэхийг хөгжлийн түншүүдэд уриалж байна.

Тэргүүлэх чиглэл 2: Худалдаа, худалдааг хөнгөвчлөх ба бүс нутгийн интеграци

I. Олон улсын худалдаа

104. Олон улсын худалдаа нь эдийн засгийн өсөлт, ажлын байр бий болгох, тогтвортой хөгжилд хүрэх онцгой боломжуудыг олгодгийг бид хүлээн зөвшөөрч байна. Гэвч далайд гарцгүй хөгжиж буй орнууд газар нутгаасаа далай тэнгист хүрэх шууд гарцгүй байх, дэлхийн зах зээлээс алслагдсан байрлал, дамжин өнгөрөх тээврийн өндөр өртөг ба эрсдэл зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж олон улсын худалдааны боломжоо бүрэн ашиглаж чадахгүй байна. Эдгээр хүчин зүйлс нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг худалдааны өгөөжөөс хүртэж, нийгэм-эдийн засгийн хөгжлөө ахиулах чадамжийг нь үлэмж хязгаарлаж байна.
105. Олон улсын худалдаа нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хувьд нэн чухал бөгөөд тэдгээрийн ДНБ-д эзлэх хувь нь дэлхийн дунджаас өндөр байгааг бид хүлээн зөвшөөрч байна. Иймд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын дэлхийн худалдаанд оролцоог мэдэгдэхүйц нэмэгдүүлэх замаар худалдааны өөрчлөн шинэчлэх боломжийг тогтвортой эдийн засгийн өсөлтөд ашиглахыг бид эрмэлзэж байна.
106. Далайд гарцгүй хөгжиж буй орнууд дэлхийн хүн амын 7 хувийг бүрдүүлдэг хэдий ч 2022 онд тэдний дэлхийн барааны экспорт дахь эзлэх хувь ердөө 1.1 хувь байсанд бид санаа зовниж байна.
107. Далайд гарцгүй хөгжиж буй олон орны экспорт нь цөөн нэр төрлийн бүтээгдэхүүнд төвлөрсөн, нэмүү өртөг бага, гадаад орчны сөрөг нөлөөлөл ба аюулд маш өртөмтгий хэвээр байгааг бид санаа зовнин тэмдэглэж байна. 2022 онд тэдгээрийн экспортын 83 хувь нь анхдагч түүхий эд байсныг бид онцлон тэмдэглэж байна.
108. Үйлчилгээний худалдаа, дижитал, цахим худалдаа нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудад газарзүйн хязгаарлалтаа даван туулах ихээхэн боломж олгож байгааг бид хүлээн зөвшөөрч байна. Гэсэн хэдий ч, 2022 онд тэдгээрийн дэлхийн

үйлчилгээний экспортод эзлэх хувь ердөө 0.7 хувь, дижитал хэлбэрээр хүргэж болох үйлчилгээний экспортод эзлэх хувь 0.3 хувь байсанд бид санаа зовниж байна.

109. Далайд гарцгүй хөгжиж буй орнууд чухал ашигт малтмалын арвин их нөөц, баялагтай бөгөөд тэдгээрийг олборлох, нэмүү өртөг шингээх, экспортлох хүчин чармайлтад олон улсын хамтын нийгэмлэг үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэх нэн шаардлагатай байгааг бид хүлээн зөвшөөрч байна.
110. Худалдааны бодлого боловсруулах болон худалдааны хэлэлцээ хийх үр чадвар зэрэг чиглэлээр далайд гарцгүй хөгжиж буй орнуудад худалдааны чадавх бэхжүүлэхэд дэмжлэг шаардлагатайг бид хүлээн зөвшөөрч байна.
111. Дүрэмд суурилсан, ялгаварлан гадуурхдаггүй, нээлттэй, шударга, хүртээмжтэй, тэгш, ил тод байх үндсэн зарчимд тулгуурласан, худалдааг бодитой либералчлах зорилготой ДХБ-ын олон талт худалдааны системийг далайд гарцгүй хөгжиж буй орнуудад түлхүү хандуулж дэмжихийн чухлыг бид онцолж байна.
112. Далайд гарцгүй хөгжиж буй 32 орны 26 нь Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүн бөгөөд үлдсэн зургаан орны нэгдэх үйл явц нь өөр өөр түвшинд байгааг бид тэмдэглэж байна.
113. Худалдааг хөнгөвчлөх хорооны дамжин өнгөрөх тээврийн асуудлаарх тусгай хэлэлцүүлгийн ач холбогдлыг бид хүлээн зөвшөөрч байна. ДХБ-ын Сайд нарын XIII Бага хурлаас "Худалдаа ба Хөгжлийн Хороо"-нд далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг олон талт худалдааны системд бүрэн нэгтгэхэд шаардагдах худалдаатай холбоотой сорилтыг үнэлэх тусгай хэлэлцүүлгүүд зохион байгуулах чиглэл өгснийг бид сайшаан тэмдэглэж байна.
114. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын дамжин өнгөрөх тээврийн бараа бүтээгдэхүүнийг хамруулсан хорио цээр, ургамлын хорио цээрийн арга хэмжээ болон техникийн зохицуулалтад нийцэх эрх зүйн, техникийн чадавхыг нь өргөтгөхөд хөгжлийн түншүүдийн дэмжлэг шаардлагатайг бид хүлээн зөвшөөрч байна.

Зорилтууд:

- Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын дэлхийн худалдаанд оролцох оролцоог мэдэгдэхүйц нэмэгдүүлж, 2034 он хүртэлх хугацаанд тэдний барааны экспортын хэмжээг дор хаяж хоёр дахин өсгөхөд дэмжлэг үзүүлэх.
- Экспортын нэмүү өртөг, боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх, үйлчилгээ болон цахим худалдааны экспортыг өргөтгөх замаар худалдааг мэдэгдэхүйц төрөлжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- 2034 он гэхэд үйлчилгээний экспортын хэмжээг дор хаяж хоёр дахин өсгөх зорилгоор үйлчилгээний экспортод мэдэгдэхүйц ахиц гаргахад дэмжлэг үзүүлэх.
- ДХБ-ын дүрэмтэй нийцэхгүй, дур зоргын буюу үндэслэлгүй тарифын бус хориг арга хэмжээг бууруулах, арилгах.
- Дамжин өнгөрөх тээврийн бараанд хорио цээрийн арга хэмжээг авахдаа ДХБ-ын дүрэмд нийцүүлэн ил тод байх.
- Далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг ДХБ-д нэгдэх үйл явцыг эцэслэн дуусгах, үүрэг амлалтаа биелүүлэх, олон талт худалдааны системд нэгдэн ороход нь зохих техникийн тусламж, чадавх бэхжүүлэх арга хэмжээг санал болгох.
- ДХБ-ын хүрээнд далайд гарцгүй хөгжиж буй орнуудад зориулсан Ажлын хөтөлбөр батлуулах эрмэлзлийг тэмдэглэх.

Бид дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг амлаж байна:

115. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын уламжлалт бус салбарт оруулах хөрөнгө оруулалт, хөгжлийн тусламж болон “Худалдааны тусламж”-ийг нэмэгдүүлэх хүчин чармайлтыг эрчимжүүлэх замаар, нэмүү өртөг шингээлт ба экспортын төрөлжилтийг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх зорилготойгоор үндэсний худалдааны стратеги, бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна.
116. Бизнесийн орчныг сайжруулах, дотоодын компаниуд, ялангуяа бичил, жижиг, дунд аж ахуйн нэгж (эмэгтэйчүүдийн эзэмшлийн ААН-үүдийг багтаан) олон улсын худалдаанд илүү үр дүнтэй

оролцоход нь дэмжих бодлогыг хэвшүүлэхээ бид амлаж байна. Үүнд худалдааг дэмжих институтуудыг, зээлийн хүртээмж болон өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, төр-хувийн хэвшлийн хэлэлцүүлгийн талбарыг бий болгох, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт, чадавх бэхжүүлэх, бизнес-хоорондын платформоор дамжуулан бусад зах зээлтэй холбох арга хэмжээг, боломжтой тохиолдолд хэрэгжүүлнэ.

117. Анхдагч түүхий эдээс хэт хамааралтай, далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын худалдаанд оролцох бүтцийн саад бэрхшээлийг шийдвэрлэх, төрөлжилтийг сааруулж буй хүчин зүйлсийг арилгах, түүхий эдийн боловсруулалтыг урамшуулах хүчин чармайлтыг нь бид дэмжинэ.
118. Шаардлагатай тохиолдолд “Стандарт ба худалдааны хөгжлийн сан” (СХХС)-гаар дамжуулан далайд гарцгүй хөгжиж буй орнуудад хорио цээр, ургамлын хорио цээрийн арга хэмжээ болон техникийн стандартад нийцэх чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг Хөгжлийн түншүүдэд уриалж байна.
119. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын үйлчилгээний худалдаа болон үйлчилгээ-зуучлалтай худалдааны өгөөжийг хүртэхэд чиглэсэн хүчин чармайлтыг бид дэмжинэ.
120. Хөгжлийн түншүүд болон бүх холбогдох оролцогч талуудыг далайд гарцгүй хөгжиж буй орнуудтай хамтран, тэдний сонирхлын салбаруудад үйлчилгээний худалдааг цаашид хөнгөвчлөх арга хэмжээ хэрэгжүүлэхийг уриалж байна.
121. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад дижитал худалдаа, цахим худалдааг хөгжүүлэхэд таатай нөхцөлийг бүрдүүлэх амлалтыг бид авч байна. Үүнд дижитал дэд бүтэц хангалтгүй, эрх зүйн ба зохицуулалтын орчин сул, дижитал үр чадвар хомс зэрэг суурь сорилтыг шийдвэрлэх, холбогдох олон улсын худалдааны хэлэлцээ хийхэд тэдний онцгой хэрэгцээ, сорилтыг харгалзан үзэх, мөн эдгээр хэлэлцээнд үр нөлөөтэй оролцох чадавхыг нь сайжруулах зэрэг асуудал багтана.
122. Хөгжиж буй орнуудад экспортод түшиглэсэн өсөлтийг бид дэмжинэ. Үүнд хөгжиж буй орнуудад хөнгөлөлт эдэлж худалдаанд нэвтрэх боломж олгох, тухайн улсын хөгжлийн

- хэрэгцээнд нийцсэн “тусгайлсан ба ялгавартай тариф”-ын зохицуулалтыг, ялангуяа нэн буурай хөгжилтэй орнуудад, хэрэгжүүлэх, мөн ДХБ-ын хэлэлцээрүүдтэй үл нийцэх худалдааны аливаа саад тотгорыг арилгах зэрэг асуудал орно.
123. Тарифын бус арга хэмжээг зохистойгоор шийдвэрлэж, ДХБ-ын дүрэмтэй нийцэхгүй дүр зоргын буюу үндэслэлгүй тарифын бус саад тотгорыг бууруулж, арилгах болно.
124. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын ДХБ-д элсэх, худалдааны хэлэлцээнд идэвхтэй оролцох, үр дүнтэй хэлэлцүүлэг, маргаан шийдвэрлэлтийг явуулах, олон талт худалдааны системд нэгдэхэд худалдаатай холбоотой техникийн тусламж, чадавх бэхжүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэхийг хөгжлийн түншүүдэд бид уриалж байна.
125. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын тусгай хэрэгцээнд чиглэсэн ажлын хөтөлбөрийг ДХБ-ын ивээл дор хэрэгжүүлэх сонирхлоо бид онцлон тэмдэглэж, “Худалдаа ба Хөгжлийн Хороо”-ны тусгай хэлэлцүүлгийн үр дүнг хүлээж байна.
126. Бүх улс орнуудыг олон улсын худалдааны бүх төрлийн хэлэлцээнд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын онцгой хэрэгцээ, сорилтыг харгалзан үзэж байхыг бид уриалж байна.
127. НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD), Дэлхийн банк, ДХБ, Дэлхийн гаалийн байгууллага, Олон улсын худалдааны төв зэрэг бүх холбогдох байгууллагыг өөрсдийн харьцангуй давуу талтай чиг үүргийн хүрээнд далайд гарцгүй болон дамжин өнгөрөх хөгжиж буй орнуудад тодорхой дэмжлэг үзүүлэхийг бид уриалж байна. Үүнд экспортын дэмжлэг, худалдааны үзэсгэлэн, худалдааг хөнгөвчлөх, цахим худалдаа, мөн эмэгтэйчүүд, залуучууд, эмзэг бүлгийн ашиг сонирхлыг тусгасан хүртээмжтэй худалдааны бодлого боловсруулах, хэрэгжүүлэх дэмжлэг орно.
128. Чөлөөт зах зээлийн хэвийн үйл ажиллагааг хангах, дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд холбогдох, зайлшгүй шаардлагатай хил дамнасан зорчих хөдөлгөөнийг хангах, нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдал, тэсвэржилтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг улс орнуудад бид уриалж байна. Энэ

нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг өнөөгийн болон ирээдүйн болзошгүй цочрол, аюул, гамшиг, цар тахал, онцгой байдалд бэлтгэхэд туслах юм.

129. Жендерийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхжуулалтыг ахиулахад хувь нэмэр оруулахуйц хүртээмжтэй худалдааны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхийг бид дэмжинэ. Ийм бодлого нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлж, ядуурлыг бууруулахад тусалдаг.

II. Худалдааг хөнгөвчлөх

130. Худалдааг хөнгөвчлөх нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын худалдааны зардлыг бууруулахад чухал үүрэгтэйг бид онцолж байна. Далайд гарцгүй орнуудын худалдааны зардал нь далайд гарцтай хөгжиж буй орнуудынхаас дунджаар 30 хувиар илүү байгаа бөгөөд энэ нь олон улсын хил дамнасан худалдаанд тулгардаг саад тотгор, хүндрэлтэй холбоотой юм.
131. COVID-19 цар тахлын үеэр хил хаагдаж, хилийн хатуу дэглэм тогтоосон явдал болон өнөөгийн геополитикийн хурцадмал байдал, зөрчил мөргөлдөөн нь олон улсын нийлүүлэлтийн сүлжээний эмзэг байдал, мөн хямралын үед далайд гарцгүй орнуудын бараа, бүтээгдэхүүн дэлхийн зах зээлд саадгүй, үр ашигтай, хэмнэлттэй нэвтрэхэд том сорилт болсонд бид сэтгэл зовниж байна.
132. Иймээс худалдааг хөнгөвчлөх арга хэмжээг ашиглан далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын зах зээлд нэвтрэх боломжийг илүү тогтвортой, урьдчилан таамаглахуйц, уян хатан болгохыг бид зорьж байна. Энэ нь зөвхөн эдгээр орнуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх төдийгүй, шударга нийгэм, эдийн засгийн үр дүнд хүрэхийн тулд зайлшгүй шаардлагатай чухал бараа, бүтээгдэхүүний хүртээмжийг баталгаажуулах ач холбогдолтой.

133. Олон улсын эрх зүйн холбогдох дүрэм журмын дагуу дамжин өнгөрөх тээврийн эрх чөлөө нь далайд гарцгүй орнуудыг дэлхийн болон бүс нутгийн ханган нийлүүлэлтийн сүлжээнд холбох зайлшгүй нөхцөл болохыг бид онцолж байна.
134. Тээврийн коридорыг далайд гарцгүй орнуудын худалдааны саад бэрхшээлийг арилгах үр дүнтэй хэрэгсэл гэж бид үзэж байна. Энэ нь дамжин өнгөрөх тээврийн маршрутын дагуух хамтын ажиллагааг бэхжүүлэх, цаг уурын өөрчлөлтөд тэсвэртэй дэд бүтэц хөгжүүлэх, “ухаалаг нэг цэгийн хилийн шалган нэвтрүүлэх пост” зэрэг байгууламжийг байгуулах, холбогдох дамжин өнгөрөх тээврийн журам, стандарт, системийг уялдуулах, холбох, мөн стратегийн ач холбогдол бүхий олон төрөлт тээврийн болон логистикийн дэд бүтцийг төлөвлөх, санхүүжүүлэхэд чиглэнэ.
135. Одоогоор Дэлхийн худалдааны байгууллагын “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-ийн хэрэгжилтийн түвшин хөгжиж буй бүх оронд дунджаар 81.1 хувьтай байгаа бол далайд гарцгүй хөгжиж буй орнуудад энэ үзүүлэлт 2023 оны 11 дүгээр сарын байдлаар ердөө 61.8 хувьтай байна.
136. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын барааны хөдөлгөөн, гаргалт, бүртгэл, түүний дотор дамжин өнгөрөх тээврийн барааны тал дээр чадавх бэхжүүлэх дэмжлэгийг үргэлжлүүлэн олгох шаардлагатайг бид хүлээн зөвшөөрч байна.
137. Дэлхийн худалдааны байгууллагын Сайд нарын XII дугаар бага хурлын шийдвэрийг бид сайшааж байна. Уг шийдвэрийн дагуу Худалдааг хөнгөвчлөх хороо нь “Дамжин өнгөрөх тээврийн асуудлаар жил бүр тусгай хуралдаан зохион байгуулах” бөгөөд энэ үйл явцыг дараагийн хэлэлцээрийн хяналт дуусах хүртэл үргэлжлүүлэхийг бид уриалж байна.

Зорилтууд:

- Баримт бичиг болон хилийн шалгалтын журмыг хялбаршуулж, уялдуулах замаар боомт, хилийн саатал ба зардлыг мэдэгдэхүйц бууруулах.
- Дамжин өнгөрөх тээврийн байгууламж болон тэдгээрийн үр

ашигт байдлыг сайжруулж, бараа хил дамжин нэвтрэх хугацаа, өртгийг бууруулснаар олон улсын худалдаанд далайд гарцгүй байдлын хүндрэл бэрхшээлийг даван туулахад бодит хувь нэмэр оруулах.

- Худалдааг хөнгөвчлөхтэй холбоотой стандарт тогтоодог байгууллагуудад далайд гарцгүй хөгжиж буй орнуудын идэвхтэй оролцоог дэмжих.
- Далайд гарцгүй болон дамжин өнгөрөх хөгжиж буй бүх оронд Дэлхийн худалдааны байгууллагын “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-ийг бүрэн, үр дүнтэй хэрэгжилтээ түргэтгэхийг уриалах.
- Хэлэлцээрийн дагуу далайд гарцгүй болон дамжин өнгөрөх хөгжиж буй орнуудын худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагааг дэмжих.
- НҮБ-ын “Дижитал болон тогтвортой худалдааг хөнгөвчлөх дэлхийн судалгаа”-нд хамрагдсан арга хэмжээний хэрэгжилтийн түвшнийг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх.

Бид дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг амлаж байна:

138. Далайд гарцгүй болон дамжин өнгөрөх орнуудыг худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагаагаа сайжруулахад дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна. Үүнд дамжин өнгөрөх асуудлаарх дүрэм, баримт бичгийн шаардлага, хил нэвтрэх журам, гаалийн горимыг уялдуулах, хялбаршуулах, стандартчилах арга хэмжээ багтана. Энэ бүхэн нь олон улсын гааль, тээвэр, аюулгүй байдлын стандартад нийцсэн байх бөгөөд “нэг цонхны систем”, гаалийн цахимжуулалтыг дэмжинэ.
139. Далайд гарцгүй орнуудын далайд хүрэх болон далайгаас саадгүй буцах, үр ашигтай, хэмнэлттэй далайд гарах эрхийг бүх төрлийн тээврийн хэрэгслээр, олон улсын эрх зүйн холбогдох дүрмийн дагуу баталгаажуулах амлалтаа бид дахин нотолж байна.
140. Далайд гарцгүй болон дамжин өнгөрөх орнуудын тээврийн коридорыг хөгжүүлэх, бэхжүүлэхийг бид дэмжинэ. Үүнд хил нэвтрэх журмыг оновчтой болгох, эрх зүйн болон бодлогын

хүрээг хэрэгжүүлэх, коридорын маршрутын дагуу дэд бүтцийг уялдуулах, мэдээлэл цуглуулах, коридорууд хоорондын сайн туршлагыг хуваалцах зэрэг арга хэмжээ орно.

141. Далайд гарцгүй орнууд болон хөрш дамжин өнгөрөх орнуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, хилийн чанад дахь худалдаа, дамжин өнгөрөх тээврийн сорилтыг үр дүнтэй хянах, шийдвэрлэх зорилгоор өгөгдөл цуглуулах, хянах хамтарсан механизм хөгжүүлэхийг бид уриалж байна.
142. Гаалийн удирдлага, хил болон коридорын менежмент, худалдааг хөнгөвчлөх бодлогын хэрэгжилтийн талаар дэлхий, бүс, дэд бүсийн түвшинд сайн туршлагыг далайд гарцгүй орнуудтай хуваалцахыг бид дэмжинэ. Энэ зорилгын хүрээнд хувийн хэвшилтэй нягт хамтран ажиллах болно.
143. Худалдаа, гаалийн үйл ажиллагааг цахимжуулахыг бид дэмжиж байна. Энэ нь ачаа, тээврийн хэрэгсэлтэй холбоотой өгөгдөл, мэдээллийг олон улсын стандартын дагуу хурдан, найдвартай солилцох нөхцөл бүрдүүлж, мэдээллийн хамгаалалтыг хангахын зэрэгцээ бүх дамжин өнгөрөх асуудлаарх үйл ажиллагааг хамрахуйц уялдаа холбоотой, харилцан ажиллах чадвартай системийг хөгжүүлэхийг уриалж байна.
144. Олон улсын хамтын ажиллагаанд тулгуурласан олон улсын гаалийн баталгааны схемүүдийг хөгжүүлэхийг бид уриалж байна. Ийм систем нь оролцогч орнуудын нягт хамтын ажиллагаа, итгэлцэл, амлалтад суурилдаг болохыг бид хүлээн зөвшөөрч байна.
145. Далайд гарцгүй болон дамжин өнгөрөх хөгжиж буй орнуудад “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэхэд чиглэсэн чадавх бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна.
146. Далайд гарцгүй болон дамжин өнгөрөх орнуудын худалдаа, тээврийн хөнгөвчлөхтэй холбоотой олон улсын конвенцуудыг соёрхон батлах, хэрэгжүүлэхэд чиглэсэн санхүүгийн болон техникийн чадавх бэхжүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэхээ бид амлаж байна.

III. Бүс нутгийн интеграци ба хамтын ажиллагаа

147. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хүртээмжтэй, шударга, боломжийн үнэтэй холболт, нэвтрүүлэх чадавхын асуудал нь зайлшгүй бүс нутгийн шинж чанартай болохыг бид хүлээн зөвшөөрч байна. Учир нь эдгээр орнуудын худалдааны ихэнх хэсэг бүс нутгийн түншүүд болон бүс нутгийн нэмүү өртгийн сүлжээгээр дамжин явагддаг.
148. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хүртээмжтэй, шударга, боломжийн үнэтэй холболт нь зайлшгүй бүс нутгийн хэмжээнд шийдвэрлэгдэх шаардлагатай асуудал бөгөөд тэдний худалдааны урсгал нь бүс нутгийн түнш болон бүс нутгийн нэмүү өртгийн сүлжээнээс хамааралтай байдгийг бид дахин нотолж байна.
149. Иймд бүс нутгийн интеграцийг далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын худалдаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх гол хэрэгслийн нэг болгон ашиглахыг бид эрмэлзэж байна.
150. Бүс нутгийн эдийн засгийн интеграци болон харилцан холбогдоход асар их боломж байгааг бид хүлээн зөвшөөрч, эдгээр нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хүртээмжтэй өсөлт болон тогтвортой хөгжилд чухал хувь нэмэр оруулна гэдгийг онцолж байна. Үүнтэй холбогдуулан бид бүс нутгийн хамтын ажиллагаа болон худалдааны хэлэлцээрийг бэхжүүлэх амлалтаа дахин нотолж байна.
151. Венийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтээс хойш бүс нутаг болон дэд бүс нутгийн худалдааны хэлэлцээрүүдийн ярилцлага, хэрэгжилтийн хүрээнд гарсан ахиц дэвшлийг бид өндрөөр үнэлж байна. Үүнд Африкийн чөлөөт худалдааны нэгдсэн бүс (AfCFTA), Евроазийн эдийн засгийн холбоо, Бүс нутгийн иж бүрэн эдийн засгийн түншлэл (RCEP), мөн Африкийн Нэгдсэн Агаарын Тээврийн Зах зээл (SAATM), Ази, Номхон далайн Хил дамнасан Цаасгүй худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр зэрэг санаачилгууд багтана. Эдгээр санаачилга нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг бүс нутгийн болон дэлхийн нэмүү өртгийн сүлжээнд нэгтгэх чухал механизм гэж бид үзэж байна.

152. Бүс нутгийн интеграци нь зөвхөн худалдаа болон худалдааг хөнгөвчлөх асуудлаар хязгаарлагдахгүй, мөн хөрөнгө оруулалт, судалгаа, хөгжлийн хамтын ажиллагаа, бүс нутгийн аж үйлдвэржилт болон хүртээмжтэй, шударга, боломжийн үнэтэй бүс нутгийн холболтыг түргэтгэх бодлогуудыг хамрах ёстойг бид онцолж байна.

Зорилтууд:

- Бүс нутаг болон дэд бүс нутгийн худалдааг нэмэгдүүлж, бүс нутгийн интеграцийг далайд гарцгүй байдлын сорилтуудыг шийдвэрлэх, худалдааны боломжийг нээх арга хэрэгсэл болгон ашиглах.
- Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын дэд бүс нутгийн хоорондын худалдаанд эзлэх хувь хэмжээг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх.
- Бүс нутгийн худалдааны хэлэлцээрүүдэд дамжин өнгөрөх тээврийн худалдааны заалт тусгах.
- Далайд гарцгүй орнуудын оролцоотой бүс нутаг болон дэд бүс нутгийн худалдааны хэлэлцээрүүдийн хооронд туршлага, мэдлэг солилцоог дэмжиж, бүс нутгийн интеграцийн үйл явцыг гүнзгийрүүлэн, эдгээр орнуудын дэлхийн эдийн засагт нэгдэх үйл явцыг хурдасгах.

Бид дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг амлаж байна:

153. Бүс нутаг болон дэд бүс нутгийн интеграцийн зохицуулалтуудыг гүнзгийрүүлж, хэрэгжилтийг нь үр дүнтэй болгохыг дэмжихээ бид амлаж байна. Үүнд тээвэр, холбоо, дижитал болон эрчим хүчний сүлжээний хамтарсан төсөл, бүс нутгийн бодлого уялдуулах, сайн туршлага солилцох, хөгжлийн тусламжийг (ялангуяа бүс нутгийн “Худалдааны тусламж” хөтөлбөрийг) чиглүүлэх арга хэмжээ орно.
154. Худалдаа, тээвэр болон дамжин өнгөрөх хөнгөвчлөлтэй холбоотойгоор бүс нутгийн болон дэд бүсийн интеграцийг гүнзгийрүүлэх, дэд бүтцийн холболтыг сайжруулах, хилийн цаанах ачаа барааны хөдөлгөөнийг хөнгөвчлөхийг бид дэмжинэ.

155. Бүс болон дэд бүсийн худалдааны хүрээнд дамжин өнгөрөх худалдаа болон холболтын асуудлыг тусгайлан авч үзэх, мөн эдгээр хэлэлцээрүүдэд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын оролцоог бэхжүүлэхийг бид уриалж байна.
156. Бүс нутгийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхийг дэмжиж, олон улсын хамтын нийгэмлэгийг худалдааны хөнгөлөлтийн схемүүд болон санаачилгуудаа бүс нутгийн хамтран ажиллах хэлбэрүүдтэй уялдуулахыг бид уриалж байна.
157. Далайд гарцгүй болон дамжин өнгөрөх орнуудад чиглэсэн техникийн болон санхүүгийн тусламж, чадавх бэхжүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэхийг бид амлаж байна. Энэ нь бүс нутгийн интеграцийн хүчин чармайлтыг дэмжих, дамжин өнгөрөх орнууд болон хөгжлийн түншүүдтэй хамтран санхүүжих боломжтой бүс нутгийн дэд бүтцийн төслүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцыг дэмжих зорилготой.
158. Бүс нутгийн болон “Өмнөд-Өмнөд” хамтын ажиллагааг дэмжиж, туршлага, технологийн ололт амжилтыг хуваалцах, нөөц дайчлах, мэдлэг ба туршлагаа системтэй солилцох замаар бүс нутгийн дэд бүтцийн хөгжил, интеграцийн үйл явцыг урагшлуулахыг бид уриалж байна.

Тэргүүлэх чиглэл 3: Дамжин өнгөрөх тээвэр ба холболт

I. Дамжин өнгөрөх тээврийн холболт

159. Далайд гарцгүй хөгжиж буй орнууд нь далайд хүрэх газар зүйн шууд гарцгүй, дэлхийн зах зээлээс тусгаарлагдсанаас үүдэлтэй онцгой сорилтуудтай тулгарч байгааг бид хүлээн зөвшөөрч байна. Тэдний холболтын асуудлууд нь тээврийн хангалтгүй дэд бүтэц, холболт болон логистик сул хөгжсөн, дамжин өнгөрөх орнуудаас өндөр хамааралтай, хил, дамжин өнгөрөх нарийн төвөгтэй дүрэм, журам зэргээс хамаарч улам хүндэрч байна.
160. 2026 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 10 жилийн хугацаанд хэрэгжих “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой тээврийн арван жил”-ийг зарлахын ач холбогдлыг бид

онцолж байна. Энэ нь ялангуяа далайд гарцгүй хөгжиж буй болон дамжин өнгөрөх орнуудад чухал бөгөөд уг 10 жилийн хөтөлбөрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг талархан хүлээн авах болно.

161. Тээврийн дэд бүтцийн хувьд ахиц гарсан хэдий ч биет дэд бүтэц хангалтгүй байгаа нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын найдвартай, тогтвортой дамжин өнгөрөх тээврийн тогтолцоонд гол саад учруулсан хэвээр байгаад бид санаа зовниж байна. Үүний улмаас эдгээр орнуудын тээвэр, худалдаа болон аяллын өртөг өндөр хэвээр байна.
162. Замын сүлжээ нь далайд гарцгүй орнуудын ачаа болон зорчигч тээврийн хувьд чухал болохыг тэмдэглэж, тэдгээрийн хатуу хучилттай замын нягтрал дэлхийн дунджаас 200,000 км-ээр дутуу байгаад бид санаа зовниж байна.
163. Төмөр замын тээвэр нь автозамынхаас богино, хурдан, найдвартай давуу талтай боловч бүрэн холбогдоогүй, хуучирсан зам, хангалтгүй засвар арчлалтаас шалтгаалан сул дорой байгааг бид хүлээн зөвшөөрч байна. Дэлхийн дундаж түвшинд дөхөхийн тулд далайд гарцгүй орнууд нийт 46,000 км шинэ төмөр зам барих шаардлагатай байна.
164. Венийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд Африкийн далайд гарцгүй дөрвөн улс төмөр замгүй байгаа талаарх мэдээнд бид санаа зовниж байна. Африкийн төмөр замын сүлжээний 26,362 км нь дутуу холбогдсон хэвээр байгаа бөгөөд энэ нь Африкийн чөлөөт худалдааны нэгдсэн бүсийн бүрэн хэрэгжилтэд ихээхэн хүндрэл үүсгэж байна.
165. Агаарын тээврийн чадавхыг далайд гарцгүй орнуудын газрын тээврийн бэрхшээлийг тойрон гарах, ялангуяа аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд чухал гэж бид үзэж байна. Гэвч эдгээр орнуудын агаарын холболт дэлхийн дунджаас доогуур байгаа нь хөрөнгө оруулалтын хомсдол болон боломжийн үнэтэй агаарын тээврийн үйлчилгээний өргөжилт хязгаарлагдмал байгаатай холбоотой байна.
166. Усан замын ашиглалттай холбоотой олон улсын эрх зүйн зарим асуудлууд, ялангуяа боомтын дэд бүтэц болон үндэсний

зохицуулалтын баримт бичгүүдийн үл нийцэл байгааг тэмдэглэж, дамжин өнгөрөх болон далайд гарцгүй орнуудын хооронд уялдаа, зохицуулалт шаардлагатайг бид онцолж байна.

167. Дамжин өнгөрөх коридорыг эдийн засгийн хөгжлийн коридор гэж үзэх шаардлагатай бөгөөд эдгээр нь далайд гарцгүй болон дамжин өнгөрөх орнуудын гол ачаа тээврийн зангилааг холбож, хил дамнасан бараа, хүмүүсийн хөдөлгөөнийг хурдасгах чухал хэрэгсэл болохыг бид тэмдэглэж байна.
168. Дамжин өнгөрөх тээврийн коридор нь хатуу дэд бүтэц (зам, төмөр зам, усан зам, боомт, нисэх буудал, хилийн пост) болон зөөлөн дэд бүтэц (институцийн, эрх зүйн болон зохицуулалтын орчин, стандарт, логистикийн үйлчилгээ, технологийн хэрэглээ) хоёрыг холбож, холболтыг сайжруулах ач холбогдолтойг бид хүлээн зөвшөөрч байна. Гэвч зарим далайд гарцгүй орнууд коридорын удирдлагын байгууллага, эрх зүйн зохицуулалтгүй байгаад санаа зовниж байна.
169. Тээвэр болон дамжин өнгөрөх коридор нь хот, хөдөөг холбох, улсын дотор болон улс хоорондын холболтыг сайжруулах, бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулах, хотууд, хүмүүс, нөөцийг холбох, бүс нутгийн болон дотоодын худалдааг дэмжих чухал хэрэгсэл болохыг бид онцолж байна.
170. Хуурай боомтууд нь далайд гарцгүй орнуудын логистикийн гүйцэтгэлийг сайжруулах, тээвэр, логистикийн үр ашгийг нэмэгдүүлэх, авто замаас төмөр зам, эсвэл дотоодын усан зам руу шилжих боломжийг нэмэгдүүлэх замаар үр өгөөж өгөхийг бид чухалчилж байна.
171. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын санаа зовнилыг анхаарч, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Далайн эрх зүйн тухай конвенцын Х хэсэг¹², 1994 оны Гаалийн тариф ба худалдааны ерөнхий хэлэлцээрийн (ГТХЕХ) 5 дугаар зүйл, болон Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн (ХХХ) 11 дүгээр зүйлд тусгасан далайд гарцгүй орнуудын далайд хүрэх эрх, дамжин өнгөрөх эрх чөлөөний хэрэгжилт хангалтгүй байгаад бид харамсаж байна.

12 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гэрээний Цуврал, боть 1833, № 31363.

Зорилтууд:

- Олон улсын эрх зүйн холбогдох дүрмүүдийн дагуу, тээврийн бүх хэрэгслээр далайд чөлөөтэй, үр ашигтай, өртөг багатай нэвтрэх боломжийг бүрэн хангах.
- Тогтвортой хөгжлийн зорилтуудын 9.1.2, 9.а болон 3.9-д нийцсэн тэсвэртэй, аюулгүй, ухаалаг, тогтвортой дамжин өнгөрөх дэд бүтцийг хөгжүүлэх.
- Өндөртүвшний шинжээчдийн зөвлөл байгуулж, далайд гарцгүй орнуудын далайд хүрэх саадгүй, үр ашигтай нэвтрэлтийг хангах арга замыг тодорхойлох.
- Аюулгүй, боломжийн үнэтэй, хүртээмжтэй, тогтвортой тээврийн дэд бүтэц, үндэсний болон хил дамнасан холболтыг өргөтгөж, шинэчлэх.
- Далайд гарцгүй болон дамжин өнгөрөх орнуудын хооронд хил дамнасан нэгдсэн тээврийн стандарт, шаардлагыг бий болгох.
- Далайд гарцгүй орнуудын дэд бүтцийн хөрөнгө оруулалтын сан байгуулах боломжийг судлах.
- Далайд гарцгүй орнуудын агаарын тээврийн системийг өргөжүүлж, бүс нутгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, олон улсын худалдааг тэлэх.

Бид дараах арга хэмжээг авна:

172. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад төмөр зам, авто зам, агаарын тээвэр, хуурай боомт, усан зам, хоолой, хил дамнасан цахилгаан дамжуулах шугам зэрэг салбарт аюулгүй, хямд өртөгтэй, хүртээмжтэй, тогтвортой тээврийн системийг бий болгох, эсвэл хадгалахыг дэмжихийн төлөө бид чармайх болно. Энэ нь тээврийн зардлыг бууруулах, худалдааг хөнгөвчлөх, бүс нутгийн болон олон улсын зах зээлтэй холбох, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэнэ.
173. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг бүх төрлийн тээврийн горимыг хамарсан, эмэгтэйчүүд, охид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настнууд болон эмзэг нөхцөлд байгаа хүмүүсийн хэрэгцээг харгалзан үзсэн, аюулгүй, хямд өртөгтэй,

хүртээмжтэй, тогтвортой тээврийн дэд бүтцийн хөгжил, засвар үйлчилгээнд чиглэсэн үндэсний болон орон нутгийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхийг бид уриалж байна.

174. Далайд гарцгүй хөгжиж буй болон дамжин өнгөрөх орнуудын хоорондын холбогдох талаарх хоёр талт гэрээ хэлэлцээрийг бүс нутгийн болон олон улсын хууль эрх зүйн баримт бичгүүдийн дагуу, ялангуяа тээврийн коридорын хөгжил, менежменттэй холбогдуулан байгуулахыг бид уриалж байна.
175. Далайд гарцгүй болон дамжин өнгөрөх өнгөрөх орнуудыг шилдэг туршлагыг хэрэгжүүлэх чиглэлээр хамтын ажиллагаагаа бэхжүүлэхийг уриалж байна. Үүнд дамжин өнгөрөх дэд бүтцийн хөгжлийн олон улсын стандартуудыг нэвтрүүлэх, төмөр замын царигийг уялдуулах замаар дамжин өнгөрөх, холболтыг сайжруулах асуудлыг багтаана.
176. Далайд гарцгүй болон дамжин өнгөрөх орнуудын дамжин өнгөрөх авто замын коридорыг хөгжүүлэх, одоо байгаа коридорыг шинэчлэх, арчлах, дутуу холболтыг нөхөхөд дэмжлэгээ нэмэгдүүлэхээ бид амлаж байна. Мөн эдгээр коридорын бүтээмжийг дээшлүүлэх, аюулгүй байдлыг сайжруулах, гишүүн орнуудын хооронд мэдээлэл хуваалцахыг хөнгөвчлөх зорилгоор мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглахыг уриалж байна.
177. Ерөнхий Ассамблей энэхүү Үйл ажиллагааны хөтөлбөрийг баталснаас хойш зургаан сарын дотор гишүүн орнууд, холбогдох олон улсын байгууллагууд, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагууд болон бие даасан шинжээчдээс бүрдэх өндөр түвшний шинжээчдийн зөвлөл байгуулахыг Ерөнхий нарийн бичгийн даргаас бид хүсэж байна. Энэ зөвлөл нь холбогдох олон улсын хууль, гэрээний хэрэгжилтийг судалж, саад тотгорыг тодорхойлж, олон улсын хууль, эрх зүйн хүрээнд далайд гарцгүй орнуудын дамжин өнгөрөх эрх чөлөөний хэрэгжилтэд зөвлөмж боловсруулна. Мөн уг зөвлөлийн тайлан, зөвлөмжийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 81 дүгээр чуулганы үеэр гишүүн орнуудад танилцуулахыг Ерөнхий нарийн бичгийн даргаас хүсэж байна.

178. Дэдбүтцийн хөрөнгө оруулалтын зориулалттай санхүүжилтийн тусгай механизм байгуулах боломжийг бид судлах бөгөөд энэ чиглэлд одоо байгаа санхүүгийн механизмд тулгуурлана. Энэхүү байгууллагыг хэрэгжүүлэх боломж, арга хэлбэрийн талаар судалж, НҮБ-ын 80 дугаар чуулганд тайлагнахыг Ерөнхий нарийн бичгийн даргаас мөн хүсэж байна.
179. Бүс нутгийн хөгжлийн банкнууд, Дэлхийн банкны групп болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын системийн холбогдох байгууллагуудыг далайд гарцгүй хөгжиж буй орнуудад нэмэлт санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлэхийг бид уриалж байна. Энэ нь тээврийн коридор дагуух дагалдах үйлдвэр, жижиг бизнесийн хөгжлийг хөхиүлэн дэмжих зорилготой.
180. Олон улсын хамтын нийгэмлэгийг далайд гарцгүй хөгжиж буй орнуудын агаарын тээврийн холболтыг сайжруулах арга хэмжээг дэмжихийг бид уриалж байна. Энэ нь худалдаа, аялал жуулчлал болон ажлын байр бий болгох чадавхыг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй.
181. Олон улсын иргэний нисэхийн байгууллагад (ОУИНБ) одоо хэрэгжүүлж буй техникийн дэмжлэг, чадавх бэхжүүлэх хөтөлбөр болон санхүүгийн түслалцааны үйл ажиллагаанд тулгуурлан, далайд гарцгүй орнуудын нисэхийн хэрэгцээ шаардлагыг хангахад туслахыг бид хүсэж байна.
182. Төмөр замын сүлжээ байгуулах болон сайжруулах чиглэлээр далайд гарцгүй хөгжиж буй орнуудад, ялангуяа одоогоор төмөр замын дэд бүтэцгүй орнуудад дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна.
183. Тээврийн коридоруудын байгууламж, удирдлага, засвар арчилгаанд шаардлагатай институцийн болон эрх зүйн тогтолцоог хөгжүүлэх, бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна. Үүнд уялдаа бүхий логиستيкийн систем, автомашины ачааллын жингийн стандарт, замын бүтэц, тэмдэг тэмдэглэгээ болон дүрэм журмыг нэг мөр болгох асуудал хамаарна.
184. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад дэд бүтэц болон үйлчилгээний засвар арчилгааны орлого бүрдүүлэх

тогтвортой механизм бий болгохыг дэмжинэ. Үүнд төлбөртэй авто зам (толл систем) зэрэг системийг нэвтрүүлэхийг бид уриалж байна.

185. Далайд гарцгүй орнууд болон тэдгээрийн хөгжлийн түншүүдийг хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар илүү үр ашигтай, чанартай, бат бөх, найдвартай, тогтвортой дамжин өнгөрөх тээврийн дэд бүтцийг хөгжүүлэхийг бид уриалж байна.
186. Далайд гарцгүй орнуудын дэд бүтцийн санхүүжилтийн чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна. Үүнд хөгжлийн банкнууд, хөгжлийн санхүүгийн байгууллагууд болон төр-хувийн хэвшлийн түншлэл, холимог санхүүжилт зэрэг хэрэгсэл, механизмыг ашиглах зэрэг орно.
187. Далайд гарцгүй болон дамжин өнгөрөх орнуудын санхүүгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэй, орон нутгийн иргэдийн дэмжлэг хүлээсэн дамжин өнгөрөх, тээврийн төслийг боловсруулах чадавхыг бэхжүүлэхээ бид амлаж байна. Үүнд бүс нутгийн интегралчлал болон олон талт механизмыг ашиглан хөрөнгө татах, төслийн үр ашгийг нэмэгдүүлэх арга барилыг багтаана.
188. Дэд бүтцийн санхүүжилт, төслийн бэлтгэл болон хэрэгжилтийн дэмжлэгийн талаар мэдлэг, түршлага солилцох, бүс нутгийн платформ, төслийн байгууллагууд болон холбогдох оролцогч талуудтай нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэхээ бид амлаж байна.
189. Далайд гарцгүй болон дамжин өнгөрөх орнуудын логиستيкийн хүндрэлийг бууруулах, авто замд хэт найдахаа багасгахын тулд олон төрлийн тээврийн горимын сүлжээг (multimodal transport network) хөгжүүлэхийг бид уриалж байна.
190. Улс орнуудын хил дамнасан хоолой нь эрчим хүч, тэр дундаа нүүрс устөрөгч болон тогтвортой эрчим хүчийг хол зайд үр ашигтай, хэмнэлттэй тээвэрлэх арга болохыг бид тэмдэглэж байна. Үндэсний, бүс нутгийн болон дэлхийн түвшинд найдвартай, тогтвортой эрчим хүчний холболтыг дэмжих олон улсын хамтын ажиллагааг үргэлжлүүлэх үүрэг бид хүлээж байна. Энэ нь эдийн засгийн интеграцчилал, тогтвортой

хөгжлийг ахиулах, ялангуяа Тогтвортой хөгжлийн 7 дугаар зорилго – бүх хүнд хүртээмжтэй, найдвартай, тогтвортой, орчин үеийн эрчим хүчний хүртээмжийг хангах – зорилгод хүрэхэд чухал ач холбогдолтой. Мөн уян хатан, аюулгүй хил дамнасан эрчим хүчний дэд бүтэц, холболтыг дэмжихийг бид уриалж байна.

191. Далайд гарцгүй орнуудад хуурай боомт байгуулахад туслахаа бид амлаж байна. Энэ нь тэдгээрийн холболтыг нэмэгдүүлж, бараа, үйлчилгээний урсгалыг идэвхжүүлэн, тээврийн зардал болон дамжин өнгөрөх хугацааг бууруулж, цаашдын эдийн засгийн өсөлтийг хөхиүлэн дэмжих болно.

II. Дижитал холболт

192. Мэдээлэл, харилцаа холбооны технологи, түүний дотор өндөр хурдны өргөн зурвасын интернетийн сүлжээ нь эдийн засгийн хөгжилд чухал үүрэгтэйг бид хүлээн зөвшөөрч байна. Мөн улс орнуудын хооронд болон дотоодын түвшинд оршин буй дижитал хэрэглээний ялгааг, түүнчлэн хот-хөдөөгийн, залуус-өндөр настнуудын, эрэгтэй-эмэгтэй хүмүүсийн дижитал хэрэглээний ялгааг арилгах нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудад өсөн нэмэгдэж буй цахим орчинд эдийн засгийн боломжийг бүрэн дүүрэн ашиглах нөхцөл бүрдүүлэхийг бид онцлон тэмдэглэж байна.
193. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын интернетийн өргөн зурвас ба далайн гүний кабельд нэвтрэхийн тулд хөрш болон эргийн орнуудаар дамжих шаардлагатай байдаг хамаарал нь интернетийн үйлчилгээний өртгийг нэмэгдүүлж, чанарыг бууруулж байгаад бид санаа зовниж байна.
194. Шударга хэлэлцээ болон өрсөлдөөнийг сайжруулах нь далайд гарцгүй орнууд далайн гүний кабельд нэвтрэх боломжийг хязгаарлаж буй бэрхшээлийг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулж, интернетийн өндөр өртгийг бууруулах боломжтойг бид дахин тэмдэглэж байна.
195. Бүс нутгийн түвшинд улс хоорондыг холбох, гэрээг цуцлах талаар нэгдсэн журам, зохицуулалт ерөнхийдөө байдаггүйг

бид харгалзан үзнэ. Үүний үр дүнд дамжин өнгөрөх оператор болон далайд гарцгүй орнуудын операторын хооронд хоёр талт хэлэлцээ хийгддэг бөгөөд энэ нь ихэвчлэн өндөр өртөгтэй нөхцөл байдал үүсгэдэг.

Зорилтууд:

- Далайд гарцгүй хөгжиж буй орнууд дахь мэдээлэл, харилцаа холбооны технологид нэвтрэх боломжийг хангалттай нэмэгдүүлэх, мөн бүх нийтийн хямд өртөгтэй интернетийн хүртээмжийг бий болгох.
- 2030 он гэхэд далайд гарцгүй орнуудыг оролцуулан дэлхий даяар бүх нийтийн интернетийн хүртээмжийг хангах, үүнд далайн гүний кабелиуд болон хиймэл дагуулд суурилсан интернетийн холболтыг багтаах.
- Дижитал, хүний нөөц болон институцийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг бүх эх үүсвэрээс үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж, дижитал дамжин өнгөрөх болон тээврийн дэд бүтцийг олон улсын таатай орчинд хөгжүүлэх.
- Далайд гарцгүй орнуудын дижитал холболт ба дижитал шилжилтийг өргөжүүлэх, ялангуяа холбогдох хамгийн хэцүү бүснутагуудад хүртээмжийг нэмэгдүүлэх, үүнд Partner2Connect санаачилгыг хэрэгжүүлэх.

Бид дараах арга хэмжээг авна:

196. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг олон улсын өндөр хүчин чадлын шилэн кабель болон интернетийн өргөн зурвасын сүлжээний хүртээмжийг сайжруулах зорилгоор үндэсний өргөн зурвасын бодлогыг боловсронгуй болгож, хэрэгжүүлэхийг бид уриалж байна. Энэ нь бүх нийтийн болон хямд өртөгтэй мэдээлэл, харилцаа холбооны технологийн үйлчилгээний хүртээмжийг хангах ерөнхий зорилго бүхий, боломжийн үнэтэй, чанартай харилцаа холбоог хөгжүүлэхэд чиглэнэ.
197. Мэдээлэл, харилцаа холбооны технологи, үүнд өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ, дижитал дэд бүтэц, мөн орчин үеийн,

хямд өртөгтэй харилцаа холбооны технологийг ашиглах чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Partner2Connect зэрэг хөтөлбөрийг ашиглан шаардлагатай чадавхыг хөгжүүлж, өргөжүүлэхээ бид амлаж байна.

198. Бүс нутгийн хэлэлцээрүүдийн хэрэгжилт болон уялдаа холбоо түүнчлэн дүрэм журмуудын нийцлийг хангаж зохицуулалтын уялдаа болон хэрэгжилтийг бэхжүүлж, бүс нутгийн гэрээ хэлэлцээрт нэгдэх стандартчилсан системийг хэрэгжүүлэхээ бид амлаж байна.
199. Хөгжлийн түншүүдийг далайд гарцгүй орнуудын бүх нийтийг интернетийн хүртээмжтэй байлгах хүчин чармайлтыг санхүүгийн болон техникийн туслалцаагаар дэмжихээ бид уриалж байна. Үүнд боломжит болон хямд өртөгтэй бүх хэлбэрийн холболтыг, тухайлбал далайн доорх кабель, хиймэл дагуулд суурилсан интернетийн холболтыг ашиглахыг багтаана.
200. Далайд гарцгүй орнуудын үндэсний чухал дэд бүтцийг хамгаалах болон мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн аюулгүй байдлыг хангах чадавхыг нэмэгдүүлэхээ бид амлаж байна. Энэ нь тогтвортой байдлыг дээшлүүлж, эмэгтэйчүүд, хүүхдүүдийг оролцуулсан бүх нийтийн аюулгүй байдлыг хангаж, үндэсний тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулна. Мөн онлайнаар болон оффлайнаар эдэлж буй хүний эрх адилхан хамгаалагдах ёстойг бид онцлон тэмдэглэж байна.
201. Далайд гарцгүй орнуудад дижитал дэд бүтэц болон өгөгдлийн төвийн хүчин чадлыг өргөтгөх чиглэлээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийг бид дэмжинэ. Үүнд шинэ, дэвшилтэт технологиуд болох хиймэл дагуулын технологи, мөн оролцогчдын хамтын сүлжээ зэрэг инновацлаг хандлагыг ашиглан утга учиртай, хүртээмжтэй холболтоор хангахыг багтаана.

III. Эрчим хүч

202. Боломжийн үнэтэй, найдвартай, тогтвортой, орчин үеийн эрчим хүчний дэд бүтэц, үүнд хил дамнасан дэд бүтэц, эрчим хүчний түгээлт ба холболтын дэд бүтцийг багтаан, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, үйлдвэрлэлийн чадавхыг бий болгох нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хөгжлийг хангахад нэн чухал болохыг бид хүлээн зөвшөөрч байна. Мөн далайд гарцгүй хөгжиж буй орнууд сүүлийн жилүүдэд боломжийн үнэтэй, найдвартай, тогтвортой, орчин үеийн эрчим хүчний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр гаргасан ахиц дэвшлийг бид сайшааж байна.
203. Бүх хүнд боломжийн үнэтэй, найдвартай, тогтвортой, орчин үеийн эрчим хүчний хүртээмжийг хангах шилжилт нь шударга, хүртээмжтэй, тэгш, аюулгүй байх ёстойг, мөн энэ нь улс орнуудын үндэсний нөхцөл байдалтай уялдсан байх шаардлагатайг бид хүлээн зөвшөөрч байна.
204. Байгалийн хий нь бага ялгаруулалттай эрчим хүчний систем рүү шилжих үйл явцыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж чадахыг бид хүлээн зөвшөөрч байна. Тиймээс Засгийн газруудыг эрчим хүчний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамтран ажиллах, хий нийлүүлэлт, эрэлт хэрэгцээ, аюулгүй байдлын талаар түршлага, мэдлэг солилцох зэргээр хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэхийг бид уриалж байна.
205. Сүүлийн жилүүдэд боломжийн үнэтэй, найдвартай, тогтвортой, орчин үеийн эрчим хүчний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд ахиц гарсан хэдий ч далайд гарцгүй хөгжиж буй орнуудад 215 сая хүн найдвартай эрчим хүчгүй амьдарч байгаад бид санаа зовниж байна. Энэ нь нийт хүн амын ойролцоогоор 40 хувийг эзэлж байна. Мөн 2021 оны байдлаар эдгээр орнуудын эцсийн нийт эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний орчин үеийн эх үүсвэрийн эзлэх хувь ердөө 12 хувь байгаа нь хангалтгүй ахиц дэвшилтэй байна.
206. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад хот ба хөдөөгийн эрчим хүчний хүртээмжийн зөрүү маш их байгаад цаашид анхаарал хандуулах шаардлагатайг бид онцолж байна. 2020

онд хотуудын 88 хувь, харин хөдөө орон нутгийн 46 хувь нь цахилгаанд холбогдсон байв.

Зорилтууд:

- 2030 он гэхэд бүх хүнд боломжийн үнэтэй, найдвартай, тогтвортой, орчин үеийн эрчим хүчний үйлчилгээг хүргэхэд чиглэсэн дэд бүтцийг өргөжүүлж, технологийг шинэчлэх.
- Эрчим хүчний шударга, хүртээмжтэй, тэгш, аюулгүй шилжилтийг түргэтгэхийн тулд далайд гарцгүй хөгжиж буй орнуудад харилцан тохиролцсон нөхцөлөөр технологи хөгжүүлэлт ба шилжилтийг дэмжих.
- Эрчим хүчний шилжилтийн явцад завсрын түлш (transitional fuels) эрчим хүчний аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгэж болохыг хүлээн зөвшөөрөх.
- 2030 он гэхэд далайд гарцгүй бүх хөгжиж буй орнуудад боломжийн үнэтэй, найдвартай, орчин үеийн эрчим хүчний үйлчилгээг бүх нийтэд хүртээмжтэй болгох.
- Бүс нутгийн нэгдсэн эрчим хүчний системийг хөгжүүлж, эрчим хүчний төлөвлөлт ба нэгдсэн системийн ажиллагаанд нийцсэн тодорхой, хэмжигдэхүйц стандартыг бий болгох.
- Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад цэвэр болон сэргээгдэх эрчим хүчийг санхүүжүүлэхэд чиглэсэн дэмжлэгийг нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, худалдаа, түгээлтийн чадавхыг бэхжүүлэх.
- 2030 он гэхэд тогтвортой хөгжлийн зорилт 7-т нийцүүлэн бохир бус цэвэр түлшээр хоол хийх бүх нийтийн хүртээмжийг хангах.

Бид дараах арга хэмжээг авна:

207. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад боломжийн үнэтэй, найдвартай, тогтвортой, орчин үеийн эрчим хүчийг дэмжих зорилгоор үндэсний эрчим хүчний бодлогоо бэхжүүлж, шинэ нөхцөлд нийцүүлэхийг бид уриалж байна. Үүгээр дамжуулан үйлдвэрлэл, худалдаа, түгээлтийн чадавхыг мэдэгдэхүйц сайжруулж, бүх хүнд эрчим хүчний хүртээмжийг хангах, эдийн засгийн бүтцийг шинэчлэхийг зорьж байна.

208. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад цэвэр болон сэргээгдэх эрчим хүчний бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах чадавхыг сайжруулах, мөн эрчим хүчний төслүүдэд санхүүжилт татахуйц төслүүд боловсруулахад дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна.
209. Эдгээр орнуудад байгаа дэд бүтцийг хадгалах, шаардлагатай тохиолдолд өргөтгөх, шинэчлэх замаар хот, хөдөөгийн аль алинд нь боломжийн үнэтэй, найдвартай, орчин үеийн эрчим хүчний үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийг бид амлаж байна.
210. 2030 он гэхэд нэг хүнд ногдох цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг хоёр дахин нэмэгдүүлэх зорилгоор санхүүгийн болон техникийн туслалцаа үзүүлэхээр бид зорьж байна. Үүний зэрэгцээ эрчим хүчний бүтцэд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг мэдэгдэхүйц нэмэгдүүлэхийг зорьдог.
211. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад шинэлэг эрчим хүчний төслийг хэрэгжүүлэхийг тэргүүлэх чиглэл болгохыг бид уриалж байна. Үүнд хоёр талт болон бүс нутгийн хамтын ажиллагааг ашиглан эрчим хүчний "superhighway"-г хөгжүүлэх, мөн далайд гарцгүй болон дамжин өнгөрөх орнуудын хил дамнасан эрчим хүчний худалдаа, тээвэрлэлтэд хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэхийг дэмжинэ.
212. Далайд гарцгүй орнуудын эрчим хүчний холболтыг нэгдсэн цахилгаан сүлжээ болон хил дамнасан холболтоор хөгжүүлэхээ бид амлаж байна. Энэ нь цахилгааны үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлэх, инновацыг дэмжих, санхүүжилтийг хөнгөвчлөхөд чиглэнэ. Үүнтэй холбогдуулан бид үйл ажиллагаа, төлөвлөлт, зохицуулалт, санхүүгийн журмуудыг уялдуулах, мөн туршлага солилцохыг уриалж байна.
213. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад цэвэр ба сэргээгдэх эрчим хүчийг дэмжих инновацлаг шийдэл боловсруулах, эрчим хүчний үйлдвэрлэл, худалдаа, түгээлтийн чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн санхүүжилтийг нэмэгдүүлэх хүчин чармайлтыг бид дэмжинэ.
214. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх зорилгоор таатай орчныг бүрдүүлэх, үүнд зохих хууль, бодлогын шинэчлэл

хийхээ бид амлаж байна. Энэ нь цэвэр ба сэргээгдэх эрчим хүч, үйлдвэрлэл, худалдаа, түгээлтийн чадавхыг хөгжүүлэхэд онцгой ач холбогдолтой.

215. Хөгжлийн түншүүд, олон улсын болон бүс нутгийн хөгжлийн банкнууд, бусад холбогдох байгууллагуудыг далайд гарцгүй орнуудад дэд бүтцийн хөрөнгө оруулалтаа мэдэгдэхүйц нэмэгдүүлэхийг бид уриалж байна. Үүнд шаардлагатай тохиолдолд хил дамнасан цахилгаан сүлжээний холболтоор эрчим хүчний системийг бэхжүүлэх, төвлөрсөн бүс цэвэр ба сэргээгдэх шийдлийг эрчим хүчний төлөвлөлтөд тусгах, мөн эрчим хүчний шилжилт бүс нутгаас хамаарч ялгаатай замаар явагдана гэдгийг хүлээн зөвшөөрөхийг уриалж байна.
216. Бохир бүс цэвэр түлшээр хоол хийх, технологид нэвтрэх боломжийг тэргүүлэх чиглэл болгохоо бид амлаж байна. Үүнд цахилгаан, цэвэр түлшний хүртээмжийн хязгаарлагдмал байдал, орлогын хүндрэл зэрэг дэд бүтцийн болон санхүүгийн саад тотгорыг арилгах, жендерийн тэгш байдлыг хангах, холбогдох зан үйлийн болон соёлын хүчин зүйлсийг харгалзан үзэхийг хичээнэ.

Тэргүүлэх чиглэл 4: Уур амьсгалын өөрчлөлт ба гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх, уян хатан байдлыг бэхжүүлэх, эмзэг байдлыг бууруулах

217. Далайд гарцгүй хөгжиж буй 32 орны хүлэмжийн хийн нийт ялгаруулалт нь дэлхийн хэмжээний ялгаруулалтын ердөө 1.9 хувьтай тэнцэж байгаа хэдий ч эдгээр орнууд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлд өртөмтгий бөгөөд элэгдэл, цөлжилт, ойн доройтол, газрын эвдрэл, ган, хэт халалт, ойн түймэр, үер, уулын мөсний хайлалт, мөсөөр хучигдсан нуурын дэлбэрэлтээс үүдсэн үер, хөрсний гүлгалт зэрэг олон сөрөг үр дагавартай нүүр тулж байгааг бид хүлээн зөвшөөрч байна. Одоогоор эдгээр орнуудын газрын 54 хувь нь хуурай бүсэд, харин тэдгээрийн хүн амын 60 хувь нь эдгээр хуурай бүс нутагт оршин сууж байна. Үүнээс гадна далайд гарцгүй олон орон нь уулын орнууд бөгөөд энэ нь тэднийг уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтлын нөлөөнд улам өртөмтгий болгож байна. Гэсэн хэдий ч эдгээр орнууд нь институцийн, техникийн болон санхүүгийн чадавх султай, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс үүдэх сорилтыг шийдвэрлэхэд хүндрэлтэй хэвээр байна.
218. Уур амьсгалын өөрчлөлт болон байгалийн гамшиг нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудад амьжиргаа, эдийн засаг, дэд бүтэц, суурьшлын бүс болон бусад үнэт хөрөнгөнд ноцтой нөлөө үзүүлж байгаад бид санаа зовниж байна. Эдгээр нөлөөлөлөнхэвчлэндарааландавтагдаж, өлсгөлөн, халдварт өвчин зэрэг хоёрдогч үр дагавар үүсгэдэг бөгөөд биологийн төрөл зүйлийн хомсдолыг улам дордуулж байна. Хуурай болон хагас хуурай бүс нутагт уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө нь хөдөө аж ахуйн бүтээмжийг бууруулж, түүнтэй хавсарсан усны хомсдолоор улам нэмэгдэх хандлагатай байна.
219. Уур амьсгалын өөрчлөлт болон системийн эрсдэлтэй холбоотой гамшгийн эрсдэлийн ойлголтыг бэхжүүлэх зорилгоор түншлэл, хамтын ажиллагааг бид дэмжиж байна. Үүнд гамшгийн эрсдэлийн боловсрол, цогц эрсдэлийн

удирдлага, эрдэм шинжилгээний болон шинжлэх ухааны чадавхыг бэхжүүлэх, дэвшилтэт технологийг ашиглах, уламжлалт, уугуул болон орон нутгийн мэдлэг, дадлыг дэмжих зэргийг багтаана.

220. Уур амьсгалын санхүүжилт, ялангуяа дасан зохицолтод чиглэсэн санхүүжилт нь одоогоор хөгжиж буй орнуудын нэмэгдэж буй хэрэгцээнд хангалтгүй байгаад бид санаа зовниж байна. Гэсэн хэдий ч олон хөгжингүй орон Дасан зохицолтын сан, Нэн буурай хөгжилтэй орнуудын сан, Ногоон уур амьсгалын сан зэрэг эх сурвалжаар дамжуулан уур амьсгалын санхүүжилтээ нэмэгдүүлэх амлалтаа өгч, өмнөх үеийн хүчин чармайлттай харьцуулахад чухал ахиц гаргасныг сайшаан тэмдэглэж байна. Бид Глазгогийн Уур амьсгалын Гэрээнд заасан ёсоор, хөгжингүй орнууд 2025 он гэхэд 2019 оны түвшнээс уур амьсгалын дасан зохицлын санхүүжилтээ дор хаяж хоёр дахин нэмэгдүүлэх ёстойг бид дахин онцолж байна. Энэ нь санхүүгийн нөөцийн хэмжээг нэмэгдүүлэхдээ бууралт ба дасан зохицолтын хооронд тэнцвэрийг хангах зорилготой юм. Мөн дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх, уян хатан байдлыг бэхжүүлэх, эмзэг байдлыг бууруулахын тулд шинжлэх ухаанд суурилсан арга хэмжээ, дэмжлэг, санхүүжилт, чадавх бэхжүүлэх, технологи дамжуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатайг бид онцлон тэмдэглэж байна. Энэ нь хөгжиж буй орнуудын нэн тэргүүний хэрэгцээ, тэргүүлэх чиглэлтэй нийцсэн байх ёстой. Үүнтэй холбогдуулан бид Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд дэлхий дахины дасан зохицлын зорилгын чухлыг хүлээн зөвшөөрч байна.
221. Далайд гарцгүй хөгжиж буй орнууд НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенцын хүрээнд эдгээр орнуудад зориулагдсан тусгай ажлын хөтөлбөр боловсруулах сонирхол, эрмэлзэлтэй байгааг бид тэмдэглэж байна.
222. НҮБ-ын Далайд гарах эрх зүйн тухай конвенцын хүрээнд батлагдсан “Үндэсний харьяаллын гаднах бүс нутгийн далайн биологийн төрөл зүйлийг хамгаалах, тогтвортой ашиглах тухай хэлэлцээрийг” бид тэмдэглэж байна.¹³

13 A/CONF.232/2023/4, “Тээвэр, худалдаа, бүс нутгийн нэгтгэлийн талаархи бүс

223. Далайд гарцгүй хөгжиж буй орнууд нь шударга, тогтвортой, хүртээмжтэй шилжилтийг дэмжихэд нэн чухал ашигт малтмалын нөөцтэй болохыг бид онцолж байна. Эдгээр ашигт малтмал нь эдийн засгийн олон талт хөгжил, бүтцийн өөрчлөлт, аж үйлдвэржилт, ядуурал болон тэгш бус байдлыг бууруулах шинэ боломжийг олгож байгаа хэдий ч, эдгээр нөөцийг ашиглах явцад үүсэх байгаль орчин болон нийгмийн сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах шаардлагатайг онцолж байна.
224. Парисын хэлэлцээрийн бүх талууд, тэр дундаа бүх далайд гарцгүй хөгжиж буй орнууд үндэсний тодорхойлсон хувь нэмрүүдээ (NDCs) илгээж, температуртай холбоотой зорилгод хүрэх чиглэлд ахиц гаргасныг бид сайшааж байна. Эдгээр хувь нэмрийн ихэнх нь ил тод байдал, ойлголт, тайлбарлах чадварыг хангахад шаардлагатай мэдээллийг өгчээ.
225. Парисын хэлэлцээртэй нийцүүлэн ялгарлыг бууруулах дотоодын арга хэмжээг түргэтгэх шаардлагатайг бид онцлон тэмдэглэж байна.
226. Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан ёсоор, зах зээлээс гадуурх арга хэмжээг тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулах хүрээнд цогц, уялдаа холбоотой, тэнцвэртэй байдлаар хэрэгжүүлэх шаардлагатайг бид онцолж байна. Үүнд ялгарлыг бууруулах, дасан зохицох, санхүүжилт, технологи дамжуулах болон чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа хамрагдана.
227. Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд онцгой өртөмтгий хөгжиж буй орнуудад бууралт болон дасан зохицолтод чиглэсэн хүчин чармайлтыг дэмжихийн тулд олон улсын уур амьсгалын санхүүжилтэд хялбар, өргөтгөсөн хүртээмжтэй байх нь чухал болохыг бид хүлээн зөвшөөрч байна. Мөн бид энэ чиглэлээр хийгдэж буй цаашдын хүчин чармайлтуудыг чухалчилж байна.

I. Дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх

228. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад үзүүлэх дэмжлэгийг өргөжүүлэх, үр нөлөөг нь нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн улам бүр дордож буй нөлөөлөлд тэсвэртэй байдлыг бэхжүүлэх, Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын хэрэгжилтийн ахиц дэвшлийг хамгаалах, мөн шинэ Үйл ажиллагааны хөтөлбөрийн бусад тэргүүлэх чиглэлийн хэрэгжилтийг дэмжих нь нэн чухал болохыг бид онцолж байна.

Зорилтууд:

- Далайд гарцгүй хөгжиж буй орнууд 2025 он гэхэд одоогоор хэрэгжүүлээгүй байгаа үндэсний дасан зохицох төлөвлөгөө, бодлого, төлөвлөлтийн үйл явцыг бий болгож, 2030 он гэхэд тэдгээрийн хэрэгжилтэд ахиц гаргасан байна.
- Уур амьсгалд дасан зохицох дэлхийн зорилт болон “Арабын Нэгдсэн Эмират Улсын дэлхийн уур амьсгалын нөлөөлөлд тэсвэртэй байх хөтөлбөр”-ийн дагуу, шаардлагатай тохиолдолд, далайд гарцгүй хөгжиж буй орнуудад дасан зохицох төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлнэ.

Бид дараах арга хэмжээг авна:

229. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад үндэсний дасан зохицох стратеги боловсруулах болон хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхээр бид амлалт авч байна. Үүнд үндэсний дасан зохицох төлөвлөгөөг боловсруулах, улмаар уг төлөвлөгөөнд тусгагдсан бодлого, хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг дэмжих орно. Энэ нь уур амьсгалд дасан зохицох дэлхийн зорилт болон “Арабын Нэгдсэн Эмират Улсын дэлхийн уур амьсгалын нөлөөлөлд тэсвэртэй байх хөтөлбөр”-тэй нийцсэн байна.

230. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад тээвэр, эрчим хүч, эрүүл мэнд, боловсрол, ус, цахилгаан, мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн уур амьсгалын нөлөөлөлд тэсвэртэй байдлыг хангах төслүүдийг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүргээ бид дахин тэмдэглэж байна.

II. Гамшгийн эрсдэлийг бууруулах

231. Уур амьсгалын өөрчлөлт нь байгалийн аюулт үзэгдлийн давтамж болон хүчийг нэмэгдүүлж байгаад бид санаа зовниж байна. Далайд гарцгүй хөгжиж буй орнууд үер, хэт халалт, шуурга, ган гачиг, цэвдэгт нуурын үер зэрэг үзэгдэлд улам бүр өртөж байна. Зарим орон газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд байрладаг бөгөөд үүнээс үүдсэн хөрсний гулсалт зэрэг хоёрдогч аюул нь дэд бүтэц, өмч хөрөнгө, эрүүл мэнд, ариун цэвэрт хохирол учруулж, хүний амь нас хохирох нөхцөл бүрдүүлдэг. Эдгээр улс орнууд гамшгийн хүндрэл, эдийн засгийн хохирлыг их хэмжээгээр хүлээдэг бөгөөд энэ нь COVID-19 цар тахал болон бусад хямралын нийгэм, эдийн засгийн үр дагаврыг улам гүнзгийрүүлж байна.
232. 2013–2022 оны хооронд гамшгийн нас баралтын дундаж түвшин тайлагнасан далайд гарцгүй хөгжиж буй орнуудад жил бүр 100,000 хүн тутамд 2.12 байсан нь дэлхийн дунджаас (1.15) хоёр дахин өндөр байв. Мөн эдгээр орнууд дэлхийн нийт дотоодын нийт бүтээгдэхүүний 1.05 хувийг эзэлдэг атлаа дэлхий нийтэд бүртгэгдсэн эдийн засгийн хохирлын 4.14 хувийг дангаараа бүрдүүлсэн байна. 2022 онд тэнгисийн гарцгүй хөгжиж буй орнуудын зөвхөн 59 хувь нь олон төрлийн аюулын эрт анхааруулах системтэй байсан гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна. Ийм системүүд нь байгалийн гамшгаас үүдэлтэй нас баралт болон эдийн засгийн хохирлыг бууруулах хамгийн үр дүнтэй аргуудын нэг юм.
233. Гамшгийн бэлэн байдлыг хангахын тулд эрт сэрэмжлүүлэх хүчирхэг системийн ач холбогдлыг дахин онцолж тэдгээрийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ эрт арга хэмжээ авахыг дэмжих шаардлагатайг бид онцолж байна. “Бүгдэд зориулсан эрт сэрэмжлүүлэг” санаачилгын хүрээнд дэлхий дээрх хүн бүрийг цаг уур, ус, уур амьсгалын аюулт үзэгдлээс хамгаалах зорилгоор, эрт сэрэмжлүүлэх систем хангалтгүй байгаа далайд гарцгүй хөгжиж буй орнуудад онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна. Мөн “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн хүрээ 2015–2030”-д заасан тэргүүлэх чиглэл, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд орон нутгийн,

үндэсний болон бүс нутгийн стратеги, платформыг хөгжүүлэх, бэхжүүлэх, хэрэгжүүлэх шаардлагыг бид онцлон тэмдэглэж байна.

234. Олон төрлийн аюулын эрт сэрэмжлүүлэх системийн хамрах хүрээ болон хүртээмж, ялангуяа эмзэг бүлгийн хувьд хангалтгүй байгаад бид гүнээ санаа зовниж, эдгээр системийн хүртээмжийг нэн яаралтай өргөжүүлэх шаардлагатайг тэмдэглэж байна.
235. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан бэлэн байдал хангах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хүн амын амьжиргаа, амь насыг хамгаалах, үндэсний нэгдсэн санхүүгийн тогтолцоог цогцоор нь бүрдүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, эмзэг байдлыг тогтвортойгоор бууруулах урамшуулал бүхий шинэ санхүүжилтийн арга хэлбэрийг ашиглахыг бид уриалж байна.

Зорилтууд:

- “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн хөтөлбөр 2015–2030”-ийг бүрэн хэрэгжүүлэх замаар далайд гарцгүй хөгжиж буй орнуудад гамшгийн эрсдэлийг бууруулах, түүнчлэн “Сендайн үйл ажиллагааны хүрээ”-ний дунд хугацааны үнэлгээний дээд түвшний уулзалтын улс төрийн тунхаглал¹⁴-д тусгагдсан уриалгыг хэрэгжүүлэх.
- Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын бодлогод гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг тусгах.
- “Сендайн үйл ажиллагааны хүрээ”-ний тэргүүлэх чиглэл, зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд орон нутгийн, үндэсний болон бүс нутгийн стратеги, платформуудыг хөгжүүлэх, бэхжүүлэх.
- Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад зориулсан аюулыг эрт сэрэмжлүүлэх иж бүрэн олон төрлийн систем болон хямралын менежмент, тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээг дэмжих, бэхжүүлэх.

14 Ерөнхий Ассамблейн 77/289 дугаар тогтоол, хавсралт.

Бид дараах арга хэмжээг авна:

236. Гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг далайд гарцгүй хөгжиж буй орнуудын эдийн засгийн шинэчлэлийн хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын үндэс болгох үүрэг бид хүлээж байна.
237. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн гамшгийн эсрэг бэлэн байдлыг хангахын тулд эрт сэрэмжлүүлэх системийг бэхжүүлэх, мөн “Бүгдэд зориулсан эрт сэрэмжлүүлэг” санаачилгын тэргүүлэх үлс орнуудын дундаас далайд гарцгүй орнууд хоцрохгүй байхад анхаарал хандуулах амлалт бид авч байна.
238. Олон талт, иж бүрэн эрсдэлийн үнэлгээ хийхээ бид амлаж байна. “Сендайн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нь эмзэг байдал, өртөмтгий байдлын шалтгааныг бууруулах, уур амьсгалын нөлөөллийг тэсвэртэй даван туулах чадварыг нэмэгдүүлэх, хүмүүнлэгийн нөлөөлөл, хэрэгцээг багасгахад чухал хувь нэмэр оруулна.
239. Хөгжлийн түншүүдийг чадавхыг бэхжүүлэх, санхүүгийн болон техникийн туслалцаа үзүүлэх, харилцан тохиролцсон нөхцөлөөр технологи дамжуулах замаар далайд гарцгүй хөгжиж буй орнуудын гамшгийн талаарх мэдээллийг цуглуулах, шинжлэх, түгээх чадварыг нэмэгдүүлэх, үндэсний статистик болон төлөвлөлтийн байгууллагуудын үүргийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг бид уриалж байна.
240. Хувийн хэвшил болон даатгалын зах зээлийг гамшгийн эрсдэлийн санхүүжилтийн механизмыг боловсруулах, эрсдэлийг бууруулах чиглэлд чиглэсэн инновацлаг, тогтвортой санхүүжилтийн шийдлүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг бид уриалж байна.
241. Олон улсын валютын сан, Дэлхийн банкны групп болон бусад бүс нутгийн хөгжлийн банкнуудыг шийдвэр гаргах, өрийн тогтвортой байдлын үнэлгээнд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын эмзэг байдал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг тусгахыг бид уриалж байна.

242. Хөгжлийн түншүүд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох байгууллагууд, олон улсын санхүүгийн байгууллагууд, хөгжлийн банкууд, хувийн хэвшил болон сангуудыг хамтран ажиллаж, далайд гарцгүй хөгжиж буй орнуудад үндэсний гамшгийн эрсдэлийг бууруулах стратеги боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг бид хүсэж байна.

III. Уур амьсгалын санхүүжилт

243. Хөгжиж буй далайд гарцгүй орнуудад уур амьсгалын өөрчлөлтийн дасан зохицол болон бууралттай холбоотой дэмжлэг, санхүүжилт Дэлхийн байгаль орчны сан, Ногоон уур амьсгалын сан зэрэг эх үүсвэрээс олгогдож ирсэн хэдий ч, санхүүгийн хэрэгцээ өндөр хэвээр байсаар байна.

244. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенц болон Парисын хэлэлцээрийн дор байгуулагдсан Технологийн механизм нь Технологийн Гүйцэтгэх хороо болон Уур амьсгалын технологийн төв, сүлжээнээс бүрддэг бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэхэд чиглэсэн технологийн хөгжүүлэлт, дамжуулалтыг дэмжих, хөнгөвчлөхөд чухал үүрэг гүйцэтгэж байна.

245. Чадавхыг бэхжүүлэх Парисын хороо нь уур амьсгалын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, цаашид боловсронгуй болгоход шаардагдах чадавхыг нэмэгдүүлэх, улмаар далайд гарцгүй хөгжиж буй орнууд зэрэг онцгой нөхцөлтэй улс орнуудын хэрэгцээ, зөрүүг арилгах чухал хэрэгсэл болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Зорилтууд:

- Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад дасан зохицох санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх.
- Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх чиглэлээр чадавх бэхжүүлэлт, технологи дамжуулалтыг өргөжүүлэх.

Бид дараах арга хэмжээг авна:

246. Парисын хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар, хэлэлцээрт нэгдсэн хөгжингүй улс орнууд Конвенцын дагуу хүлээсэн үүргээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хүрээнд хөгжиж буй улс орнуудад гамшгийг арилгах болон дасан зохицлын чиглэлээр санхүүжилт олгох ёстойг бид дахин тэмдэглэн дурдаж байна.
247. Түүнчлэн Парисын хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар, бусад талууд ийм дэмжлэгийг сайн дурын үндсэн дээр үзүүлэх, эсвэл үргэлжлүүлэн үзүүлэхийг уриалсныг бид эргэн санаж байна.
248. Цаашилбал, Парисын хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар, дэлхий нийтийн хүчин чармайлтын нэг хэсэг болгон хөгжингүй орнууд өргөн хүрээний эх үүсвэр, хэрэгсэл, сүвгуудаар дамжуулан уур амьсгалын санхүүжилтийг татан төвлөрүүлэх үйл явцад тэргүүлэх үүрэг гүйцэтгэх ёстой бөгөөд энэ нь өмнөх хүчин чармайлтаас илүү ахиц гаргах ёстойг бид тэмдэглэж байна.
249. Парисын хэлэлцээрийн дагуу далайд гарцгүй хөгжиж буй орнуудад үзүүлж буй санхүүгийн дэмжлэг, технологи дамжуулалт, чадавх дээшлүүлэх талаарх мэдээллийг тогтмол гаргаж байх үүргээ биелүүлэхээ бид амлаж байна.
250. Дунд болон урт хугацааны дасан зохицлын хэрэгцээг хангахын тулд далайд гарцгүй хөгжиж буй орнуудад дасан зохицлын төлөвлөлт, хэрэгжилтэд зориулсан чадавх дээшлүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэхийн төлөө үргэлжлүүлэн ажиллахаа бид амлаж байна.
251. 2023–2027 оны “Уур амьсгалын технологийн төв, сүлжээний санхүүжилт ба түншлэлийн стратеги”-ийг хэрэгжүүлэх замаар далайд гарцгүй хөгжиж буй орнуудын уур амьсгалын технологийн хэрэгцээг хангах үйл ажиллагааг дэмжихээ бид амлаж байна.
252. Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох агентлагууд болон олон улсын болон бүсийн хөгжлийн, санхүүгийн

байгууллагуудыг бүх салбар дахь уур амьсгалын үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах төслүүдэд хөрөнгө оруулалт хийх чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр далайд гарцгүй хөгжиж буй орнуудад дэмжлэг үзүүлэхийг бид уриалж байна.

IV. Уур амьсгалд тэсвэртэй дэд бүтцийн хөгжил

253. Уур амьсгалын өөрчлөлтөөр улам бүр сэдрэгдэж буй гамшиг нь төмөр зам, авто зам, усан цахилгаан станц болон эрчим хүчний бусад дэд бүтэц, орон сууц, сургууль, эмнэлэг болон олон нийтийн барилгуудыг муутгаж, худалдаа, эрчим хүч, тээврийн чухал харилцааны гол шугам болох олон улсын усан замыг гэмтээж, ингэснээр далайд гарцгүй хөгжиж буй орнуудын тогтвортой хөгжлийн хүчин чармайлт, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварт шууд саад тотгор болж байна.
254. Чанартай, найдвартай, тогтвортой, уур амьсгалын болон гамшгийн эрсдэлд тэсвэртэй дэд бүтэц нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудад тогтвортой хөгжлийг дэмжих, мөн гамшгаас үүдэх сүйрэл, доголдлоос урьдчилан сэргийлэх боломжтойг бид тэмдэглэж байна. Энэ нь "Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн хөтөлбөр 2015–2030" болон Тогтвортой хөгжлийн зорилгуудын, ялангуяа 9 дүгээр зорилтын "тэсвэртэй дэд бүтэц" зорилтуудтай нийцэж байна.

Зорилтууд:

- Гамшиг болон уур амьсгалын эрсдэлийн шинжилгээг уур амьсгалд тэсвэртэй дэд бүтцийн хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болгох.
- Тээвэр, эрчим хүч, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт үндэсний болон бүс нутгийн хэмжээнд нэгдсэн, чанартай, найдвартай, тогтвортой, уур амьсгалын болон гамшгийн эрсдэлд тэсвэртэй дэд бүтцийг байгуулах, засварлах, арчлах чиглэлээр санхүүгийн болон техникийн туслалцааг үргэлжлүүлэн олгох.

Бид дараах арга хэмжээг авна:

255. Тогтвортой, уур амьсгалд тэсвэртэй дэд бүтцийн хөгжлийн салшгүй хэсэг болгон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг оролцуулсан гамшгийн эрсдэлийн дүн шинжилгээг сайжруулах, мөн Тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдуулан төслийн хэрэгжилтийг хянах системийг бий болгох үүрэг бид хүлээж байна.
256. Бүс нутгийн хэмжээнд нэгдсэн, тогтвортой, уур амьсгал болон гамшгийн эрсдэлд тэсвэртэй тээвэр, эрчим хүч, мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлэхээ бид амлаж байна. Хөгжлийн түншүүд, түүний дотор олон улсын хөгжлийн банкуудыг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд улам эмзэг болж буй дэд бүтцийг барьж байгуулах, хадгалах чиглэлээр далайд гарцгүй хөгжиж буй орнуудад нөөц хөрөнгө гаргахыг бид уриалж байна.

V. Алдагдал ба хохирол

257. Уурамьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, эсвэл дасан зохицох арга хэмжээний хүрээнээс давсан сөрөг үр дагавар нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудад газарзүйн байршил, нийгэм-эдийн засгийн болон хөгжлийн түвшний шалтгаанаар онцгой хүндээр тусч байгааг бид гүнээ санаа зовнин тэмдэглэж, ийм асуудлыг шийдвэрлэхэд дэлхий нийтийн эв санаа, хамтын ажиллагаа шаардлагатайг онцлон тэмдэглэж байна.
258. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенцын талуудын бага хурлын 28 дугаар чуулган болон Парисын хэлэлцээрийн талуудын бага хурлын тавдугаар хуралдаанаар баталсан шийдвэрийг, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд онцгой өртөмтгий хөгжиж буй орнуудад туслах зорилго бүхий шинэ санхүүжилтийн зохицуулалт, тэр дундаа “Алдагдал ба хохирлын сан”-г байгуулсан шийдвэрийг бид сайшаан хүлээн авч байна.

Зорилт:

- Алдагдал ба хохиролд хариу арга хэмжээ авах шинэ санхүүжилтийн зохицуулалт, тэр дундаа сангийн хүрээнд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хэрэгцээ, тэргүүлэх чиглэл, эмзэг байдлыг тусгахыг дэмжих.

Бид дараах арга хэмжээг авна:

259. Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд онцгой өртөмтгий хөгжиж буй орнуудад эдийн засгийн болон эдийн засгийн бус алдагдал, хохиролд хариу арга хэмжээ авахад шаардлагатай шинэ, нэмэлт, урьдчилан таамаглах боломжтой, хангалттай санхүүгийн нөөцийн нэн яаралтай хэрэгцээг бид хүлээн зөвшөөрч байна. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенцын талуудын бага хурал болон Парисын хэлэлцээрийн талуудын бага хурлын шийдвэрийг яаралтай хэрэгжүүлэхийг бид амлаж байна. Ингэснээр уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд онцгой өртөмтгий орнууд, тэр дундаа далайд гарцгүй хөгжиж буй орнууд тус санд нэн даруй хандах боломжтой болох юм.

VI. Биологийн төрөл зүйлийн хомсдол

260. Далайд гарцгүй хөгжиж буй олон орнууд биологийн төрөл зүйлээр баялаг бөгөөд байгалийн ихээхэн нөөцтэйг бид тэмдэглэж байна. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын эдийн засаг нь байгалиас бий болдог бараа, үйлчилгээний хангамжаас ихээхэн хамааралтай гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна. Биологийн төрөл зүйл болон эрүүл экосистем нь эдийн засгийн олон төрлийн үйл ажиллагаа, хүнсний баталгаат байдал, хүнсний тэжээллэг чанар, нийгмийн үйлчилгээ зэрэгт зайлшгүй шаардлагатай нөөцийг хангаж өгдөг. Гэвч далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хувьд экосистемийн доройтол, биологийн төрөл зүйлийн хомсдол ноцтой түвшинд хүрч байгаа нь санаа зовоох асуудал юм. Тухайлбал, далайд гарцгүй хөгжиж буй орнуудад ойгоор бүрхэгдсэн газрын хэмжээ 2015 онд 17.0 хувь байснаа 2020 онд 16.6 хувь болж буурсан бол дэлхийн дундаж үзүүлэлт өөрчлөлтгүй байна.

261. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын биологийн төрөл зүйл, байгалийн баялгийн нөөцийг тогтвортой, шударга, тэгш байдлаар хамгаалж, эдийн засгийн хөгжил болон хүний сайн сайхан байдлыг дэмжихэд ашиглах ёстойг бид баталж байна. Энэ нь Биологийн төрөл зүйлийн тухай конвенцын¹⁵ гурван зорилго, мөн Күнмин-Монреалын дэлхийн биологийн олон янз байдлын хүрээний¹⁶ зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Тогтвортой хөгжлийн стратеги нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудад анхан шатны бүтээгдэхүүндээ нэмүү өртөг шингээх, бүтцийн эмзэг байдлаа бууруулах, үйлдвэрлэлийн чадавхаа нэмэгдүүлэхэд тус дөхөм үзүүлнэ.
262. Биологийн төрөл зүйлийн тухай конвенцын талуудын бага хурлын арван тавдугаар чуулганаас¹⁷ гаргасан шийдвэрийг бид сайшаан хүлээн авч байна. Уг шийдвэрээр Күнмин-Монреалын дэлхийн биологийн олон янз байдлын хүрээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, одоо байгаа дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Дэлхийн байгаль орчны сангийн хүрээнд тусгай итгэмжлэлийн сан байгуулахыг хүссэн бөгөөд уг сан нь хангалттай, урьдчилан таамаглах боломжтой, цаг тухайд нь нийлүүлэх хөрөнгийн хэрэгцээг харгалзан үзэж, хүрээг цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд чиглэнэ. Мөн бид Хүрээг хэрэгжүүлэхэд бүх холбогдох оролцогч талуудыг татан оролцуулахын чухлыг онцолж байна.

Зорилтууд:

- Күнмин-Монреалын дэлхийн биологийн олон янз байдлын хүрээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, далайд гарцгүй хөгжиж буй орнуудад биологийн төрөл зүйлийн хомсдолыг зогсоож, сэргээхэд чиглэсэн дэмжлэгийг мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдүүлэх.
- 2030 он гэхэд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын доройтсон эх газрын болон дотоод усны экосистемийг үр дүнтэйгээр

15 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гэрээний Цуврал, боть 1760, № 30619.

16 Нэгдсэн Үндэстний Байгаль орчны хөтөлбөр, баримт бичиг CBD/COP/15/17, шийдвэр 15/4, хавсралт.

17 Адил эх сурвалжид, шийдвэр 15/7.

сэргээж, биологийн төрөл зүйл, экосистемийн үйл ажиллагаа, экологийн бүрэн бүтэн байдал, холболтыг бэхжүүлэх.

Бид дараах арга хэмжээг авна:

263. Биологийн төрөл зүйлийн тухай конвенцын талуудын Күнмин-Монреалын дэлхийн биологийн олон янз байдлын хүрээг шударга, тэгш байдлаар хэрэгжүүлэх үүргийг бид дахин онцолж байна. Энэ нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хэрэгцээг хангах, мөн 2030 он гэхэд тэдгээр орнуудад биологийн төрөл зүйлийн хомсдолыг зогсоож, буцаан сэргээх зорилготой юм.
264. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын үндэсний биологийн төрөл зүйлийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэх, шинэ хүрээтэй нийцүүлэн хөрөнгө оруулалтыг дэмжих, бүх салбарын бодлогын уялдааг сайжруулах, хяналт, шинжилгээ, үнэлгээг бэхжүүлэх, нөөц татан төвлөрүүлэх стратегийг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэхээ бид амлаж байна.
265. Биологийн төрөл зүйлийн тухай конвенцын талуудын Конвенцын 20 дугаар зүйлд заасны дагуу, дотоод, олон улсын, төрийн болон хувийн бүх эх үүсвэрээс гаргах санхүүгийн нөөцийг мэдэгдэхүйц, шат дараатайгаар нэмэгдүүлэх, мөн чадавх бэхжүүлэх, техникийн болон шинжлэх ухааны хамтын ажиллагаа, технологид нэвтрэх ба түүнийг шилжүүлэх талаарх үүргээ бид дахин нотолж байна. Энэ нь Күнмин-Монреалийн дэлхийн биологийн олон янз байдлын хамрах хүрээг бүрэн хэрэгжүүлэхэд далайд гарцгүй хөгжиж буй орнуудад бүрэн дүүрэн оролцох боломжийг олгоно.

Тэргүүлэх чиглэл 5: Хэрэгжүүлэх арга хэрэгсэл

266. Дотоод, гадаад, улсын болон хувийн эх үүсвэр нь газар зүйн хувьд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын өсөн нэмэгдэж буй хөрөнгө оруулалт, зардлын хэрэгцээг хангахад хангалтгүй байгаа бөгөөд үүнд албан ёсны хөгжлийн түслэмж, гадаадын шууд хөрөнгө оруулалт, мөн хувийн шилжүүлэг болох гадаадад ажиллагсдын мөнгөн гуйвуулга болон хөрөнгийн үрсгал зэрэг олон улсын санхүүжилтээс хамаарч байгааг бид хүлээн зөвшөөрч байна.
267. Иймд газар зүйн хувьд далайд гарцгүй хөгжиж буй орнууд, дамжин өнгөрөх орнууд болон тэдгээрийн түншүүд энэхүү Хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд бүх эх үүсвэрээс нөөц бололцоог мэдэгдэхүйц нэмэгдүүлэх зорилгоор өөрчлөн шинэчлэх арга хэмжээ авах шаардлагатайг бид хүлээн зөвшөөрч байна.

I. Дотоод нөөц дайчлах

268. Дотоод нөөцийг дайчлах нь бүх улс орны эдийн засгийн хөгжлийн чухал бүрэлдэхүүн гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна. Газар зүйн хувьд далайд гарцгүй хөгжиж буй орнуудад эдийн засгийн суурь хумигдсан, амьжиргааны түвшний эдийн засаг давамгайлсан, татварын удирдлага ба татвар хураах чадавх сул, татвараас зайлсхийх болон хууль бусаар зугтах зэрэг хүчин зүйлс дотоод нөөцийг дайчлах үйл явцыг хязгаарлаж байна. Хүртээмжтэй, үр ашигтай татварын тогтолцоо болон газар зүйн хувьд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын институцийн чадавхыг бэхжүүлэх нь дотоод нөөцийг дайчлах боломжийг нэмэгдүүлэхэд зохих хувь нэмэр оруулна.
269. Газар зүйн хувьд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын дотоодын нийт хуримтлал нь 2021 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 24.1 хувьд хүрсэн боловч энэ нь дэлхийн дундаж болох 28 хувиас доогуур хэвээр байгаа нь хөгжлийн санхүүжилтийн хомсдол байсаар буйг илтгэж байна.

Зорилтууд:

- Газар зүйн хувьд далайд гарцгүй хөгжиж буй бүх оронд шаардлагатай тохиолдолд дотоодын нийт бүтээгдэхүүнд ногдох татварын орлогын хувь хэмжээг шат дараалан нэмэгдүүлэх.
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг конвенц¹⁸ болон бусад холбогдох хэрэгслийн дагуу хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох, түүний эх оронд нь буцаах чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг сайжруулах.
- Хууль бус санхүүгийн урсгалыг таслан зогсоох, түүнтэй тэмцэх чиглэлээр засгийн газар хоорондын зохицуулалтыг бэхжүүлэх.

Бид дараах арга хэмжээг авна:

270. Газар зүйн хувьд далайд гарцгүй хөгжиж буй орнууд цөөн төрлийн бүтээгдэхүүнээс хамаарах байдлыг бууруулахын тулд үйлдвэрлэл, үйлчилгээ, технологи зэрэг уламжлалт бус салбарыг дэмжиж, орлогын эх үүсвэрээ төрөлжүүлэхийг бид уриалж байна.
271. Олон улсын татварын хамтын ажиллагааг өргөжүүлж, татварын суурийн алдагдал болон ашиг шилжүүлэлтээс зайлсхийх орон зайг хаах чиглэлээр хүчин чармайлтаа нэмэгдүүлэхээ бид амлаж байна. Мөн газар зүйн хувьд далайд гарцгүй хөгжиж буй орнуудад татварын ил тод байдал болон мэдээлэл солилцооны олон улсын стандартыг нэвтрүүлэхэд туслах, жишээлбэл, автоматаар мэдээлэл солилцох шинэ олон улсын стандартыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг бид зорьж байна.
272. Газар зүйн хувьд далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг олборлох нөөцөө ил тод, хариуцлагатай, тогтвортой удирдлага бүхий тогтолцоогоор удирдах, олборлох салбарын зүгээс нийтийн орлогод шударгаар хувь нэмэр оруулах, татвар болон санхүүгийн урамшууллын бодлогыг дахин хянаж, нийтийн орлогыг дээд хэмжээнд хүргэхийг бид уриалж байна.

18 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гэрээний Цуврал, боть 2349, № 42146.

273. Газар зүйн хувьд далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг дотоод санхүүгийн гүнзгийрэлтийг нэмэгдүүлэх замаар дотоод нөөцийг дайчлах, мөн гадаадад байгаа иргэдийн хуримтлалыг татах (жишээ нь: диаспорагийн бонд, гадаад валютын хадгаламж, мөн гуйвуулгыг барьцаалсан хамтарсан зээл гэх мэт) боломжийг ашиглахыг бид уриалж байна.
274. Дижитал технологийн боломжийг ашигласан шинэ төрлийн санхүүгийн хэрэгслийг хөгжүүлэхийг бид уриалж байна. Энэ нь тогтвортой хөгжлийн зорилгыг үндэсний түвшинд хэрэгжүүлэхэд чиглэсэн дижитал санхүүжилтийн платформ, инновацлаг үйлчилгээ, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн цахимжилт болон олон нийтийн орлогын шинэчлэл зэргийг хамарна.
275. Санхүүжилтийн тогтолцоог, ялангуяа бичил, жижиг, дунд үйлдвэрлэл (түүнд эмэгтэй эзэдтэй аж ахуйн нэгжүүдийг оруулан)-ийг дэмжих катализатор үүрэгтэй механизмыг ашиглан, тогтвортой хувийн хөрөнгө оруулалтын үрсгалыг бий болгож, эдийн засгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, боломжит ирээдүйн хямрал, шокийн нөлөөг бууруулахыг бид зорьж байна.
276. Хууль бус санхүүгийн үрсгалтай тэмцэх, хөрөнгийг буцаан олгох, сэргээх чиглэлээр олон улсын хамтын ажиллагаа болон сайн туршлагыг бэхжүүлэхээ дахин амлаж байна. Мөн хөрөнгийн хулгай болон хууль бус санхүүгийн үрсгалд ээлтэй нөхцөлийг арилгахын төлөө ажиллах, авлига, хээл хахууль, мөнгө угаах зэрэг бүх хэлбэрийн гэмт хэргийг таслан зогсоох чиглэлийн үүргээ хэрэгжүүлэхээ бид дахин онцолж байна. Энэ хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг конвенц болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай конвенц¹⁹-д заасан олон улсын эрх зүйн хэм хэмжээг мөрдөнө.

¹⁹ Адил эх сурвалжид, боть 2225, № 39574.

II. Албан ёсны хөгжлийн тусламж болон гадаад санхүүжилтийн бусад эх үүсвэр

277. Албан ёсны хөгжлийн тусламж нь газар зүйн хувьд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын дотоод нөөцийг нөхөх чухал хэрэгсэл хэвээр байгаа бөгөөд эдгээр орнуудын эдийн засгийн хөгжилд албан ёсны хөгжлийн тусламж ихээхэн нөлөөтэй байгааг бид хүлээн зөвшөөрч байна.
278. Албан ёсны хөгжлийн тусламжийн нөөц цөөн тооны далайд гарцгүй хөгжиж буй орнуудад төвлөрч, бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад олон тооны далайд гарцгүй хөгжиж буй орнууд бага хэмжээний тусламж авч байгааг бид тэмдэглэж байна.
279. Уламжлалт болон шинэ эх үүсвэрүүдээр дамжуулан далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг дэмжих хөгжлийн санхүүжилтийн хэмжээг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх шаардлагатай. Үүнд хөнгөлөлттэй зээл, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар чанартай, найдвартай, тогтвортой, уур амьсгалын болон гамшигт тэсвэртэй дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэн хамруулж болно гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна.

Зорилтууд:

- Уламжлалт болон шинэлэг эх үүсвэрээр дамжуулан далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг дэмжих хөгжлийн санхүүжилтийн хэмжээг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх.
- Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хэрэгцээ, сорилтыг нийгэм, эдийн засаг, байгаль орчны хамгийн их үр өгөөжтэйгөөр шийдвэрлэхэд чиглэсэн банкны шаардлагад нийцэхүйц төслүүдийг боловсруулах, санхүүжилт татах чадавхыг нэмэгдүүлэх.

Бид дараах арга хэмжээг авна:

280. Хөгжлийн түншүүдийг, түүний дотор хөгжингүй орнуудыг, өөрсдийн албан ёсны хөгжлийн тусламжийн амлалтаа бүрэн болон цаг хугацаанд нь биелүүлэх, мөн энэхүү Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд газар зүйн хувьд далайд гарцгүй

хөгжиж буй орнуудын тусгай хэрэгцээ, сорилтыг харгалзан үзэж, албан ёсны хөгжлийн тусламжийг нэмэгдүүлэх хүчин чармайлтаа эрчимжүүлэхийг бид уриалж байна. Мөн буцалтгүй тусламж болон их хэмжээний хөнгөлөлттэй зээл эдгээр орнуудад онцгой ач холбогдолтой болохыг онцлон тэмдэглэж байна.

281. Санхүүгийн спекуляцид автсан түүхий эдийн зах зээлээс үүдэлтэй сөрөг нөлөөг бууруулахын тулд олон улсын хэмжээнд арга хэмжээ авах, үүнд спекуляцийн хэмжээг хязгаарлах журам бий болгох, үнийн савлагааг саармагжуулах шинэ санхүүгийн механизм бий болгохыг бид уриалж байна.
282. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад шинэлэг санхүүжилтийг нэмэгдүүлж, өмнөх тогтсон санхүүжилтийн механизмыг илүү үр ашигтайгаар ашиглах, үүнд хосолмол санхүүгийн хэрэгслийг ашиглах, мөн албан ёсны хөгжлийн тусламжийн ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд зориулсан хөрөнгийг үр дүнтэй ашиглахаа бид амлаж байна.
283. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг оролцуулан байгаль орчинд ээлтэй технологийг харилцан тохиролцсон нөхцөлөөр хөгжиж буй нийт орнуудад нутагшуулах явцыг хурдасгах шаардлагатай байгааг бид хүлээн зөвшөөрч байна. Мөн эдгээр орнууд дэлхийн уур амьсгалын сангуудаас нөөц хөрөнгө татах илүү хүртээмжтэй байх нөхцөлийг бүрдүүлэх арга замуудыг судлахыг уриалж, нэмэлт нөөц татах зорилгоор “ногоон бонд” болон бусад санхүүгийн хэрэгсэл гаргах боломжийг бид судална.
284. Хөгжлийн хамтын ажиллагаа болон төрийн санхүүжилтийн чанар, үр нөлөө, үр ашгийг сайжруулах хүчин чармайлтаа бид үргэлжлүүлнэ. Үүнд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын үндэсний тэргүүлэх чиглэлтэй дэмжлэгийг уялдуулах, салангид байдлыг бууруулах, тусламжийн уялдаагүй байдлыг арилгах үйл явцыг түргэсгэх зэрэг арга хэмжээнүүд орно.
285. Олон улсын болон бүс нутгийн хөгжлийн банкнуудыг өөрийн хүлээсэн үүргийн хүрээнд нэмэлт санхүүжилт татах, олгох

арга хэмжээг авахыг бид уриалж байна. Энэ нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх, дэдбүтцийн хөрөнгө оруулалтад шаардлагатай санхүүжилтийн хэмжээг хангах, холбогдох тээвэр, худалдааны холболтыг сайжруулахад чиглэнэ.

286. Олон улсын хөгжлийн банкнуудын хувийн хөрөнгө оруулалтыг татах үүргийг бид хүлээн зөвшөөрч, дэд бүтцийн хөгжилд зориулсан хөнгөлөлттэй санхүүжилтийг нэмэгдүүлэхийг уриалж байна. Мөн эдгээр банкнуудыг худалдааны санхүүжилтийн зөрүүг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор дижитал худалдааны санхүүжилтийг илүү хүртээмжтэй болгохыг дэмжинэ.
287. 2021 оны 8 дугаар сарын 23-нд батлагдсан 650 тэрбум ам.доллартой тэнцэх тусгай зээлжих эрхийн (SDR) хуваарилалтыг сайшааж, тусгай зээлжих эрх эсвэл түүнтэй тэнцэх хөрөнгийг дахин чиглүүлэхэд зориулсан 100 тэрбум ам.долларын амлалтад хүрсэнд бид талархал илэрхийлж байна. Мөн Олон Улсын Валютын Сангийн гишүүн хөгжиж буй орнуудын хэрэгцээнд нийцсэн ирээдүйн боломжуудыг судлахыг зөвлөж, хамгийн их хэрэгцээтэй орнууд, үүнд далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг хамруулан тусгай зээлжих эрхийг дахин чиглүүлэхийг яаралтай уриалж байна. Энэ хүрээнд холбогдох хууль эрх зүйн хүрээг хүндэтгэж, тусгай зээлжих эрхийн нөөцийн хөрөнгийн шинж чанарыг хадгалах болно. Мөн ирээдүйн тусгай зээлжих эрхийн хуваарилалт хамгийн их хэрэгцээтэй орнуудад, үүнд далайд гарцгүй хөгжиж буй орнуудад ашиг тусаа өгөх арга замыг судална.
288. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг тогтвортой хөгжлийн хүчин чармайлтаа ахиулах, шинэлэг санхүүжилтийн механизмуудад нэвтрэх, мөн банкны шаардлагад нийцэхүйц дэд бүтцийн төслүүдийг боловсруулах, хэрэгжүүлэхэд чиглэсэн техникийн, санхүүгийн болон чадавхыг бэхжүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэхээр шийдвэрлэж байна.

III. Гадаадын шууд хөрөнгө оруулалт

289. Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь хөрөнгө, технологи, зах зээлд нэвтрэх боломжийг олгох замаар газар зүйн хувьд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын тулгамдсан сорилтыг шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлж чадна гэж бид үзэж байна. Мөн эдгээр орнуудад гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахын зэрэгцээ түүнийг үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулах нь чухал болохыг бид онцолж байна.
290. COVID-19 цар тахлын дараах 2021 онд далайд гарцгүй хөгжиж буй орнууд руу чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал сэргэсэн хэдий ч, энэ сэргэлт нь дэлхийн болон хөгжиж буй орнуудын дунджаас доогуур түвшинд байгаад бид санаа зовниж байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт буурахад хүргэсэн хүчин зүйлсэд эдгээр орнуудын дэлхийн болон бүс нутгийн худалдааны сүлжээнд нэгдсэн байдал сул, хөрөнгө оруулалтын төлөөх өрсөлдөөн ихэссэн, үйлдвэрлэлийн хүчин чадлын хомсдол, хөрөнгө оруулалтын орчны дүрэм, журмууд сул байгаа зэрэг орно.
291. Эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэх, чанартай ажлын байр бий болгохын тулд, ялангуяа дэд бүтцийн салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг бид хүлээн зөвшөөрч байна.

Зорилтууд:

- Далайд гарцгүй хөгжиж буй орнууд руу чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын үрсгалыг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх.
- Одоогийн бүх хөрөнгө оруулалт дэмжих платформыг ашиглан далайд гарцгүй хөгжиж буй орнууд руу хөрөнгө оруулалтыг татах, үүнд хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагуудын хооронд түршлага солилцох, чадавх бэхжүүлэх, хөрөнгө оруулалтын бодлогын үнэлгээ хийх, "Хил хязгааргүй татварын байцаагчид" санаачилгатай хамтран шударга, ил тод орлого хураах тогтолцоог хангах арга хэмжээг дэмжих.

Бид дараах арга хэмжээг авна:

292. Далайд гарцгүй хөгжиж буй орнууд руу чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилго тавьж байна. Үүнд эдгээр орнуудын зам, төмөр зам, боомт зэрэг чухал тээврийн дэд бүтцийн хөгжүүлэлт болон олон төрлийн тээврийн (multimodal) системийг хамруулна.
293. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг экспортын чадамж бүхий, эдийн засгийн төрөлжилтийг дэмжих, гадаад валютын орлогыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг хурдасгах, мөн дунд болон өндөр технологийн салбаруудын хөгжил, дэлхийн нэмүү өртгийн сүлжээнд нэгдэхэд чиглэсэн салбаруудад чиглүүлэхийг бид дэмжиж байна.
294. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг хөрөнгө оруулалтад ээлтэй орчин бүрдүүлэх, өмчийн эрх, гэрээний хэрэгжилт, маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулах замаар тодорхой, тогтвортой хөрөнгө оруулалтын бодлого боловсруулахыг бид уриалж байна.
295. Олон улсын хамтын нийгэмлэгийг гадаадын шууд хөрөнгө оруулалтыг Тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцсэн, эдийн засагт эерэг нөлөө бүхий салбарууд болон төслүүдэд чиглүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бид уриалж байна.
296. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор хөрөнгө оруулалтын баталгааны механизмыг хөгжүүлэхээ бид амлаж байна.
297. Одоо байгаа бүх хөрөнгө оруулалтыг дэмжих платформыг ашиглан далайд гарцгүй хөгжиж буй орнуудад нэмэлт хөрөнгө татахыг бид зорьж байна. Үүнд хөрөнгө оруулалт дэмжих агентлагуудын хооронд туршлага солилцох, чадавх бэхжүүлэх зэрэг арга хэмжээг хамруулна. Мөн эдгээр орнуудын Засгийн газруудын чадавхыг бэхжүүлэхээ бид амлаж байна — үүнд гадаадын шууд хөрөнгө оруулалт татах, дотоодын хөрөнгө оруулалт дэмжих, аялал жуулчлал болон экспортын дэмжлэг үзүүлэх, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх чадавхыг нэмэгдүүлэхийг багтаана.

IV. Гадаадад ажиллагчдын мөнгөн гуйвуулга

298. Гадаадад ажиллаж буй иргэдийн мөнгөн гуйвуулга нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжилд чухал хувь нэмэр оруулдаг хувийн хөрөнгийн үрсгал бөгөөд бусад орлогын эх үүсвэрийг нөхдөг болохыг бид хүлээн зөвшөөрч байна. Мөн гуйвуулга нь бизнес эрхлэлтийг дэмжих чадамжтай болохыг тэмдэглэж байна.
299. Энэ гуйвуулга чухал үүрэгтэй гэдгийг онцолж байна — ядуурал, тэгш бус байдлыг бууруулах, хүйсийн тэгш байдлыг хангах, мөн үүнийг санхүүгийн хямралын үед эдийн засгийг тогтворжуулах, сөрөг цикл үүсгэхгүй байх үүрэгтэй гэж үзэж байна.
300. Технологийн дэвшлийг, түүний дотор дижитал шийдлийг, гуйвуулгын хүртээмж, ашиглалт, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор шинэлэг аргаар ашиглах нь нэн чухал болохыг бид хүлээн зөвшөөрч байна. Эдгээр нь гуйвуулгыг илүү хурдан, аюулгүй, хямд болгоход дэмжлэг үзүүлнэ.
301. Гуйвуулга нь жижиг аж ахуйн нэгжийг эхлүүлэх, өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлж, бичил, жижиг, дунд бизнесийн салбарыг бэхжүүлэн, суурь түвшний эдийн засгийн хөгжил, ажлын байр бий болгох, орлого нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулж байгааг бид онцлон тэмдэглэж байна.
302. 2014–2022 оны хооронд далайд гарцгүй хөгжиж буй орнууд руу чиглэсэн гуйвуулгын үрсгал 43 хувиар өссөн хэдий ч, түүний хуваарилалт эдгээр орнуудын хооронд жигд бус байгааг бид онцлон тэмдэглэж байна.

Зорилтууд:

- 2030 он гэхэд гадаадад ажиллагсдын мөнгөн гуйвуулгын гүйлгээний шимтгэлийг нийт дүнгийн 3 хувиас доош бууруулах.
- 5 хувиас дээш зардалтай гуйвуулгын сувгуудыг бүрэн халж устгах.
- Гуйвуулгатай холбоотой санхүүгийн үйлчилгээ нь эмэгтэй, эрэгтэй хүмүүст тэгш хүртээмжтэй байхыг хангах.

Бид дараах арга хэмжээг авна:

303. Далайд гарцгүй хөгжиж буй орнууд руу чиглэсэн гуйвуулгын зардлыг бууруулахын тулд санхүүгийн үйлчилгээний хүртээмж, ашиглалт, чанарыг сайжруулах чиглэлээр ажиллахаа бид амлаж байна. Энэхүрээнд Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сангийн санаачилгаар хэрэгждэг Гуйвуулга, хөрөнгө оруулалт ба хөгжлийн дэлхийн форум, мөн Санхүүгийн хүртээмжийн дэлхийн түншлэл зэрэг олон улсын үйл ажиллагааг дэмжиж байна. Эдгээр нь гуйвуулгын урсгалыг сайжруулж, зардлыг бууруулах зорилготой.
304. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад гуйвуулгыг боловсрол, эрүүл мэндийн салбарт чиглүүлэхийг бид дэмжиж байна. Энэ нь хүний хөгжлийн чадавхыг нэмэгдүүлж, хүлээн авагчдын хөдөлмөр эрхлэх боломжийг сайжруулахад хувь нэмэр оруулна.
305. Холбогдох оролцогч талуудыг газар зүйн хүчин зүйл болон санхүүгийн үйлчилгээнд хязгаарлагдмал нэвтрэх байдал зэргээс шалтгаалсан гуйвуулгын өндөр шимтгэлийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авахыг бид уриалж байна.
306. Санхүүгийн хүртээмжийг өргөжүүлэх, ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд банкны үйлчилгээнд хялбар нэвтрэх нөхцөлийг бүрдүүлэхийг бид амлаж байна. Энэ нь гуйвуулгын зардлыг бууруулах, мөн хүмүүсийг албан ёсны сувгаар гуйвуулга илгээж, хүлээн авахыг дэмжихэд тусална.
307. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын судалгааны төвийг гуйвуулгын талаарх мэдээлэл, статистикийн мэдээлэл цуглуулах, шинжилгээг сайжруулах, эдийн засгийн нөлөөллийг илүү сайн ойлгох, зохистой бодлого, стратеги боловсруулахад туслахыг бид уриалж байна.
308. Гуйвуулгыг урт хугацааны хөрөнгө оруулалт болгон ашиглахыг дэмжих урамшууллын хөтөлбөрийг бий болгохоо бид амлаж байна. Үүнд бичил зээлийн үйлчилгээ, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг, ялангуяа эмэгтэйчүүдийн эзэмшдэг болон удирддаг бизнесийг дэмжих санаачилгуудыг хамруулна.

309. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг гуйвуулгыг хялбарчлах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, мөн гуйвуулгын гүйлгээний аюулгүй байдлыг хангах тодорхой, дэмжих бодлого, зохицуулалтыг боловсруулахыг бид уриалж байна.

V. Өрийн дарамтаас чөлөөлөх болон хөнгөлөлттэй санхүүжилт

310. Гадаад зээл нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын санхүүжилтийн чухал эх үүсвэр гэдгийг бид хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд өндөр болон өсөж буй хүүгийн түвшин нь гадаад өрийн ачаалал ихтэй зарим далайд гарцгүй хөгжиж буй орнуудад өрийн тогтвортой байдлын хувьд өндөр эрсдэлийг үүсгэж байгаад санаа зовниж байна.
311. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын урт хугацааны өрийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэхийг бид зөвлөж байна. Үүнд өрийн санхүүжилт, өрийн дарамтаас чөлөөлөх, өрийн бүтцийн шинэчлэл болон зохистой өрийн удирдлагыг хослуулсан зохицуулсан бодлого хэрэгжүүлэх нь Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд эдгээр орнуудын чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэнэ.
312. Өрийн эрсдэлийн үнэлгээ хийсэн 22 далайд гарцгүй хөгжиж буй орноос 7 нь өндөр эрсдэлтэй, 4 нь аль хэдийн өрийн дарамтад орсон байгаад бид санаа зовниж байна.
313. Бүхэлд нь хамарсан цогц арга хэмжээний ач холбогдлыг бид хүлээн зөвшөөрч байна. Үүнд өрийн дарамтаас чөлөөлөх, зохистой өрийн удирдлага, хөнгөлөлттэй санхүүжилт, сайн засаглал, стратегийн хөрөнгө оруулалтыг уялдуулан хэрэгжүүлэх нь өрийн тогтвортой байдлыг сайжруулах, мөн далайд гарцгүй хөгжиж буй орнуудын тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжихэд чухал үүрэгтэй.

Зорилт:

- Өрийн дарамтад орсон эсхүл өндөр эрсдэлтэй далайд гарцгүй хөгжиж буй орнуудын өрийн асуудлыг шийдвэрлэж, далайд гарцгүй хөгжиж буй бүх орнуудын гадаад өрийг тогтвортой түвшинд хадгалах.

Бид дараах арга хэмжээг авна:

314. Өрийн дарамтаас чөлөөлөх арга хэмжээг, үүнд өрийн тэглэлт болон өрийн бүтцийн шинэчлэлийг, шаардлагатай тохиолдолд тус тус хэрэгжүүлэхийн ач холбогдлыг бид хүлээн зөвшөөрч байна. Энэ нь өрийн хямралыг урьдчилан сэргийлэх, удирдах, шийдвэрлэх хэрэгсэл болохын зэрэгцээ далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хөгжлийн хэрэгцээг харгалзан үзэх ёстой.
315. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг өрийн хямралаас үүдэх сөрөг нөлөөллийг бууруулах, макроэдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор өрийн түр хугацааны төлбөрийн зогсолтын тухай хэлэлцээрийг, хамгийн сүүлчийн арга хэмжээ болгон, хэрэгжиж буй олон улсын тогтолцооны хүрээнд, зээлдэгч болон зээлдүүлэгч талуудын хооронд тохиолдол бүрээр хэлэлцэн байгуулахыг бид дэмжиж байна.
316. Зээлдүүлэгч болон зээлдэгч талуудыг, тохирсон, ил тод, тохиолдол бүрийн онцлогт нийцсэн нөхцөлөөр, шинэ болон сайжруулсан өрийн хэрэгслүүдийг ашиглах боломжийг судлахыг бид уриалж байна. Үүнд өрийг хувьцаагаар солих (debt-for-equity) загвар, Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан төслүүдийн хүрээнд хэрэгжих өрийн солилцоо болон өрийн индексжүүлсэн хэрэгслүүд зэрэг орно.
317. Нэгдсэн Үндэстний Байгууллага, Дэлхийн Банкны бүлэг, Олон Улсын Валютын Сан, бүс нутгийн хөгжлийн банкууд зэрэг олон улсын байгууллагуудыг далайд гарцгүй хөгжиж буй орнуудын институцийн чадавхыг бэхжүүлэхэд нэмэлт санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлэхийг бид уриалж байна. Энэ нь өрийн тогтвортой байдлыг хангахын тулд өрийн удирдлагыг үндэсний хөгжлийн стратегийн салшгүй хэсэг болгон сайжруулах, ил тод, хариуцлагатай өрийн удирдлагын тогтолцоог дэмжих, өрийн дахин хэлэлцээ хийх чадавхыг нэмэгдүүлэх, мөн гадаад өртэй холбоотой шүүхийн маргаан болон зээлдэгч, зээлдүүлэгч талуудын өрийн мэдээлэл нийцүүлэлтийн асуудлаар хууль зүйн зөвлөгөө үзүүлэхэд чиглэнэ.

Эдгээр хүчин чармайлт нь Өрийн үйлчилгээний түр хугацааны зогсолтын санаачилгаас цааших өрийн зохицуулалтын нэгдсэн тогтолцоо (Common Framework for Debt Treatments beyond the DSSI)-ны хүрээнд өрийн тогтвортой байдлыг хангах болон хадгалахад чиглэнэ.

Хэрэгжилт, дагаж мөрдөх ба хяналт-шинжилгээ

318. Энэхүү Үйл ажиллагааны хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд үндэсний, дэд бүс нутгийн, бүс нутгийн болон дэлхийн түвшинд, үр дүнтэй дагаж мөрдөх, хяналт-шинжилгээний тогтолцоо зайлшгүй шаардлагатайг бид онцлон тэмдэглэж байгаа бөгөөд эдгээр нь Тогтвортой хөгжлийн зорилтууд зэрэг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй суурь баримт бичгүүдтэй бүрэн уялдах ёстой. Үндэсний, бүс нутгийн болон дэлхийн түвшний механизмууд нь харилцан бие биеэ нөхөж, бэхжүүлсэн байх ёстойг бид дахин нотолж байна.
319. Далайд гарцгүй хөгжиж буй орнууд, дамжин өнгөрөх улсууд болон хөгжлийн түншүүдийн хөгжлийн стратеги, бодлогын үндэсний манлайлал, өмчлөл нь хэрэгжилтийн бүхий л шатанд — хэрэгжилт, хяналт-шинжилгээ болон үнэлгээний үйл явцын туршид — баталгаажсан байх ёстойг бид онцолж байна.
320. Үндэсний, дэд бүс нутаг, бүс нутгийн болон дэлхийн түвшинд хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл явц нь тасралтгүй байх ёстойг бид онцлон тэмдэглэж байна. Энэ нь дамжин өнгөрөх улсууд, хөгжлийн түншүүд болон бусад холбогдох талуудтай нягт уялдаа холбоотой, хамтын ажиллагаатай хэрэгжих шаардлагатай. Энэхүү үйл явц нь авсан үүрэг амлалтуудаа хэрэгжүүлэх, түншлэлийг бэхжүүлэх, харилцан хариуцлагыг бүх түвшинд хангахад чиглэнэ.

I. Үндэсний түвшний үнэлгээ

321. Улс орнуудын тэргүүлж, удирдан явуулдаг, холбогдох бүх талуудыг бүрэн хамруулсан, Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг тогтмол, хүртээмжтэйгээр үнэлэхийг бид уриалж байна. Үндэсний парламент болон бусад төрийн

байгууллагууд эдгээр үйл явцад дэмжлэг үзүүлэхийг мөн уриалж байна.

322. Үндэсний түвшинд, далайд гарцгүй хөгжиж буй улс бүрийн Засгийн газар энэхүү Үйл ажиллагааны хөтөлбөрийн заалтуудыг өөрийн орны үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт болон НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээтэй уялдуулж нэгтгэсэн Үндэсний хэмжээний хэрэгжилтийн стратеги, төлөвлөгөө боловсруулах шаардлагатай.
323. Улс орны түвшинд хэрэгжиж буй хяналт-шинжилгээ, тайлагналын одоо байгаа тогтолцоог, үүнд Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, үндэсний тодорхойлсон хувь нэмэр болон НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ зэрэгт хамаарах тогтолцоог өргөжүүлж, энэхүү Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээнд хамруулах шаардлагатай бөгөөд энэ нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг бүгдийг нь хамрах ёстойг бид онцолж байна.

II. Бүс нутгийн түвшний үнэлгээ

324. Хэрэгжилтийг хянах болон үнэлгээний үйл явцыг бүс нутгийн болон дэд бүс нутгийн түвшинд хэрэгжүүлэх нь онцгой ач холбогдолтой. Учир нь дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагаа нь анхнаасаа хоёр талт, дэд бүс нутгийн болон бүс нутгийн түвшинд хэрэгждэг. Иймд бүс нутгийн болон дэд бүс нутгийн комисс, байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулахыг уриалж байна.
325. Бүс нутгийн улс орнуудыг хамруулсан үйл явцыг бид дэмжиж байна. Энэ нь үндэсний түвшний үнэлгээнд тулгуурлан хийгдэж, дэлхийн түвшний хэрэгжилтийг хянах болон хяналт-шинжилгээний үйл явц болох "Тогтвортой хөгжлийн асуудлаарх Өндөр түвшний улс төрийн форум"-д хувь нэмэр оруулах ёстой.
326. Бүс нутгийн комиссуудын хүрээнд бүрэн үйл ажиллагаатай, үр нөлөөтэй бүс нутгийн зохицуулалтын механизмуудыг бүрдүүлэх шаардлагатайг бид онцолж байна. Энэ нь Үйл

ажиллагааны хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

327. Бүс нутгийн комиссуудыг дэд бүс нутгийн болон бүс нутгийн хөгжлийн банкнууд, засгийн газар хоорондын байгууллагуудтай нягт уялдаатайгаар энэхүү шинэ Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар хоёр жил тутам бүс нутгийн хүрээнд үнэлгээ хийхийг бид уриалж байна. Түүнчлэн, тэдгээр нь хэрэгжилтийн талаар дүн шинжилгээ хийсэн тайлан гаргаж, холбогдох бүс нутгийн болон дэд бүс нутгийн байгууллагууд, хувийн хэвшлийг бүс нутгийн комиссын хуралдаанд идэвхтэй хамруулан оролцуулах ёстой.
328. Улс орнуудыг бүгдийг хамруулсан бүс нутгийн үйл явц нь үндэсний түвшний үнэлгээнд тулгуурлан дэлхийн түвшний хяналт-шинжилгээ, үнэлгээнд хувь нэмэр оруулах болно гэдгийг бид тэмдэглэж байна. НҮБ-ын бүс нутгийн комиссууд болон холбогдох агентлагууд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын тусгай хэрэгцээ, сорилтыг өөрсдийн үйл ажиллагааны нэг хэсэг болгон авч үзэж байх шаардлагатай.

III. Дэлхийн түвшний хэрэгжилт

329. Дэлхийн түвшинд бий болсон хэрэгжилт, хяналт-шинжилгээний механизмыг бэхжүүлж, сайжруулах шаардлагатай гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна. Энэ нь Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд цаг тухайд нь, үр дүнтэй хяналт тавихад чиглэнэ. Үүнд үндэсний, бүс нутгийн болон салбарын түвшинд бодлого, арга хэмжээг илүү нарийн тооцон дүгнэх, дэлхийн түвшинд хэрэгжилтэд үзүүлэх бодит дэмжлэгийг сайжруулах, холбогдох засгийн газар хоорондын үйл ажиллагаа болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын системийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, мөн далайд гарцгүй хөгжиж буй орнуудаас ирэх мэдээлэл, хяналт-шинжилгээг илүү өргөн бүтэцтэйгээр дэмжих зэрэг чиглэлүүдийг хамарна.
330. Шинжлэх ухаан болон бодлогын уялдаа холбоог бэхжүүлж, энэхүү Үйл ажиллагааны хөтөлбөрийн бүх тэргүүлэх чиглэлд нотолгоонд суурилсан хүчтэй хэрэгслийг бүрдүүлэхийг бид уриалж байна.

331. Ерөнхий Ассамблейг энэхүү Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр тусгайлан хэлэлцэх асуудлын хүрээнд хянахыг бид уриалж байна. Дэлхийн түвшний хэрэгжилтийг хянах болон үнэлгээ хийх үйл явц нь Ерөнхий нарийн бичгийн даргын жил бүрийн тайланд орно. Уг тайлан нь НҮБ-ын системийн байгууллагуудтай хамтран, үндэсний статистикийн байгууллагуудын гаргасан мэдээлэл, бүс нутгийн түвшинд цуглуулсан мэдээлэл болон Нарийн бичгийн дарга нарын газрын Эдийн засаг, нийгмийн асуудлын хэлтсийн Статистикийн хэлтсийн өгөгдөлд үндэслэн боловсруулагдана.
332. Бүх холбогдох НҮБ-ын бага хурал, үйл явц болон үндсэн баримт бичгийн хэрэгжилтийг хянах, үнэлгээний зохицуулалттай үр дүнтэй уялдаа холбоо тогтооно. Үүнд 2030 оны Хөгжлийн хөтөлбөр, Аддис-Абабагийн үйл ажиллагааны хөтөлбөр, Парисын хэлэлцээр, болон Сендайн гамшгийн эрсдэлийг бууруулах үндсэн баримт бичиг (2015–2030)-ийг багтаана.

IV. Үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэсний бодлогод тусгах нь

333. Далайд гарцгүй хөгжиж буй орнууд, дамжин өнгөрөх орнууд, хөгжлийн түнш орнууд болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын системийн байгууллагуудыг өөрсдийн үндэсний болон салбарын хөгжлийн стратеги, хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ болон стратегийн төлөвлөгөөндөө энэхүү Үйл ажиллагааны хөтөлбөрийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх зорилгоор тусгахыг бид уриалж байна. Далайд гарцгүй болон дамжин өнгөрөх хөгжиж буй орнуудыг, шаардлагатай нөхцөлд, үндэсний зохицуулах механизмыг байгуулахыг дэмжинэ.
334. Бүс нутгийн болон дэд бүс нутгийн байгууллагууд, тэр дундаа бүс нутгийн эдийн засгийн хамтын нийгэмлэгүүд болон бүс нутгийн хөгжлийн банкнуудыг энэхүү Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг өөрсдийн холбогдох хөтөлбөрүүдэд тусгахыг бид урьж байна.
335. НҮБ-ын Ерөнхий Ассамблей, Эдийн засаг, нийгмийн зөвлөл болон “Тогтвортой хөгжлийн асуудлаарх Өндөр түвшний улс төрийн форум”-ыг далайд гарцгүй хөгжиж буй орнуудын өмнө тулгараад буй тогтвортой хөгжлийн сорилтыг хэлэлцэхэд

хангалттай цаг хугацаа, анхаарал хандуулахыг бид урьж байна. Энэ нь оролцоог нэмэгдүүлж, авсан үүрэг амлалтыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах болно.

336. Нэгдсэн Үндэстний Байгууллагын сангууд, хөтөлбөрүүд болон бусад олон талт байгууллагуудын, тухайлбал Дэлхийн Банкны Групп, Олон Улсын Валютын Сан, бусад олон улсын санхүүгийн байгууллагууд болон Дэлхийн Худалдааны Байгууллагыг энэхүү Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах, мөн холбогдох хүлээсэн үүргийнхээ хүрээнд өөрсдийн ажлын хөтөлбөртөө тусгахыг бид уриалж байна. Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үндэсний, дэд бүс нутгийн, бүс нутгийн болон дэлхийн түвшний хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл явцад эдгээр байгууллагуудыг бүрэн хэмжээнд оролцохыг мөн урьж байна.

V. Нэгдсэн Үндэстний Байгууллагын системийг бүрэн дайчлан оролцуулах

337. Ерөнхий нарийн бичгийн даргаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын системийн холбогдох бүх байгууллагуудыг бүрэн дайчлан оролцуулах замаар Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн гүйцэтгэл, хяналт-шинжилгээ, үнэлгээг үндэсний, дэд бүс нутгийн, бүс нутгийн болон дэлхийн түвшинд уялдаа холбоотой хийхийг бид хүсэж байна.
338. Нэгдсэн Үндэстний Байгууллагын системийн Зохицуулагч байгууллагуудын дарга нарын Зөвлөл болон Тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан Нэгдсэн Үндэстний Групп зэрэг одоо байгаа зохицуулах механизмыг өргөнөөр ашиглах ёстой бөгөөд НҮБ-ын дээд түвшний зохицуулах механизмуудыг системийн хүрээнд Үйл ажиллагааны хөтөлбөрт боломжийг ашиглах, дэмжлэг бий болгох чиглэлд түлхүү анхаарахыг бид уриалж байна.
339. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын асуудлаарх агентлаг хоорондын зөвлөлдөх бүлгийг ахлан удирдаж буй НҮБ-ын Нэн бүүрай хөгжилтэй, Далайд гарцгүй хөгжиж буй болон Арлын жижиг хөгжиж буй орнуудын асуудал эрхэлсэн Дээд төлөөлөгчийн газарт талархал илэрхийлж, түүний үйл ажиллагааг цаашид бэхжүүлэхийг бид уриалж байна.

340. Тус Дээд төлөөлөгчийн газар болон Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад ажиллаж байгаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Суурин зохицуулагчийн газруудын нягт уялдаа холбоог бэхжүүлэхийг бид уриалж байна. Энэ нь Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал хэрэгсэл болох юм. Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын агентлагууд, тэр дундаа НҮБ-ын Суурин зохицуулагчид болон тэдгээрийн багууд илүү идэвхтэй үүрэг гүйцэтгэж, бүх оролцогч талуудыг дайчлан далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Засгийн газруудыг бүтцийн хязгаарлалтаас үүдэлтэй сорилтыг даван туулахад дэмжлэг үзүүлэх нь нэн чухал гэдгийг онцолж байна.

VI. Ерөнхий Ассамблейн даргын дэргэдэх Нэн буурай хөгжилтэй, Далайд гарцгүй хөгжиж буй болон Арлын жижиг хөгжиж буй орнуудын асуудлаарх Зөвлөхүүдийн зөвлөл болон далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Анд нөхдийн бүлгийн үүрэг

341. Ерөнхий Ассамблейн даргын дэргэдэх Нэн буурай хөгжилтэй, Далайд гарцгүй хөгжиж буй болон Арлын жижиг хөгжиж буй орнуудын асуудлаарх Зөвлөхүүдийн зөвлөлийг энд онцолж, далайд гарцгүй хөгжиж буй орнуудад зориулсан түршлага солилцох, нөөц дайчлах үйл ажиллагааг дэмжихийн тулд уг механизмыг үр нөлөөтэй ашиглахыг бид уриалж байна.
342. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Анд нөхдийн бүлгийн чухал үүргийг онцлон тэмдэглэж, Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд идэвхтэй оролцож, дэмжлэг үзүүлэхийг уриалж байна.

VII. Хөтөлбөрийн хэрэгжилтийн дэлгэрэнгүй замын зураг, хэрэгжилт болон хяналт-шинжилгээний хүрээг боловсруулах

343. Нэн буурай хөгжилтэй, Далайд гарцгүй хөгжиж буй болон Арлын жижиг хөгжиж буй орнуудын асуудал эрхэлсэн Дээд төлөөлөгчийн газрыг Үйл ажиллагааны хөтөлбөрийн хурдацтай хэрэгжилтийг хангах хамрах хүрээтэй замын зураг боловсруулж, оролцогч талуудын тодорхой үүрэг, хариуцлагыг тодорхойлохыг бид урьж байна. Энэ нь далайд

гарцгүй хөгжиж буй орнуудын төлөөх амлалт бодит үр дүнд хүрч, Үйлажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хөнгөвчлөх, мөн эдгээр орнуудыг Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

VIII. Үндэсний зохицуулагчдын сүлжээг бэхжүүлэх

344. Дээд төлөөлөгчийн газраас байгуулсан далайд гарцгүй хөгжиж буй орнуудын "Үндэсний зохицуулагчдын сүлжээ", тэдгээрийн тогтмол уулзалт, хэлэлцүүлэг чухал гэдгийг бид онцолж байна. Мөн далайд гарцгүй хөгжиж буй орнуудаас томилогдсон үндэсний зохицуулагчид нь Венийн үйл ажиллагааны хөтөлбөр болон Тогтвортой хөгжлийн зорилтуудыг үндэсний түвшинд хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож буйг тэмдэглэж байна. Дээд төлөөлөгчийн газрыг энэхүү үндэсний зохицуулагчдын сүлжээг цаашид бэхжүүлэх, жил бүрийн уулзалтыг зохион байгуулж, шинэ Үйл ажиллагааны хөтөлбөр болон Тогтвортой хөгжлийн зорилтуудыг үндэсний хөгжлийн үйл явцад тусгах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ хийх талаар туршлага, шилдэг арга хэрэгслийг хуваалцах, харилцан холбоотой байх, мөн хэрэгжилтийн боломжит санхүүжилт, бизнесийн загваруудын талаар илүү сайн ойлголттой байх боломж бүрдүүлэхийг бид уриалж байна.
345. Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр болон бусад холбогдох, хэрэгжиж буй болон ирээдүйн үйл явц хоорондын уялдаа холбоо, уялдааг хангахаар бид түүштай ажиллана.

IX. Үндэсний статистикийн чадавхыг бэхжүүлэх нь

346. Өндөр чанартай, цаг үеэ олсон, холбогдох, ангилсан, найдвартай мэдээлэл нь ахиц дэвшлийг хэмжих, хэнийг ч орхигдуулахгүй байх баталгааг хангахад зайлшгүй шаардлагатайг бид хүлээн зөвшөөрч байна. Ийм мэдээлэл нь бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад ашиглах гол түлхүүр юм.

347. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын үндэсний статистикийн байгууллагууд санхүү, техник технологийн хувьд дутмаг байгааг анхаарах ёстойг бид тэмдэглэж байна. Үүнээс шалтгаалан мэдээллийн хүртээмж хомс, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо сул байгаа нь бодит хэрэгжилт болон хяналтын үр нөлөөг бууруулж байна. Найдвартай, баталгаатай өгөгдөл дутмаг байх нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын тусгай нөхцөл байдлыг олон улсын тавцанд хангалттай хамгаалах, сурталчлах үйл ажиллагаанд ч саад болж байна.
348. Хөгжиж буй орнуудад, тэр дундаа далайд гарцгүй хөгжиж буй орнуудад чадавх бэхжүүлэх дэмжлэгийг эрчимжүүлж, орлого, хүйс, нас, арьс өнгө, угсаа, шилжилт хөдөлгөөний байдал, хөгжлийн бэрхшээл, газарзүйн байршил болон тухайн улсын нөхцөлд хамаарах бусад шинжээр ангилсан өндөр чанартай, цаг үеэ олсон, найдвартай мэдээллийн хүртээмжийг мэдэгдэхүйц нэмэгдүүлэхээ бид амлаж байна.

X. Сэдэвчилсэн үнэлгээ болон шинжилгээний ажил хийх нь

349. Нэн буурай хөгжилтэй, Далайд гарцгүй хөгжиж буй болон Арлын жижиг хөгжиж буй орнуудын асуудал эрхэлсэн Дээд төлөөлөгчийн газарт Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн ахиц дэвшлийг, шаардлагатай тохиолдолд, хөндлөнгийн болон сэдэвчилсэн байдлаар үнэлэхийг хүсэж байна.
350. Дээд төлөөлөгчийн газар нь Үйл ажиллагааны хөтөлбөрийн дэлхийн түвшний хяналт-шинжилгээ, үнэлгээнд агуулгын уялдаа бүхий дэмжлэг үзүүлэх ажлыг дараах байдлаар үргэлжлүүлнэ:
- (а) Засгийн газрууд, НҮБ-ын системийн агентлагууд, иргэний нийгмийн байгууллагууд болон бусад холбогдох оролцогч талуудаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн үндэсний түвшинд хэрэгжсэн арга хэмжээнд дүн шинжилгээ хийх;
 - (б) Холбогдох олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын засгийн газар хоорондын түвшний бодлогын хөгжлийн чиг хандлагыг хянах;

- (в) НҮБ-ын системийн байгууллагууд болон бусад холбогдох олон улсын болон бүс нутгийн байгууллагууд, мөн далайд гарцгүй хөгжиж буй орнууд дахь НҮБ-ын Суурин зохицуулагчидтай агуулгын холбоо, уялдааг хадгалах;
 - (г) Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад Ерөнхий нарийн бичгийн даргаас үзүүлэх дэмжлэгийн хүчин чармайлтад туслалцаа үзүүлэх;
 - (д) Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын дэлхийн болон салбарын түвшний хяналт-шинжилгээг дэмжих;
 - (е) Үндэсний, бүс нутгийн зохицуулагчдын системтэй нягт хамтран ажиллаж, тэдгээрийг Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үндэсний бодлогод тусгах, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл явцад бүрэн оролцуулах.
351. Дээд төлөөлөгчийн газар нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудад хамааралтай олон улсын бодлогын хөгжлийн чиг хандлагыг, тэр дундаа дэлхийн түвшний гол бага хурал, чуулга уулзалтын үр дүнг хянан, Үйл ажиллагааны хөтөлбөрийг үр дүнтэй, цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд чиглэсэн сурталчилгаа, мэдээллийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
352. Нэгдсэн Үндэстний Байгууллагын системийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын удирдах зөвлөлд нь өөрсдийн хүлээсэн үүргийн хүрээнд, шаардлагатай гэж үзвэл, Үйл ажиллагааны хөтөлбөрийн салбарын болон сэдэвчилсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг явуулах ёстой.
353. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төвийг бэхжүүлж, түршлага, мэдлэг, арга зүйг хуваалцах, мөн Үйл ажиллагааны хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлүүдийн сэдэвчилсэн хүрээнд судалгаа, шинжилгээний ажлыг хэрэгжүүлэхийг бид уриалж байна.

XI. Нэн буурай хөгжилтэй, Далайд гарцгүй хөгжиж буй болон Арлын жижиг хөгжиж буй орнуудын асуудал эрхэлсэн Дээд төлөөлөгчийн газрын үүрэг

354. Нэн буурай хөгжилтэй, Далайд гарцгүй хөгжиж буй болон Арлын жижиг хөгжиж буй орнуудын асуудал эрхэлсэн Дээд төлөөлөгчийн газар дараах чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд үйл ажиллагаагаа бэхжүүлэх ёстой:

- (а) Ерөнхий Нарийн Бичгийн даргад системтэй, үр нөлөөтэй хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд болон Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хамаарах Нэгдсэн Үндэстний Байгууллагын системийн бүх байгууллагуудыг бүрэн дайчлан оролцуулах, зохицуулахад туслалцаа үзүүлэх. Энэ хүрээнд мэдээлэл, өгөгдөл ашиглан 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан улс, бүс нутаг болон дэлхийн түвшинд Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн уялдаа холбоотой хяналт-шинжилгээ, үнэлгээг дэмжинэ;
- (б) Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн олон улсын дэмжлэг, нөөцийг дайчлах үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх;
- (д) Нэгдсэн Үндэстний Байгууллагын системийн холбогдох байгууллагууд болон бусад оролцогч талууд – тухайлбал парламент, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдтэй хамтран далайд гарцгүй хөгжиж буй орнуудын асуудлаар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, сурталчилгаа, мэдээллийн ажлыг эрчимжүүлэх;
- (е) Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын бүлгийн зөвлөлдөх уулзалтууд болон бусад засгийн газар хоорондын хурал, бага хуралд оролцоход бодит агуулгын дэмжлэг үзүүлэх зорилгоор судалгаа, шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх. Энэ нь шинжлэх ухаанд суурилсан, нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргалтыг дэмжиж, шинэ болон гарч буй сорилт, боломжийг харгалзан үзэхэд чиглэнэ. Мөн НҮБ-ын Ерөнхий Ассамблей, Эдийн засаг, нийгмийн

зөвлөл, “Тогтвортой хөгжлийн асуудлаарх өндөр түвшний улстөрийн форум” болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын системийн Зохицуулагч байгууллагуудын дарга нарын зөвлөлд далайд гарцгүй хөгжиж буй орнуудтай холбоотой асуудлаар дэмжлэг үзүүлэх, хэлэлцүүлэг, шинэлэг сэтгэлгээг урамшуулах, цаашдын хамтын ойлголцлыг бэхжүүлэх, Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд чиглэсэн хүчин чармайлтыг зохицуулахад хувь нэмэр оруулах зорилготой байна.

355. Дээд төлөөлөгчийн газрын үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх, далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг дэмжихэд чиглэсэн чадавх, үр нөлөөг нь бэхжүүлэх, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын системийн эдгээр орнуудад үзүүлэх дэмжлэгийн үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Ерөнхий Нарийн Бичгийн даргаас гишүүн орнууд болон холбогдох төрөлжсөн байгууллагууд, сангууд, хөтөлбөрүүд, бүс нутгийн комиссуудтай зөвлөлдөн, НҮБ-ын системийн хүрээнд хийгдсэн ажлыг харгалзан судалгаа, дүн шинжилгээ хийж, санал, зөвлөмж бүхий тайланг Ерөнхий Ассамблейн 80 дугаар чуулганд өргөн мэдүүлэхийг хүсэж байна.

XII. Дунд хугацааны дүн шинжилгээ болон Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын асуудлаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагын дөрөвдүгээр бага хурал

356. Ерөнхий Ассамблейг 2029 онд Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг дүгнэх өндөр түвшний хамрах хүрээтэй дунд хугацааны үнэлгээг зохион байгуулах боломжийг авч үзэхийг уриалж байна. Мөн уг хөтөлбөрийн хэрэгжилтийг цогц байдлаар үнэлэх, цаашдын арга хэмжээний талаар шийдвэр гаргах зорилгоор 2034 онд Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын асуудлаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагын дөрөвдүгээр бага хурлыг зохион байгуулах асуудлыг авч үзэхийг уриалж байна.

**“ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭ, ЭМЗЭГ БАЙДАЛ БОЛОН
СОРИЛТУУДЫГ ГАЗАРЗҮЙН БАЙРШЛЫН
ХЯЗГААРЛАЛТ, АЛСЛАГДМАЛ БАЙДАЛ,
ГАРЦГҮЙ БАЙДЛААС ҮҮДЭН ЦОГЦ, УЯЛДАА
ХОЛБООТОЙ БАЙДЛААР ШИЙДВЭРЛЭХ
НЭГДСЭН ЗОРИЛТОД ТУЛГУУРЛАЖ
БАЙНА...”**

– ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР



НҮБ-ын Нэн буурай хөгжилтэй, Далайд гарцгүй
хөгжиж буй болон Арлын жижиг орнуудын асуудал
эрхэлсэн Дээд төлөөлөгчийн газар

WWW.UN.ORG/OHRLLS



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦАА



НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ
БАЙГУУЛЛАГА
МОНГОЛ УЛС



INTERNATIONAL
THINK TANK FOR
LLDC



Европын Холбоо
санхүүжүүлэв

Энэхүү хэвлэлийн агуулгыг Зөвлөх компани бүрэн
хариуцах ба Европын Холбооны албан ёсны байр
суурийг илэрхийлээгүй болно.